БАГАНУУР ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

# 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

"Ёс зүй, сахилга, хариуцлага, хяналт, бүтээмжийг дээшлүүлэх" жил




7021 0021 portal.ndaatgal.mn Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар

БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН
2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2026 оны 06 дугаар сарын 12 Багануур дүүрэг

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ***Стратегийн төлөвлөлгөөний зорилго 1:*** Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, гадаад, дотоод харилцааг өргөжүүлж, ажил олгогч, даатгуулагчтай хамтран ажиллах; | | | | | | | |
| ***Зорилт 1.*** Нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар судалгаа хийж, санал боловсруулах | | | | | | | |
| 1.1. | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой батлагдсан дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах; | - | Хэрэгжүүлэх заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | 9 | 25 | Тайлант онд дээд газраас ирүүлсэн 25 эрхзүйн актыг хүлээн авч, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2026 оны эхний хагас жилийн байдлаар тогтоол шийдвэрийн хэрэгжилт 93.2 %-тай байна. | 93.2 |
| 1.2. | Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах | - | Батлагдсан төлөвлөгөө | 1 | 1 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/02 дугаар тушаалаар баталсан Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн хуваарьт мөн газрын даргын 2026 оны 02 дугаар сарын 26 өдрийн А/51 дүгээр тушаал, 2026 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/93 дугаар тушаал, 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/138 дугаар тушаалаар тус тус орсон өөрчлөлтийг тухай | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүр хүлээн авч, мөрдөн ажиллаж байна. | |
| 1.3. | Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль, НДЕГ-ын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах | - | Батлагдсан төлөвлөгөө | 1 | 1 | НДЕГ-ын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан хуваарь нь энэ оны эхний хагас жилийн байдлаар НДЕГ-ын даргын 2026 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн А/31 дүгээр тушаал, 2026 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/136 дугаар тушаалаар тус тус шинэчлэгдсэн байна. Шинэчилсэн төсвийн хуваарийг мөрдөн ажиллаж байна.<br>Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдлөг болгон 2026 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үйл ажиллагааны зардалд 345,2 сая төгрөгийг хөтөлбөр, арга хэмжээнд тусгасан эдийн засгийн ангилал, зориулалтын дагуу зарцууллаа. Энэ нь тайлант үеийн зардлын 362,8 сая төгрөгийн төсвийн 95,1%-ийг эзэлж байна. | 100 |
| 1.4. | “Нийгмийн даатгалын хамралтын 2026 оны төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах; | - | Албан журмын даатгуулагчдын тоо, хувь | 6,986<br>91,8% | 7,096<br>100% | "Хуулийн этгээд шинээр бүртгүүлж байгаа иргэдэд зориулан НДЕХ-ийн 20.1, Зөрчлийн тухай хуулийн 10.17.1 дэх заалт, харьяалах Нийгмийн даатгалын байгууллагад нийгмийн даатгалын шимтгэл | 137.7 |
| | | | Сайн дурын даатгалд хамрагсадын тоо, хувь | 960<br>86,1% | 1295<br>100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөгчөөр бүртгүүлэх зөвлөмж бүхий зурагт хуудас (постер)-ыг бэлтгэн, дүүргийн СТСХ, Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэс, нотариатч болон цахимаар байршуулж, зарим газрын удирдлага, албан хаагч нартай ажил хэргийн уулзалт хийж ажилласнаар тайлант хугацаанд шинээр 41 ажил олгогч хамруулж 107.7 хувийн биелэлттэй. Албан журмын даатгуулагч өссөн дүнгээр хагас жилд 60 даатгуулагч шинээр хамруулахаас тайлант хугацаанд нийт 72 даатгуулагч хамруулж 120% биелэлттэй байна. | |
| | | | Малчдын хамралтын тоо, хувь | 172<br>103,6% | 207<br>100% | Дүүргийн бүх хороодод 2026 оны 02 дугаар сард 03/23, 05 дугаар сард 03/79 дугаартай “Хамтран ажиллах тухай” албан бичиг илгээж малчин, 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/, гурав хүртэлх насны хүүхдээ асарч буй эх, хөдөлмөрийн насны ажил хөдөлмөр эрхлээгүй иргэд болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн судалгаа авав.<br>Судалгааг авч нэгтгэн, түүнд үндэслэн нийгмийн даатгалын мэдээллийн сангаас шүүлт хийж, зорилтот бүлгийн иргэдийг тодорхойлсоноор сайн дурын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | даатгалд хамрагдвал зохих иргэдтэй уулзах, утсаар ярих зэргээр мэдээлэл хүргэж, зөвлөгөө өгөв. Ингэснээр 736 хүнийг сайн дураар, үүнээс шинээр 208 хүн даатгуулсанаас малчин, туслах малчин 40, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх 12, 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/ 8, энгийн 148 даатгуулагч байна. | |
| ***Стратегийн төлөвлөгөөний зорилго 2:*** Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэн сангийн орлогыг бүрдүүлэн нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тогтвортой, бие даасан найдвартай байдлыг хангах замаар сангийн зарлагын гүйцэтгэлийг хангах, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал, хөнгөлөлт, чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд олгох, хяналт шалгалт, шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах; | | | | | | | |
| ***Зорилт 3.*** Нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, хамралтыг нэмэгдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилт, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд олгох, төсвийн гүйцэтгэлийг хангах, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах | | | | | | | |
| 3.1. | Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хүрээнд сан тус бүрээр даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хуульд заасан хугацаанд олгох ажлыг зохион байгуулах; | | Төсвийн зардлыг сан тус бүрээр хэтрүүлээгүй байна. | ТДС-61,424 сая ТМЖ-2,957 сая ҮОМШӨ-2,660 сая АДС-1,716 сая | ТДС-69,002 сая ТМЖ-3,276 сая ҮОМШӨ-3,557 сая АДС-1,692 сая | Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг чанд мөрдөж ажилласанаар 2026 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 32,742.6 сая төгрөгийн зардлын батлагдсан төсвөөс 31,964.9 сая төгрөг зарцуулж гүйцэтгэл 97.62 хувьтай, сан тус бүрийн зардал хэмнэлттэй байна. | 100 |
| 3.2. | Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийг мэдээлэх; | | Мэдээлсэн тоо | 12 | 5 | Нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг оны эхний 5 сард сар бүр хугацаанд нь гарган Нийгмийн даатгалын ерөнхий | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | газарт илгээв. | |
| 3.3. | Нийгмийн даатгалын байгууллагын төсвийн гүйцэтгэлийн дүнг мэдээлэх; | | Мэдээлсэн тоо | 12 | 5 | Байгууллагын үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийг Greenfinance програмаар боловсруулж, сар бүрийн эхэнд сарын мэдээ, тайланг 2 төрлийн маягтаар үнэн зөв, бүрэн гүйцэд бэлтгэж, нягтлан шалгаж, баталгаажуулан, НДЕГ-т илгээж байна. | 100 |
| 3.4 | Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны төсвийг зориулалтын дагуу зарцуулах; | | Өр авлагын хувь | 100% | 100% | Тус газрын үйл ажиллагааны төсвийг тухайн сарын мэдээ тайлангаар гарсан байдалтай уялдуулан, төсвийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй, төсвийн хэтрэлтгүй ажиллаж байна. Төсөв хүрэлцэхгүйн улмаас 2026 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийгмийн даатгалын шимтгэлд 11 600,0 мянга, бичиг хэргийн зардалд 313,7 мянга, бага үнэтэй, түргэн элэгдэх зүйл, ахуйн эд зүйлсийн зардалд 299,0 мянга, харуул хамгаалалтын зардалд 237,5 мянга нийт 12450,2 мянган төгрөгийн өглөг үүсээд байна. | 100 |
| 3.5. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах; | | Тайлагнасан тоо | 4 | 1 | Нийгмийн даатгалын сангийн 1-р улирлын төсвийн гүйцэтгэлийн тайланг тогтоосон хугацаанд нь үнэн зөв гарган, НДЕГ-т хүргүүлэв. Тайлант оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гаргах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.6. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар зөрчилгүй ажиллах; | | Дүгнэлтийн хувь | “Өөрчлөлтгүй” | “Өөрчлөлт гүй” | Тус газрын 2025 оны Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК гүйцэтгэж, "өөрчлөлтгүй" дүгнэлт авлаа. | 100 |
| 3.7. | Нийгмийн даатгалын сангийн бүртгэлийг SICOS системээр тухай бүр үнэн зөв хөтлөх; | | Систем хөтлөлтийн хувь | 100% | 100% | Сангийн бүртгэл, гүйлгээг өдөр бүр SICOS систем дээр үнэн зөв бүртгэж ажиллаж байна. | 100 |
| 3.8. | Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах; | | Тайлагнасан тоо | 4 | 1 | Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайланг Greenfinance програмаар боловсруулж, сар, улирлаар төсвийн гүйцэтгэлийг гарган, тогтоосон хугацаанд, үнэн зөв тайлагнаж, НДЕГ-т тухай бүр илгээж байна. Мөн гүйлгээ тус бүрийн анхан шатны баримтын бүрдлийг нягтлан шалгаж, бүрдэл хангасан баримтаар ажил гүйлгээг бүртгэж байна. | 100 |
| 3.9. | Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитаар зөрчилгүй ажиллах; | | Дүгнэлтийн дүн | “Өөрчлөлтгүй” | “Өөрчлөлт гүй” | Тус газрын 2025 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК гүйцэтгэж “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгч, Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2026 оны 02 дугаар сарын 286 тоот албан бичгээр дүгнэлтийг хүргүүлсэн байна. | 100 |
| 3.10. | Нийгмийн даатгалын байгууллагын бүртгэлийг GREENFINANCE системээр тухай бүр үнэн зөв хөтлөх; | | Систем хөтлөлтийн хувь | 100% | 100% | Тайлант хугацаанд finance.gov.mn программаар нийт 191 удаагийн 345,2 сая төгрөгийн зарлагын гүйлгээ | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хийж, ehuulga-аар гарсан зарлагын жагсаалтаар анхан шатны баримтад үндэслэн GREENFINANCE програмаар бүртгэн, мэдээ, тайланг гаргаж, мэдээ тайланг гарын үсэг зуруулан, тэмдэг дардасаар баталгаажуулж, НДЕГ-т хүргүүлэн ажиллаж байна. Удирдлагыг санхүүгийн мэдээллээр ханган, шийдвэр гаргах, дүгнэлт, харьцуулалт хийх боломжийг бүрдүүлэхэд анхааран ажиллав. | |
| 3.11. | Нийгмийн даатгалын төвлөрсөн харилцах дансны орлогыг 7 хоног бүр төвлөрүүлэх; | | Төвлөрүүлэл тийн хувь | 100% | 100% | Тус газрын арилжааны 4 банкин дахь нийгмийн даатгалын сангийн төвлөрсөн харилцахын дансны орлогыг өдөр бүр, төрийн сан банкин дахь төвлөрсөн харилцах дансны орлогыг тухай бүр НДЕГ-ын дансанд төвлөрүүлж, тайлант хугацааны эцэст төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын төв сан хариуцсан ахлах мэргэжилтэнтэй тооцоо нийлж, баталгаажуулан ажиллаж байна. | 100 |
| 3.12. | Нийгмийн даатгалын сангийн бусад өглөг, авлагыг барагдуулах; | | Өглөг, авлагыг барагдуулсан хувь | 100% | 100% | 2026 оны 5 дугаар сарын байдлаар шинээр үүссэн 2,856.3 сая төгрөгийн авлагыг бүртгэж, 2,855.6 сая төгрөгийн авлага хаагдсан байна. Үүнээс 9 даатгуулагчтай холбоотой 4.75 сая төгрөгийн авлагаас | 55 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 4,3 сая төгрөгийг барагдуулж 0,45 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой авлага буюу банк хоорондын үйлчилгээний хөлс, багцын нэхэмжлэлийг тухай бүр хааж, үнэн зөв бүртгэн, тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан. Өмнөх онуудад үүссэн бусад авлага, өглөгийг барагдуулах чиглэлээр эзэн холбогдогчийг тогтоох, бүртгэлийг залруулах зэргээр шат дараатай ажлуудыг хийж байна. Барагдуулалт 91%-тай байна.<br><br>2025 оны байдлаар шимтгэлийн өртэй 2 ажил олгогчийн 39.8 мянган төгрөгийн улсын байцаагчийн актыг барагдуулаагүй тайлант хугацаанд 10 ажил олгогчийн 1,700.6 мянган төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоож, 1,475.9 мянган төгрийг барагдуулсан байна. Улсын байцаагчийн актын барагдуулалт 85.4%-тай байна.<br><br>Оны эхний үлдэгдэлтэй тэтгэвэр тогтоолгосон 34 тэтгэвэр авагчийн 532,037.9 мянган төгрөгийг тэтгэврийн даатгалын санд буцаан төлүүлэхээр тогтоосон улсын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байцаагчийн актын үлдэгдэлтэй байна. Тайлант хугацаанд 47 тэтгэвэр авагчид дутуу олгосон 37,115.2 мянган төгрөгийн акт тогтоогдож, бүрэн олгож барагдууллаа.<br><br>Нийт 569,153.1 мянган төгрөгийн улсын байцаагчийн актын авлагаас 37,832.4 мянган төгрөг барагдсан байна. Үүнээс: 20 тэтгэвэр авагчид холбогдох 409,822.98 мянган төгрөгийн авлага нь Эрүүгийн хэрэг үүсгэн шалгагдаж байгаа тул актын барагдуулалтыг түр зогсоосон байна. Барагдуулалт 23,74%-тай байна.<br><br>Оны эхний үлдэгдэлтэй жирэмсэн, амаржсаны тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмж илүү олгосон акт төлбөр 32,890.6 мянган төгрөгийн актын үлдэгдэлтэй байснаас тайлант онд жилгүйдлийн тэтгэмж илүү олгосон 8 даатгуулагчид 4,687.9 мянган төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоогдож, 6,758.99 мянган төгрөгийг барагдуулж, актын барагдуулалт 18%-тай байна.<br><br>Дотоод хяналт шалгалтаар тогтоосон 6 даатгуулагчтай холбоотой 15,404.43 мянган | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөгийн улсын байцаагчийн актыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. | |
| 3.13. | Арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний хэрэгжилтийг хангах; | | Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Тус газартай хамтран ажиллах гэрээтэй ХААН, ХАС, Төрийн, Голомт банктай хамтран ажиллах гэрээний заалтыг үйл ажиллагаандаа мөрдөн, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Гэрээний үүргийн биелэлтийг жилийн эцсээр дүгнэхэд танилцуулах асуудлыг анхааран ажиллаж байна.<br><br>Тайлант хугацаанд нийт 29 удаагийн тэтгэвэр олголтын файл илгээж, банк тус бүрээс ирүүлсэн нийт 5 удаагийн 29,427.67 сая төгрөгийн тэтгэвэр олголтын хаалтын файлыг системд уншуулж, гүйцэтгэлийг баталгаажуулсан.<br>Өр авлага барагдуулахад арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу 3 тэтгэвэр авагчийн илүү олгогдсон 33.2 сая төгрөгийг барагдуулах хүсэлт илгээж 14.4 сая төгрөгийг сангийн харилцах дансанд шилжүүлсэн боловч ХААН банк гэрээний үүргээ биелүүлээгүйгээс 18.9 сая төгрөг шийдвэрлэгдээгүй байна. | 100 |
| ***Зорилт 4.*** Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулж, сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1. | Төрийн өмчийг эзэмшүүлэх 2025 оны гэрээ дүгнэлт, 2026 оны гэрээний хэрэгжилтийг хангах; | | Гэрээний хэрэгжилтийн үнэлгээ | “Хангалттай” | “Сайн” | Тайлант хугацаанд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас гэрээ дүгнээгүй байна. | - |
| 4.2. | Нийгмийн даатгалын сангийн болон урсгал үйл ажиллагааны зардлын батлагдсан төсвийн хүрээнд худалдан авалтыг журмын дагуу зохион байгуулах; | | Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Урсгал үйл ажиллагааны зардлын батлагдсан төсвийн хүрээнд 2026 оны бараа үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө гарган, газрын даргаар батлууллаа. Батлагдсан төлөвлөгөөний дагуу гэрээтэй харилцагчдаас бараа бүтээгдэхүүнийг худалдан авч, санхүүгийн анхан шатны баримтын бүрдлийг зохих ёсоор хангуулан, бүртгэлд тусгаж, тайлан мэдээг бэлтгэн ажиллаж байна. | 100 |
| 4.3. | Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын хэрэгжилтийг хангах; | | Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Тооллогын дүн гарсаны дараа актлах, дахин үнэлэх хөрөнгийн санал авч, актлах болон дахин үнэлүүлэх хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хүргүүлж, шийдвэр ирсэний дараа хөрөнгийн хөдөлгөөнийг бүртгэлд тусгахаар ажиллаж байна. | 100 |
| 4.4. | Хөрөнгийн тооллогыг хийж, дүнг ирүүлэх; | | Тооллогын дүнгийн тоо | 2 | 2 | Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн цахим системийн эд хөрөнгийн тооллогын комисс бүртгэх цэсээр тооллогын комиссын бүрэлдэхүүний мэдээллийг бүртгэн, эрх нээлгүүлэв. Тайлант оны эхний хагас жилийн тооллогыг явуулах ажлын хэсгийг тус газрын даргын 2026 оны А/11 дүгээр | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тушаалаар томилууллаа. | |
| 4.5. | Өмч хамгаалах байнгын комиссын үйл ажиллагааны журмыг мөрдөх; | | Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/27 тоот тушаалаар 2025 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг 2026 оны 01 дүгээр сарын 7-ны өдрөөс өмнө хийж гүйцэтгэсэн.<br><br>Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар 2026 оны улсын тооллогын комисс байгуулж одоогоор байгууллагын ажилтан албан хаагчдын өмчийг бүртгэлтэй тулган тоолж эхэлсэн байна. | 100 |
| ***Зорилт 5.*** Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаатай холбогдолтой бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, биелэлтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын төлөвлөлт, зарцуулалт, нягтлан бодох бүртгэлийн тайлагналтад дотоод аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, хэрэгжилтийг хангах; | | | | | | | |
| 5.1. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, шилэн дансны цахим хуудаст нийгмийн даатгалын сан, байгууллагын санхүү үйл ажиллагааны мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, бодитой бүрэн мэдээлж, мэдээлэл байршуултад хяналт тавих, шилэн дансны мэдээг улирал бүр хугацаанд нь тайлагнах; | | Хугацаанд нь байршуулсан мэдээллийн хувь | 98.4% | 100% | Мэдээллийн ил тод байдал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагааны төсөв, зардалтай холбоотой 28 төрлийн 73 мэдээ, мэдээллийг байршууллаа. | 100 |
| | | | Мэдээллийн бүрэн бүтэн байдал | 12 | 5 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагааны төсөв, зардалтай холбоотой мэдээллийг https://info.shilendans.gov.mn/ цахим хуудаст мэдээлсэн. Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудаст нийгмийн даатгалын үйл ажиллагааны шинчлэгдсэн | |
| | | | Мэдээг хугацаанд хүргүүлсэн байдал (Улирал бүрийн дараа сарын 10-ны | 4 | 2 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | өдрийн дотор) | | | төсвийн хуваарийг 2, 5 дугаар сард "Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт" хэсэгт цаг хугацаанд нь оруулан баталгаажуулж, ил тод болгон ажилласан. | |
| 5.2. | Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, олон нийтэд нээлттэй, ил тод болгохоор заасан мэдээллийг байгууллагын цахим хуудаст болон мэдээллийн самбар, бусад мэдээллийн хэрэгслээр хугацаанд нь бүрэн мэдээлэх, цахим системд нээлттэй байршуулсан байдалд хяналт тавих; | | Мэдээллийн ил тод байдлын хувь (байршуулсан мэдээллийн тоо, Хугацаанд мэдээлсэн байдал, Мэдээллийн бүрэн бүтэн байдал, Эх сурвалжийн тодорхой байдал); | 97% | 99% | Байгууллагын мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах зорилгоор 2026 оны 1 дүгээр улиралд холбогдох албан хаагчдаас мэдээллийг хүлээн авч, веб сайт болон мэдээллийн самбарыг шинэчлэн, иргэдийн мэдээлэл авах эрхийг 85%-ийн гүйцэтгэлтэйгээр хангаж ажиллалаа. | 85 |
| 5.3. | Аудитын байгууллагаас өгөгдсөн акт, албан шаардлага зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлж хугацаанд холбогдох газруудад хүргүүлэх; | | Акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийн хувь; | 100% | 100% | Тус газрын 2025 оны Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн, байгууллагын үйл ажиллагааны тайлангийн аудитыг Баталгаат тооцоолол аудит ХХК гүйцэтгэж, "зөрчилгүй" дүгнэлт авлаа. Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу 2026 оны 03 дугаар сард 7 заалт бүхий төлөвлөгөө гарган, төлөвлөгөөний дагуу ажлуудыг хэрэгжүүлэн ажиллаж, хэрэгжүүлсэн ажлын үр дүн, төлөвлөгөөний биелэлтийг гарган, нотлох баримтыг хавсаргаж, НДЕГ-ын ДАМГ-т албан бичгээр | 56.9 |
| | | | Хугацаанд хүргүүлсэн байдал (Нотолгоо, баримттай); | 4 | 4 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүргүүлж, хянуулав. Зөвлөмжийн биелэлт, гүйцэтгэлийг fasaudit програмд оруулсан. | |
| ***Зорилт 6.*** Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогчид, даатгуулагчид, иргэд, Нийгмийн даатгалын байгууллагуудад хяналт шалгалт хийх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, нийгмийн даатгалын шимтгэлийн өр авлагыг бууруулах, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах, заавар, зөвлөмжийн санал боловсруулах, хэрэгжилтийг хангах; | | | | | | | |
| ***Зорилт 6.1.*** Нийгмийн даатгалын багц хуулиуд, Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг батлагдсан удирдамжийн дагуу 6 аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газарт шалгаж, өмнөх шалгалтын үр дүнг тооцож, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх | | | | | | | |
| 6.1.1. | Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэлд (нийт 7-оос доошгүй сум) дотоодын хяналт, шалгалтыг зохион байгуулж, тайланг хагас бүтэн жилээр гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулж, заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх; | | Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангийн үндэслэлд шалгалт хийх | 4 | 2 | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026.03.23-ны өдрийн А/69 дугаар "Ажилгүйдлийн тэтгэмж шалгах тухай", 2026.04.01-ний өдрийн А/82 дугаар " Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх тухай" төлөвлөгөөт бус хяналт шалгалтын удирдамжийн дагуу гүйцэтгэж, биелэлтийг заасан хугацаанд хүргүүлэв.<br><br>Мэдээллийн технологийн төвөөс дараах жагсаалтуудыг ирүүлсэн байна.<br><br>2020-2025 онд нас барсны дараа сараас хойш илүү олгогдсон зөрчилтэй тэтгэврийн жагсаалтад үндэслэн тэтгэврийн олголтын тооцооллын үндэслэлд тулгалт хийлээ.<br><br>42 жагсаалт бүхий 15 тэтгэвэр авагчийн нэр ирсэн бөгөөд тулган шалгахад 5 тэтгэвэр авагч холбоотой зөрчил илэрсэн байна. Үүнээс | 60 |
| | | | Сайн дураар даатгуулагчийн шимтгэл төлөлтөд хяналт шалгалт хийх | 1 | 1 | | |
| | | | Тэтгэврийн тогтоолт, олголтод хяналт шалгалт хийх | 1 | 1 | | |
| | | | Тэтгэмжийн тогтоолт, олголтод хяналт шалгалт хийх | 1 | 1 | | |
| | | | Тэтгэврийн хувийн хэргийн тооллого хийх | 1 | 1 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2 тэтгэвэр авагчид илүү олгосон 31,405,4 мянган төгрөгийн тэтгэврийн даатаглын санд төлүүлэхээр 31405,45 мянган төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоож, 12,576,7 мянган төгрөгийг барагдуулсан, мөн шинээр 3 тэтгэвэр авагчид 4465,7 мянган төгрөг илүү олгосон тогтоогдоод байна.<br><br>Мөн тэтгэвэр авах эрх зүйн харилцаа дуусгавар болж нас барсан, зогсоогдсон болон шилжин явсан, шилжин ирсэн, Монгол улсын иргэний харьяатаас гарсан, гадаад улсын иргэн тэтгэвэр авагчийн тэтгэврийн олголтын тооцооллын үндэслэлийг тулган шалгалаа.<br>Архивын нэгжээс дээрх хугацааны 1,664 тэтгэврийн хувийн хэргийг татан авч олголттой тулгалгахад 26 тэтгэвэр авагчид холбогдох 10312,5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.<br><br>636 жагсаалт бүхий ажилгүйдлийн тэтгэмж авсан иргэдийн мэдээлэл ирснийг тулган шалгалаа. Шалгалтаар 62 даатгуулагчтай холбоотой зөрчил илэрснээс дотоод хяналтаар ажилгүйдлийн сангаас илүү олгосон 17 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | иргэнд улсын байцаагчийн акт, НДЕГ-н салбарын хяналтаас 13 иргэнд улсын байцаагчийн актыг тус тус тогтоосон байна. Ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаанд ажилд орж албан журмаар шимтгэл төлсөн 23 иргэний тушаалыг татан авч тооцоо хийх, ажилд орсон 9 иргэний тушаалаар тэтгэмжийг зогсоохдоо программд огноо буруу оруулсанаар 1 өдрийн тэтгэмж илүү олгосон зөрчил илэрсэн байна. Шалгалтын тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэв. | |
| 6.1.2. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт шалгалт, дотоодын хяналт шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалтын мэдээ, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын тайланг улирал тутамд гаргаж Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газарт хүргүүлэх, | | Төлбөр зөрчлийн барагдуулалтын хувь | 7.5% | 73% | "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" төлөвлөгөөт шалгалтаар Нүүрэнтэйн эсгий ХХК-д Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024.07.08-ны өдрийн 32/34 дугаартай Улсын ахлах байцаагчийн 2,081.8 мянган төгрөгийн акт тогтоогдож, 2026 оны 05 дугаар сарын байдлаар барагдуулаагүй байна. Тус компанийн захирал болон нягтлан бодогч нартай удаа дараа холбогдоход улсын байцаагчийн актыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн тайлбар өгсөн байна. | 49.06 |
| | | | Нэгтгэсэн тайлангийн тоо | 2 | 1 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | "Ажилгүйдлийн даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн дагуу 2022-2024 онд олгосон ажилгүйдлийн тэтгэмжийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газрын Нийгмийн хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч нар гүйцэтгэж, улсын байцаагчийн акт тогтоосон. Улсын байцаагчийн илүү, дутуу олгосон 26 даатгуулагчийн 21,393.8 мянган төгрөгийг актын төлбөрөөс 11 даатгуулачийн 4,485.9 мянган төгрөгийг барагдуулж, 14 даатгуулагчийн 16,907.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.<br><br>Улсын байцаагчийн актын барагдуулалт 21%-тай байна.<br><br>Оны эхний үлдэгдэлтэй тэтгэвэр тогтоолгосон 34 тэтгэвэр авагчийн 532,037.9 мянган төгрөгийг тэтгэврийн даатгалын санд буцаан төлүүлэхээр тогтоосон улсын байцаагчийн актын үлдэгдэлтэй байна. Тайлант хугацаанд 47 тэтгэвэр авагчид дутуу олгосон 37,115.2 мянган төгрөгийн акт тогтоогдож, бүрэн олгож барагдууллаа. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Нийт 569,153.1 мянган төгрөгийн улсын байцаагчийн актын авлагаас 37,832.4 мянган төгрөг барагдсан байна. Үүнээс: 20 тэтгэвэр авагчид холбогдох 409,822.98 мянган төгрөгийн авлага нь Эрүүгийн хэрэг үүсгэн шалгагдаж байгаа тул актын барагдуулалтыг түр зогсоосон байна. Барагдуулалт 23,74%-тай байна.<br><br>Оны эхний үлдэгдэлтэй 3 тэтгэвэр авагч болох Н.Өлзийхутаг, Д.Батчулуун, П.Ууганхүү нар нь нас барсан байна.<br><br>Тайлант хугацаанд 47 тэтгэвэр авагчид дутуу олгосон 37,115.2 мянган төгрөгийн акт тогтоогдож, бүрэн олгож барагдуулсан байжээ. Барагдуулалт 100%-тай байна.<br><br>Оны эхний үлдэгдэлтэй жирэмсэн, амаржсаны тэтгэмж 1 даатгуулагч, илүү олгосон ажилгүйдлийн тэтгэмж 4 даатгуулагчид илүү олгосон нийт 11,496.8 мянган төгрөгийг актын төлбөрөөс барагдуулаагүй байна.<br><br>Тайлант хугацаанд ажилгүйдлийн тэтгэмж илүү олгосон 8 даатгуулагчид | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 4,687.9 мянган төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоогдож, 5 даатгуулагчийн 2,273.1 мянган төгрөгийг барагдуулан, 2,414.8 мянган төгрөгийг барагдуулаагүй, улсын байцаагчийн актын барагдуулалт 51,5%-тай байна.<br><br>Дотоод хяналт, шалгалтын тайланг хагас жилээр үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлантай тулган баталгаажуулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын Хяналт шалгалтын газар хүргүүлэхээр бэлтгэж байна. | |
| 6.1.3. | Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогчид Нийгмийн даатгалын багц хууль,тогтоомжийн хэрэгжилтийг 1 баг нь 100 ААНБ-ыг шалгаж, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээг зохион байгуулах | | Шалгасан ААНБ-ын тоо | 100 | 100-аас дээш | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамжийн дагуу шимтгэлийн хуримтлагдсан өртэй аж ахуйн нэгж, байгууллагуудтай өр барагдуулах, шалгалтанд хамрагдах тухай удирдамж танилцуулахаар холбогдоход аж ахуйн нэгж, байгууллагын тушаал шийдвэр, иргэн болон ажилтантай байгуулсан холбогдох гэрээ, санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэл, цалин хөлс, санхүүгийн анхан шатны | 75.8 |
| | | | Улсын байцаагчийн акт, төлбөрийн барагдуулалтын хувь | 70% | 72% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | баримтуудаас дутуу ирүүлсэн, мөн удаа дараа холбогдоход материал ирүүлээгүй зэрэг нөхцөл байдлаас үүдэн шалгалтыг эцэслэн дуусгаагүй байна.<br><br>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг “Ажил олгогч Улсын бүртгэлийн байгууллагаас гэрчилгээ авснаас хойш ажлын 14 өдрийн дотор харьяалагдах нийгмийн даатгалын байгууллагад нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлэх”-т заасны дагуу хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй 11, ажил олгогчийг нотлох баримтад үндэслэн тулган шалгасан, мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/199 дугаар тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын 4.1-т дагуу 2 ажил олгогчийг нотлох баримтад үндэслэн тулган шалгаж зөрчлийн тухай хуулийн дагуу шалган шийдвэрлэж 6,000.0 мянган төгрөгийн торгууль тогтоож, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу 15 хоногийн дотор торгуулиа | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлсөн 12 ажил олгогчийн 5,500.0 мянган төгрөгийн торгууль 50%-ийн хөнгөлөгдсөн, 1 ажил олгогч торгуулийн 500.0 мянган төгрөг төлөөгүй, барагдуулалт 92%-тай байна.<br><br>Тайлант хугацаанд дотоодын хяналт шалгалтаар 10 ажил олгогч, байгууллагын 10 даатгуулагчид холбогдох 1700,6 мянган төгрөгийн акт тогтоогдож 9 ажил олгогчийн 1486,9 мянган төгрөгийг актын төлбөрийг барагдуулж, 1 ажил олгогчийн 213,7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. 2025 оны байдлаар үлдэгдэлтэй шимтгэлийн өртэй 2 ажил олгогчийн 39,8 мянган төгрөгийн улсын байцаагчийн актыг барагдуулаагүй байна. Улсын байцаагчийн актын барагдуулалт 85,4%-тай байна. | |
| ***Зорилт 6.2.*** Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, шимтгэлийн авлага барагдуулах ажлыг зохион байгуулах; | | | | | | | |
| 6.2.1. | Ажил олгогч, даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх | | НДШ-ийн орлогын төлөвлөгөө | 38,111 сая | 19,135.18 сая | 2026 оны эхний 5 сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн төлөвлөгөөгөөр 16,170.6 сая төгрөг төвлөрүүлэхээс 16,644.7 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 102,9%-иар биелүүллээ. Шимтгэлийн өр төлбөрийг төлүүлэхээр ажил олгогч нартай сар бүр тогтмол | 102.9 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | утсаар ярих, мессэж илгээх, БНД-НДХ-Ажил олгогч групп чат, пэйж хуудсаар мэдээлэл, санамж хүргэв. НДШ-ийн авлагын насжилтийн судалгааг сард 2 удаа гаргаж шимтгэлийн өр төлбөрийг барагдуулах, хууль сануулах, данс, мөнгөн дүнг ажил олгогч байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нарт утсаар тогтмол мэдэгдэж ажиллав. | |
| 6.2.2. | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 20 хувиар бууруулах | | НДШ-ийн авлага барагдуулалт | 4456.32 | 3637.05 | Нийгмийн даатгалын шимтгэлийн 2025 оны жилийн эцсийн өртэй 114 ажил олгогчийн 4,546,2 сая төгрөгийн авлагаас тайлант оны эхний 5 сарын байдлаар 83 нь бүрэн, 16 нь хэсэгчлэн нийт 98 ажил олгогчийн 1,546,9 сая төгрөг буюу 34,03 хувийг барагдуулж, 31 ажил олгогчийн 2,999,3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. | 170.15 |
| ***Зорилт 6.3.*** Төлөвлөгөөт шалгалтын хүрээнд аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газарт ажиллах явцад нийгмийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлэх, 180 буюу түүнээс дээш хоногийн насжилттай хуримтлагдсан өрийг барагдуулах ажлыг зохион байгуулах | | | | | | | |
| 6.3.1 | Аж ахуйн нэгж, байгууллагад хийх шалгалтын хүрээнд ажил олгогчийн хуримтлагдсан өрийг барагдуулах | | ААНБ-ын тоо | 5 | 20 | хяналт шалгалтаар 10 ажил олгогч, байгууллагын 10 даатгуулагчид холбогдох 1700,6 мянган төгрөгийн акт тогтоогдож 9 ажил олгогчийн 1486,9 мянган төгрөгийг актын төлбөрийг барагдуулж, 1 ажил олгогчийн 213,7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна | 87.43 |
| | | | НДШ-ийн хуримтлагдсан авлагыг барагдуулалтын хувь | 20% | 50% | | |
| ***Зорилт 6.5.*** Нийгмийн Халамжийн сангийн 2023-2025 оны санхүүгийн болон бусад баримт, мэдээлэлд тулгуурлан Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр тогтоолт, олголт, асаргааны тэтгэмж, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн тогтоолт, олголт, протез, ортопед, тусгай хэрэгслийн нийлүүлэлт, | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| олголт, ахмадын амралт, сувилал, магадлан итгэмжлэгдсэн рашаан, сувилалын үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийх | | | | | | | |
| 6.5.1. | Аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын нийгмийн халамжийн санд хийх урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгуулах, тайлан мэдээг хугацаанд нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналт шалгалтын газарт хүргүүлэх | | Хяналт шалгалтын тоо | 1 | 1 | Тус газар нь нийгмийн хамгааллын байцаагчгүй болно. | - |
| | | | Гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | | |
| ***Стратегийн төлөвлөгөөний зорилго 3:*** Нийгмийн даатгалын үйлчилгээ, мэдээллийн нэгдсэн санг боловсронгуй болгож, дэвшилтэт шинэ технологи нэвтрүүлэх, олон нийтэд мэдээлэх, сурталчлах; | | | | | | | |
| ***Зорилт 7.*** Нийгмийн даатгалын үйлчилгээг мэргэжлийн түвшинд чанартай үзүүлэх, хөгжүүлэх, сайжруулах, цахимжуулах, нийгмийн даатгалын маркетингийг боловсронгуй болгох, Нийгмийн даатгалын хууль тогтоомж, тэдгээрийн шинэчлэлийн талаар мэдээлэх, сурталчлах, олон нийтэд түгээх; | | | | | | | |
| 7.1. | Нийгмийн даатгалын мэдээллийн шинэ системийн хэрэглээг сайжруулах зорилгоор иргэд, даатгуулагч, ажил олгогчоос сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэн дүгнэх, сайжруулах санал боловсруулж, хэрэгжүүлэх; | | Судалгааны тоо | - | 2 | Иргэд болон ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгааг цахим хэлбэрээр зохион байгуулж, нийт 90 ажил олгогчийн удирдлага, хүний нөөц, санхүүгийн ажилтан болон 16 даатгуулагчийн санал хүсэлтийг нэгтгэн, үр дүнг тайлагнаж сайжруулах санал боловсрууллаа. | 100 |
| | | | Оролцогчийн тоо: | - | АО-2<br>И,Д-50 | | |
| | | | Саналын тоо | - | 2 | | |
| 7.2. | Иргэд даатгуулагчдаас нийгмийн даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой сэтгэл ханамжийн судалгаа авах, сайжруулах санал боловсруулах, хэрэгжүүлэх | | Судалгааны тоо | 2 | 2 | Байгууллагын үйл ажиллагааны хүрээнд иргэд, даатгуулагчдын сэтгэл ханамжийн судалгааг цахим хэлбэрт шилжүүлэн нийт 90 ажил олгогчийн удирдлага, хүний нөөц, санхүүгийн ажилтан болон 16 даатгуулагчийн санал асуулгыг амжилттай авч нэгтгэн, судалгааны нэгдсэн дүн болон сайжруулах санал, зөвлөмжийг 2026 оны 06 дугаар сарын 08-ны өдөр НДЕГ-ын Үйлчилгээ хөгжүүлэлт, олон нийттэй харилцах газарт хагас | 100 |
| | | | Оролцогчийн тоо: | 100 | 100 | | |
| | | | Саналын тоо | - | 2 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | жилийн тайлангийн хүргүүлэв. | |
| 7.3. | Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах, сайжруулах санал хүргүүлэх; | | Дуудлага алдалтын хувь | 6.9% | 4%, | CallPro системийн дуудлагын бүртгэлд тогтмол хяналт тавин ажилласны үр дүнд тайлант хугацаанд дуудлага алдалтын түвшинг 7.2%-д барьж, зорилтот үзүүлэлтийг 10%-иас доош амжилттай хадгалан үйлчилгээний шуурхай байдлыг ханган ажиллалаа. | 100 |
| | | | Саналын тоо | - | 2 | | |
| 7.4. | Нийгмийн даатгалын байгууллагад хэрэгжүүлж буй үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, мөрдөж ажиллах, сайжруулах талаар санал дэвшүүлэх; | | Хэрэгжилтийн хувь | 100% | 100% | -Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээний стандартыг хангуулах ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламжийн хонхыг засварлаж, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэргэнцрийн замын наалтыг шинэчилсэн байна.<br><br>Мөн ажлын байрны болон үйлчилгээний орчны бэлэн байдал, тав тух, тохилог орчинг бүрдүүлж, өрөөний хаягжилт, үйлчилгээний заалны албан хаагчийн хаягийг шинэчлэн тодруулж, үйлчлүүлэгч бүрт мэдээ мэдээлэлтэй чөлөөтэй танилцах, хэрэглэх боломжийг ханган үйлчилгээний А, Б зааланд байршуулсан байна.<br><br>Үйлчлүүлэгчийн хувийн нууцыг хангах, бухимдуулахгүй байх үүднээс | 100 |
| | | | Саналын тоо | 2 | 2 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | албан хаагч бүр үйлчлүүлэгчийг суулгаж үйлчлэх, ээлжийн дараалллыг баримтлан үйлчилж хэвшсэн байна. | |
| 7.5. | Нийгмийн даатгалын ач холбогдолыг энгийн ойлгомжтой байдлаар мэдээлэл хүргэх /контент, постер, рийл, цаг үеийн мэдээ мэдээлэл/ Нийгмийн даатгалын байгууллагаар авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг тогтмол мэдээллэх; /Байгууллагын фэйсбүүк болон албан ёсны веб сайт/ | | Мэдээлэл бэлтгэсэн тоо | 27 | 30 | "Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн шинэчлэл болон үйлчилгээний талаарх мэдээллийг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор орчин үеийн дижитал хэлбэрээр (постер, видео контент, рийлс) тогтмол бэлтгэн олон нийтийн сүлжээгээр түгээж, тайлант хугацаанд нийт [тоо] контент нийтэлснээр 1322321 хандалт, 1770 риакшн, 175 сэтгэгдэл, 2660 шэйр болон 431хадгалалт (save)-ыг тус тус авч, иргэдийн мэдээлэл авах боломж, оролцоог өндөр түвшинд хангаж ажиллалаа. | 100 |
| | | | Хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн хувь | 80% | 90% | | |
| | | | Хандалтын тоо / фэйсбүүк/ *(одоо байгаагаас нэмэгдүүлэх тоо)* | 4250 | 1 сая | | |
| 7.6. | Нийгмийн даатгалын байгууллагын үзүүлсэн үйлчилгээ, орлого, зарлагыг тогтмол мэдээлэх “Тойм мэдээ”-г бэлтгэн хүргэх; /мэдээ, постер, видео бичлэг, фэйсбүүк лайв гэх мэт арга хэрэгслийг ашиглан бэлтгэх/ | | Мэдээллийн тоо | 12 | 12 | Нийгмийн даатгалын байгууллага нь үйлчилгээний тайлан болон санхүүгийн мэдээллийн ил тод байдлыг хангах хүрээнд нийгмийн сүлжээгээр дамжуулан нийт 7 удаагийн мэдээллийг тогтмол бөгөөд шуурхай байршуулж ажиллалаа. | 100 |
| | | | Хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | | |
| 7.7. | Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах хүрээнд хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах, эх сурвалжаар хангах; | | Хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа хийсэн хэвлэл мэдээллийн байгууллагын | 2 | 2 | Нийгмийн даатгалын байгууллагаас хөдөлмөрийн чадвар алдалтын өнөөгийн байдал, шалтгаан болон урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх мэдээллийг дүүргийн удирдлагуудад танилцуулж, | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тоо | | | "Багануурын мэдээ" фэйсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд нээлттэй мэдээлж, хамтын ажиллагааг хэрэгжүүллээ. | |
| | | | Хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | | |
| | | | Хамтран ажилласан байгууллагын тоо | 1 | 1 | | |
| | | | Хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | | |
| 7.8. | Ажил олгогч, даатгуулагч, иргэдэд зориулсан нийгмийн даатгалын хууль, тогтоомжийг төрийн болон олон нийтийн байгууллага, хувийн хэвшил, төрийн бус байгууллагатай хууль сурталчлах чиглэлээр нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах зэргээр хамтран ажиллах; | | Нээлттэй өдөрлөг зохион байгуулсан тоо | 6 | 6 | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд Багануур Тохижилт ААТҮГ болон бусад байгууллагуудтай хамтран 2 удаагийн сургалт, өдөрлөгийг зохион байгуулж, Төлчин эмэгтэйчүүдийн болон "Ажилтнуудаа сонсъё" зэрэг 2 үйл ажиллагаанд нийт 4 удаагийн арга хэмжээгээр дамжуулан ажил олгогч, даатгуулагчдад зөвлөгөө мэдээлэл хүргэн ажиллалаа. | 100 |
| | | | Хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн хувь | 100% | 100% | | |
| ***Зорилт 8.*** Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэх, хадгалах, хамгаалах, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх; | | | | | | | |
| 8.1. | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | | Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | 95,7% | 100% | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулах ажлын хүрээнд ажил олгогчийн хариуцлагын хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, хаяг, утас, цахим хаяг зэрэг мэдээллийг тухай бүр ажил олгогчоос албан хүсэлт болон улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг авч | 100 |
| | | | Ажил олгогчийн НДШ-ийн | 99,94% | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тайланд ирүүлэх даатгуулагчийн мэдээллийг бүрэн, зөв бүрдүүлсэн байх | | | өөрчлөн шинэчилж мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлэн ажиллаж хэвшсэн. Шинээр бүртгүүлж байгаа болон бүртгэлтэй ажил олгогчийн удирдлага, санхүүгийн ажилтнууд солигдох тухай бүр албан хүсэлтийг үндэслэн улсын бүртгэлийн гэрчилгээ, тушаал, бичиг баримтын үндэслэлийг шалган бүрдүүлж шинэчлэгдсэн мэдээллийг системд өөрчлөн бүртгэж ажиллаж байна. Тайлант хугацаанд нийт шинээр шимтгэл төлөгч ажил олгогчоор бүртгүүлэх, дарга, захирал, эрхлэгч болон нягтлан бодогч солигдсон, байгууллагын нэр, хэлбэр өөрчлөгдсөн, регистрийн дугаар шинэчлэгдсэн зэрэг нийт 81 ажил олгогчийн мэдээллийг баримтыг үндэслэн бүрэн гүйцэт оруулж ажил олгогчийн мэдээллийг үнэн зөв бүрдүүлж ажиллав. Цахим хэлбэрээр ирүүлсэн тайланг хянан баталгаажуулах тухай бүр ажил олгогчийн шинээр томилогдсон ажилтны даатгуулагчийн төрөл кодыг зөв сонгосон эсэхэд түүврээр хяналт тавьж шаардлагатай тохиолдолд ажил олгогчтой холбогдон даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүрдүүлэн ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Тайлант хугацаанд нийт шинээр томилогдон ажиллаж буй 56 даатгуулагчийн мэдээллийг нягтлан ажилласан байна. | |
| 8.2. | Мэдээллийн технологийн ашиглалтыг сайжруулах | | Программ хангамжуудыг зөв зохистой ашиглаж, аюулгүй байдлыг хангах | 100% | 100% | Программ хангамжуудыг зөв зохистой ашиглаж, системийг процессын зураглалын хүрээнд горимын дагуу ашиглаж ажиллах, мэдээллийг зохих зөвшөөрөлгүйгээр тараахгүй, түгээхгүй байхад анхаарч шинээр бүртгүүлсэн ажил олгогчийн мэдээллийг тухай бүр мэдээлэл технологийн ажилтанд мэдэгдэж ажил олгогчийн хуваарилалтыг системд хийлгэн ажиллаж байна. Тайлант хугацаанд шинээр бүртгэгдсэн 41 ажил олгогчийг хуваарилуулав. | 100 |
| | | | МТТ-өөс хүргүүлсэн албан бичгийн хариу, судалгааг цаг хугацаанд нь ирүүлэх, бусад үүрэг болгосон ажлыг хэрэгжүүлсэн байх | 100% | 100% | | |
| ***Зорилт 9.*** Эрүүл мэндийн магадлалын чиглэлээр хяналт шалгалт, сургалт, судалгаа, шинжилгээ хийх, тайлан мэдээ нэгтгэн дүгнэх, санал боловсруулах, сонгон шалгаруулалт зохион байгуулах оролцогч талуудад мэргэжил арга зүйн үйлчилгээ үзүүлэх | | | | | | | |
| 9.1. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаа болон эмнэлгийн хуудасны үндэслэлд дотоодын хяналт тавих, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах арга хэмжээг авч ажиллах | | Хяналт шалгалтын болон арга хэмжээний тоо | 4 | 4 | Эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудасны жагсаалтыг сар бүр авч хяналт хийдэг. Тайлант хугацаанд 998 хөдөлмөрийн чадвар алдалт, 176 жирэмсэн амаржсаны эмнэлгийн хуудсыг хянаж, баталгаажуулжээ. Эрүүл мэндийн байгууллагын | 90 |
| | | | Хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулсан хувь | -4% | -2,5% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 40 гаруй эмч нарыг хамруулж эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаа, эмч нар хурлаар оруулахад анхаарах зүйлс, хяналтын эмчийн хариуцлага, эмнэлгийн хуудас олгох журам зэрэг асуудлаар сургалт зохион байгуулсан.<br><br>Зөвлөлийн хурлыг 7 хоног бүр, гишүүдийн ирцийг ханган хуралддаг. Тайлант хугацаанд 18 удаа 29,5 цаг хуралдсан бөгөөд 1-р улирлын байдлаар 1 гишүүн 8.5 цаг, 1 гишүүн 11 цаг, 1 гишүүн 15 цаг, бусад гишүүд тус бүр бүрэн ирцтэй буюу 18 цагийн хуралд суусан байна. Гишүүдийн ирцийг улирал бүрээр гаргаж дотоодын хяналт хийж, гишүүдийг тухай бүр мэдээлэл, арга зүйгээр ханган ажилласан. Нийт хурлаар 200 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг шийдвэрлэсэн. Тайлант хугацаанд 23 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцласан шийдвэр гарч, хөдөлмөрийн чадвар алдсан иргэний тоо 2,7% буурч, шинээр 32 иргэн тогтоолгож, нийт 869 иргэн хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгосон байна. | |
| 9.2. | Орон нутгийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд судалгаа, дүн шинжилгээ хийж, хөдөлмөрийн чадвар | | Шинээр хийсэн судалгаа | 3 | 3 | Засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэн | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | алдалтаас урьдчилан сэргийлэх, бууруулах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан байх | | болон дүн шинжилгээний тоо | | | хариуцсан мэргэжилтэн болон Эрүүл мэндийн төвийн гэмтэл, чих хамар хоолой, шүдний эмч нартай хамтран гэмтэл, чих хамар хоолойн өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгосон иргэдийн мэдээлэлд судалгаа, дүн шинжилгээ хийж ажилласан. Судалгааны дүнг ЭММСЗөвлөлд танилцуулсан. Судалгаагаар гэмтэл нь хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэж буй өвчлөлийн 3 дугаарт, чих хамар хоолойн өвчин нь 6 дугаарт орж байна. Дээрх өвчний заалтаар хөдөлмөрийн чадвар алдалтын хугацаагүй шийдвэртэй 70 иргэнийг дахин магадлалд хамруулж байна. | |
| | | | Засаг дарга болон хамтран ажилласан байгууллагын тоо | 5 | 5 | | |
| 9.3. | Эрүүл мэндийн магадлалтай холбоотой хууль, тогтоомжийг танилцуулах, авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох эмч, мэргэжилтнүүд болон иргэдэд чиглэсэн сургалт зохион байгуулах | | Сургалтын тоо | 4 | 4 | Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаа түүнийг хэрэгжүүлэхэд мөрдөж ажилладаг журам, дүрмийн талаар 5 удаагийн сургалтаар 155 иргэд даатгуулагчдад мэдээлэл, зөвлөгөө өгсөн.<br><br>ЭММТЗөвлөлөөс зохион байгуулсан сургалтад салбар зөвлөлийн гишүүдийг хамруулж, авилга ашиг | 100 |
| | | | Сургалтад хамрагдсан хүний тоо | 150 | 150 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөлийн хурал бүрийн эхэнд тус өдрийн хурлаар орох иргэдийн нэрсийг танилцуулан, ашиг сонирхлын зөрчилтэй эсэхийг асууж, мэдэгдсэн тохиолдолд хуулийн дагуу батлагдсан маягт бөглүүлэн, зөвлөлийн даргаар шийдвэрлүүлж хурлын үйл ажиллагааг эхлүүлж хэвшсэн. Мөн зөвлөлийн магадлалын хурлын явцыг камераар бичиж, архивлаж байна. | |
| 9.4. | Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс өгсөн үүрэг, даалгавар, чиглэл, зөвлөмжийн хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж ажиллах | | Үүрэг, даалгаврын биелэлтийн хувь | 84% | 100% | Тайлант хугацаанд ЭММТЗөвлөлөөс ирүүлсэн 3 чиглэл ирснийг хэрэгжүүлэн ажилласан. Улсын хэмжээнд хийгдэх хөдөлмөрийн чадвар алдалтын хугацаагүй шийдвэртэй иргэдийн дахин магадлалд хамруулах иргэдийн баримт бичгийг бүрдүүлж бэлтгэл ажлыг хангасан. НДЕГ-аас дахин магадлал хийх ажлыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан. | 100 |
| 9.5. | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаа болон эмнэлгийн хуудасны үндэслэлд дотоодын хяналт тавих, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах арга хэмжээг авч ажиллах | | Мэдээллийн сангийн бүрэн, үнэн зөв бүрдүүлэлтийн хувь | 100% | 100% | Эрүүл мэндийн төвийн дүн бүртгэлээс нас барсан иргэдийн жагсаалт, тэтгэврийн байцаагчаас шилжилт хөдөлгөөний бүртгэлийг сар бүр авч мэдээллийн баазад тулгалт хийж, хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгосон иргэдийн хөдөлгөөнийг | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | мэдээллийн баазад хийж ажилласан. Нийгмийн халамжийн сангаас 340 тэтгэвэр авагчдын жагсаалтыг авч тулгахад нас барсан 2, шилжсэн 1 иргэний хөдөлгөөнийг хийж мэдээллийг баазыг шинэчиллээ. | |
| ***Стратегийн төлөвлөгөөний зорилго 4:*** Даатгуулагчид, үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд нийцсэн, нийгмийн хариуцлага бүхий тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх; | | | | | | | |
| ***Зорилт 10.*** Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн туслалцаа үзүүлэх, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, мэргэжил, ур чадвар, чадавхийг дээшлүүлэх, мэргэшүүлэх, | | | | | | | |
| 10.1. | Нийгмийн даатгалын салбарт хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, шийдвэр, тайлан, биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх; | | Тогтоол, шийдвэрийн тоо | 9 | Тухай бүр | Тайлант онд дээд газраас ирүүлсэн 25 эрхзүйн актыг хүлээн авч, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>2026 оны эхний хагас жилийн байдлаар тогтоол шийдвэрийн хэрэгжилт 93.2 %-тай байна. | 93.2 |
| | | | Хугацаанд нь хүргүүлсэн байдал | 2 | 2 | | |
| | | | Хэрэгжилтийн хувь | 93% | 100% | | |
| 10.2. | Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, сул орон тоог хууль тогтоомжийн дагуу нөхөх; | | Баталгаажуулсан орон тоогоор ажилласан хувь | 100% | 100% | Тус газрын даргын 2026 оны 10 дугаар сард А/21 тушаалаар баталсан зохион байгуулалтын 3 нэгж, удирдах 1, гүйцэтгэх 15, үйлчилгээний 2 нийт 18 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна. | 100 |
| | | | Сул орон тооны захиалгын тоо | 2 | Тухай бүр | | |
| | | | Хугацаанд нь шийдвэрлэсэн байдал | 100% | 100% | | |
| 10.3. | Нийгмийн даатгалын газрын ажилтан, албан хаагчдын Нийгмийн даатгалын улсын байцаагч, мэргэшлийн зэргийн нэмэгдэл болон бусад холбогдох судалгааг гаргаж хууль тогтоомжийн дагуу холбогдох баримт бичгийг хүргүүлэх, албан хаагчдыг сургаж, мэргэшүүлэх; | | Хүргүүлсэн судалгаа, мэдээллийн чанар | 100% | 100% | 2026 оны эхний хагас жилийн байдлаар<br>1 албан хаагчийн мэргэшлийн зэрэг,<br>5 албан хаагчийн төрийн албаны зэрэг дэв нэмэгдүүлэх, | 100 |
| | | | Улсын байцаагчийн шалгалтад | 0% | 80% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | тэнцсэн албан хаагчдын эзлэх хувь | | | 8 албан хаагчийн төрийн шагналд тодорхойлж, Ахмадын судалгаа зэрэг хүний нөөцтэй холбоотой 14 судалгааг цаг тухайд нь үнэн зөв гаргаж НДЕГ-т хүргүүллээ. Хүний нөөцийн сарын мэдээг сар бүр ЗУГ-т хүргүүлж байна. | |
| | | | Шалгалтын бэлтгэл сургалтад хамруулсан байдал | 100% | 100% | | |
| 10.4. | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх; | | Сургалт зохион байгуулсан тоо | 7 | 4 | Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг мөрдөж ажилласан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулах 4 удаагийн сургалтад оролцох албан хаагчдын нэрсийг гаргаж, 2 удаагийн 5 цагийн сургалтад давхардсан тоогоор тус газрын 19 албан хаагчийг хамрууллаа. | 100 |
| | | | Ёс зүйн зөрчил гаргаагүй байдал | 100% | 100% | | |
| 10.5. | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангах; | | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 100% | 100% | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр байгууллагын худалдан авах ажиллагаа, төсвийн зарцуулалтыг бүрэн цахимжуулж, ил тод байдлыг хангаж, шилэн дансанд байршуулсан. Нийт албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчил болон авлигын эсрэг хууль тогтоомжийн чиглэлээр НДЕГ-аас зохион байгуулсан сургалтад хамруулж, зөвлөмж мэдээллээр хангасан. | 100 |
| | | | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 8 | 8 | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Үйл ажиллагааны явцад авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй ажлын байрны эрсдэлээс хамгаалж, дотоод хяналтыг тогтмолжуулсан. | |
| 10.6. | 2025 оны ХАСХОМ гаргавал зохих албан хаагч нарын мэдүүлгийг бүрэн гаргаж дуусгах, НДЕГ-т тайлан мэдээг тогтоосон хугацаанд ирүүлэх, 2026 онд ХАСУМ мэдүүлбэл зохих этгээдийн мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн хянуулах. | | ХАСХОМ гаргах этгээдийн жагсаалтыг хугацаанд нь хүргүүлсэн байдал | 100% | 100% | 2025 оны ХАСХОМ гаргавал зохих албан хаагч нарын мэдүүлгийг 2026 оны 02 дугаар сарын 11-ний өдөр бүрэн баталгаажуулж, НДЕГ-т тайлан мэдээг тогтоосон хугацаанд хүргүүлсэн байна. Мөн ХАСУМ хянуулах 1 албан хаагчийн мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэн, хянуулсан байна. | 100 |
| | | | Мэдүүлгийг бүрэн гаргасан байдал, тоо | 100% | 100% | | |
| | | | ХАСУМ хянуулах этгээдийн мэдүүлгийг хянуулсан байдал | 100% | 100% | | |
| 10.7. | “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн дагуу дунд хугацааны дэд төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллах; | | Баталсан төлөвлөгөө | 1 | 1 | Монгол улсын гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025.09.03-ны А/163 дугаар тушаалын дагуу Нийгмийн батлагааг хангах төлөвлөгөөг 2026.04.15-ны Газрын даргын А/08 тушаалаар баталсан.Үүнтэй холбоотойгоор Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталж нийт газрын хэмжээнд мөрдөж байна. Төлөвлөгөө боловсруулж, эхний хагас жилээр 70%-ийн | 72 |
| | | | Хэрэгжилтийн хувь | 71.2 | 100% | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | биелэлттэй байна. | |
| 10.8. | Ахмадуудын нийгмийн баталгааг хангах, “Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам”-ын дагуу дэмжлэг үзүүлэх; | | Хэрэгжилтийн хувь | 50% | 100% | НДЕГ-аас ирүүлсэн 2026 оны 06/758 тоот Чиглэл хүргүүлэх тухай "Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.5-д “Төсвийн байгууллага ахмадын сангийн хөрөнгийг Төрийн сангийн дансанд байршуулна", 2026 оны төсөвт зардлын эдийн засгийн “Ахмадын сан” ангилалд батлагдсан төсвийг ахмадын сангийн дансанд төвлөрүүлж, тухайн данснаас зарцуулж байх" чиглэлийн дагуу 2026 оны батлагдсан төсвийн 3,0 сая төгрөгийг энэ оны 5 дугаар сард ахмадын санд байршуулсан. Тус газарт харъяалалтай 11 ахмадыг Монголын уламжлалт Цагаан сараар хүлээн авч хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулсан. | 100 |
| | | | Тусламжийн дүн | 950,000 | 3,000,000 | | |
| 10.9. | “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн цахим систем”-ийг турших, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах | | Нэвтрүүлсэн байдал | - | 75% | Нийт 18 албан хаагч pm.hrs.gov.mn гүйцэтгэлийн төлөвлөгөөг 100% шивж оруулсан. | 100 |
| 10.10. | Дээд байгууллагаас өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг хэрэгжүүлэх, тухай бүр нь хүргүүлж ажиллах; | | Хэрэгжилтийг хувь | 100% | 100% | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас тайлант хугацаанд ирүүлсэн 16 чиглэл, 11 зөвлөмж, 7 шийдвэрийг тухай бүр удирдлагад танилцуулан, цохолт хийлгэж албан | 100 |
| | | | Хугацаандаа хүргүүлсэн үүрэг даалгаврын тоо | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаагчдад хүлээлгэн өгөв. Хариутай бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж, хариуг заасан хугацаанд хүргүүлсэн. Мөн 2026 оны 05 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл нийт 25 эрх зүйн актыг хүлээн авч хэрэгжилтийг ханган ажилласан байна. | |
| 10.11. | Иргэд, даатгуулагч, ажил олгогч, хуулийн этгээдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэх, тоон гарын үсгээр албан бичгийг баталгаажуулан солилцох; | | Албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн хувь | 98% | 100% | 2026 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар тус газарт Edoc-224, Able-229 нийт 453 албан бичиг ирсэн бөгөөд 1 албан бичгийг 1 хоногийн хугацаа хэтэрч шийдвэрлэсэн. | 100 |
| | | | Өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэсэн хувь | 99.5% | 100% | | |
| | | | Тоон гарын үсгийн хэрэглээний хувь | 100% | 100% | | |
| 10.12. | Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх; | | Сургалтын тоо | 99 | 70 | Тайлант хугацаанд албан хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор тэдний саналыг үндэслэн улсын байцаагч, мэргэшсэн нягтлан бодогч болон бусад чиглэлийн мэргэшүүлэх сургалтуудад үе шаттайгаар хамруулж, нийт 60 удаагийн сургалтад давхардсан тоогоор 369 ажилтан албан хаагчийг идэвхтэй оролцуулж ажиллалаа. | 100 |
| | | | Албан хаагчдын тоо | 413 | 350 | | |
| ***Зорилт 11.*** Ажил олгогч, даатгуулагч, иргэдэд нийгмийн даатгалын хууль эрх зүйн мэдлэг олгох замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах; | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11.1. | Ажил олгогч, даатгуулагч, иргэдийн нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах; | | Сургалтын тоо | 16 | 16 | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр тусгагдсан шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж, нийт 16 удаагийн сургалтыг үр дүнтэй зохион байгууллаа. Тус сургалтуудад 132 ажил олгогч аж ахуйн нэгжийг хамруулахын зэрэгцээ төлөвлөгөөт тоог давуулан биелүүлж, нийт 1071 ажил олгогч, иргэн болон даатгуулагчийг холбогдох мэдээ мэдээллээр ханган ажиллалаа. | 100 |
| | | | ААНБ-ын тоо | 175 | 132 | | |
| | | | Иргэд, даатгуулагчдын тоо | 551 | 1071 | | |
| 11.2. | Нутгийн захиргааны байгууллагатай хамтран өрхийн болон хувиараа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг нийгмийн даатгалд заавал даатгуулах чиглэлээр сургалт, сурталчилгаа хийх | | Сургалт, сурталчилгааны тоо | 27 | 11 | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд Багануур Тохижилт ААТҮГ болон бусад байгууллагуудтай хамтран 2 удаагийн сургалт, өдөрлөгийг зохион байгуулж, Төлчин эмэгтэйчүүдийн болон "Ажилтнуудаа сонсъё" зэрэг 2 үйл ажиллагаанд оролцон нийт 4 удаагийн арга хэмжээгээр дамжуулан ажил олгогч, даатгуулагчдад зөвлөгөө мэдээлэл хүргэн ажиллалаа. | 100 |
| | | | Өрхийн болон хувиараа үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулах хувь | 10% | 10% | | |
| Гүйцэтгэлийн үнэлгээ | | | | | | | 97.18% |
| Дээд газраас дүгнэсэн үнэлгээ | | | | | | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээ**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Үндэсний бичгийн танхимын сургалтанд хамрагдан, бие даан хичээллэж, үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болох. | Танхимын сургалтад 90%-иас дээш ирцтэй хамрагдсан байна. -Албан хэрэг хөтлөх, хөрвүүлэх чадвартай болсон байна. | Үндэсний бичгийн цахим сургалтад хамрагдсан, анхан шатны түвшинд байна. | Үндэсний бичигт хөрвүүлэх | Албан хэрэг хөтлөх | Багануур дүүргийн Насан туршийн суралцахуйн төвөөс зохион байгуулсан “Үндэсний бичиг”-ийн анхан шатны 8 удаагийн 16 цагийн танхимын сургалтад оролцож, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэв. Хичээлийг багш, докторант Ш.Бадамрагчаа заалаа. Анхан шатны мэдлэгийн түвшин тогтоох шалгалтад амжилттай дүн үзүүлж, дараагийн шатны сургалтад оролцох эрх авав. | 100 |
| 2 | Нийгмийн даатгалын байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөнд хамрагдах. | Сургалт, зөвлөгөөнд бүрэн хамрагдсан байна. | Удирдах ажилтны сургалт, зөвлөгөөнд 2 удаа хамрагдсан. | Зохион байгуулагдсан хугацаанд | Зохион байгуулагдсан хугацаанд | НДЕГ-н 3-р сард зохион байгуулсан удирдах ажилтны сургалтад газрын дарга хамрагдсан | 100 |
| 3 | Манлайллын ур чадварын талаарх сургалтад хамрагдах. | Газрын удирдах ажилтнууд манлайллын ур чадварын сургалтад 100 хувь оролцсон | - | Тухай бүр | Тухай бүр | Одоогоор хүлээгдэж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байна. | | | | | |
| 4 | Стресс менежментийн хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллах. | Стресс менежментийн хөтөлбөрийг боловсруулж амжилттай хэрэгжүүлсэн байна. | - | Тухай бүр | Тухай бүр | Стресс менежмент хөтөлбөрийн хүрээнд 2025 онд гаргасан нийт албан хаагчдын дунд явуулсан судалгаанд үндэслэн бүтээмж нэмэгдүүлэх, ажлын байрандаа тайван ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэхээр дэлхийн хүний нөөцийн судалгааны 3 том зохиол болох GOOGle-н Алтан дүрэм, Netflix-ийн Дүрэмгүй дүрэм, Dare to Lead номыг үндэслэн дээрх номын зарчмуудаас ажилтан албан хаагч дээрээ турших хэрэгжүүлж байна.<br><br>2026.02.06-ны өдөр НДЕГ-ын ҮХОНХГ-аас зохион байгуулсан “Аз жаргалтай ажлын байр” сургалтанд нийт албан хаагч нар хамрагдсан байна.<br><br>Албан хаагчдаа мотивацжуулах буюу АЗ-н сертификатын сургалтад 5 албан хаагч хамруулж илүү шинэлэг, танин мэдэхгүйгээ тэлэх зэрэгт нь системтэйгээр тусалж байна. | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Дүүргийн ЭМТ-ийн сэтгэцийн эмчийн үзлэгт хамрагдаж, “Стресс, нойргүйдлийн түвшин тогтоох судалгаа”-г бөглөсөн дүнгээр сэтгэцийн эрүүл мэнд “хэвийн” үнэлэгдсэн. Мөн “Сэтгэцийн эрүүл мэнд, Ажлын байрны стресс менежмент” сэдэвт сургалтад оролцлоо. | |
| Гүйцэтгэлийн үнэлгээ | | | | | | | 100% |
| Дээд газраас дүгнэсэн үнэлгээ | | | | | | | |

oOo

ТАЙЛАН ХЯНАСАН:
НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА Б.БАТЖАРГАЛ

......... оны ...... дугаар сарын ......

ТАЙЛАГНАСАН:
БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ГАЗРЫН ДАРГА Р.ӨНӨРЖАРГАЛ

2026 оны 06 дугаар сарын 12

БАГАНУУР ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР

# 2026 оны ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

**“Ёс зүй, сахилга, хариуцлага, хяналт, бүтээмжийг дээшлүүлэх” жил**




7021 0021
portal.ndaatgal.mn
Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар

Агуулга:

1. Статистик мэдээ ........................................................................................................3
2. Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт, санхүүгийн үзүүлэлтийн мэдээ..4
3. Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмжийн мэдээ...........................11
4. Үйл ажиллагааны санхүүгийн мэдээ............................................................................17
5. Хяналт, шалгалтын мэдээ..........................................................................................19
6. Хууль тогтоомжийн биелэлтийн мэдээ......................................................................25
7. Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг иргэдэд таниулах ажлын мэдээ...............36
8. Дүүргийн төр захиргааны байгууллагын даалгасан ажлын мэдээ.............................39

# БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН

2026 оны 06 дугаар сарын 12 Багануур дүүрэг

## ЭХЛЭЛ

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар нь тайлант хугацаанд шинээр мөрдөгдөж буй Нийгмийн даатгалын багц хууль, бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газар, нийслэл, дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийгэм эдийн засгийн зорилтод тусгагдсан Нийгмийн даатгалын тухай хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдон төрийн захиргааны удирдах дээд шатны байгууллагуудаас гаргасан тушаал, захирамж, тогтоол, шийдвэр, албан даалгаврыг биелүүлж, хэрэгжилтийг ханган ажиллав.

Тайлант хугацаанд ажил олгогч даатгуулагчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэн хамгаалж, хууль дээдлэн, бусдын нөлөөнд үл автан ажиллах зарчмыг баримтлан,  дүүргийн нутаг дэвсгэрт нийгмийн даатгалын хуулийг хэрэгжүүлж, хамрах хүрээг өргөжүүлэх, сангийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг  зохих сангаас, хуулиар тогтоосон цаг хугацаанд тогтоон, Sicos цахим системээр бүртгэж, олголоо.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны А/01 дүгээр тушаалаар тайлант оныг “Ёс зүй, сахилга, хариуцлага,  хяналт, бүтээмжийг  дээшлүүлэх жил” болгон зарласан. Зорилтот жилийн хүрээнд Нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах, ажил олгогчдыг дэмжих, нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд, даатгуулагч, харилцагчид  чирэгдэлгүй, шуурхай, ил тод, нээлттэй хүргэх, мэдээллийн системийн шинэчлэлийг тогтворжуулах, цахим үйлчилгээг өргөжүүлэх зорилт тавин ажиллаж байна.

# НЭГ. СТАТИСТИК МЭДЭЭ

2026.05.31-ний өдрийн байдлаар



## ХОЁР: НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН МЭДЭЭ

2026 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 16,170,640.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс 16,644,752.77 мянга төгрөг төвлөрүүлж (ЭМД орлого ороогүй дүнгээр), төлөвлөгөөг 102.9%-иар биелүүлэв.

2.1.Орлогыг сан тус бүрээр харуулбал: (мян.төг)

| д/д | Сан | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
|---|---|---|---|---|
| 1 | Тэтгэвэр | 13,379,39.30 | 13,510,700.80 | 100.98 |
| 2 | Тэтгэмж | 1,390,390.60 | 1,434,526.90 | 103.17 |
| 3 | ҮОМШӨ | 892,055.20 | 1,187,391.86 | 133.11 |
| 4 | Ажилгүйдэл | 508,805.50 | 512.133.20 | 100.65 |
| Дүн | | 16,170,640.60 | 16,644,752.77 | 102.93 |

2.2.Нийгмийн даатгалын сангийн зарлага

1. Тэтгэврийн даатгалын сан (мян.төг)

| | Тэтгэврийн төрөл | Хүний тоо | Дүн |
|---|---|---|---|
| 1 | Өндөр нас | 4394 | 23,461,957.53 |
| 2 | ХЧА-ны тэтгэвэр | 449 | 1,665,325.76 |
| 3 | Тэжээгчээ алдсан | 223 | 863,995.24 |
| 4 | Цэргийн өндөр нас | 323 | 2,452,084.42 |
| Дүн | | 5389 | 28,443,362.95 |

2. Тэтгэмжийн даатгалын сан (мян.төг)

| | Тэтгэмжийн төрөл | Хүний тоо | Дүн |
|---|---|---|---|
| 1 | ХЧТА | 604 | 311,184.97 |
| 2 | ЖАТ | 170 | 783,289.19 |
| 3 | НБДГБГ олгох тэтгэмж | 56 | 174,000.00 |
| Дүн | | 58 | 1,268,474.16 |

3.ҮОМШӨ-ий даатгалын сан (мян.төг)

| | Төрөл | Хүний тоо | Дүн |
|---|---|---|---|
| 1 | Тахир дутуугийн тэтгэвэр | 129 | 909,800.07 |
| 2 | Тэжээгчээ алдсаны тэтгэвэр | 16 | 102,763.38 |
| 3 | Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний зардал | 91 | 108,240.00 |
| 4 | ҮОМШӨ Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж | | 0.0 |
| 5 | ХЧТА | 2 | 1,772.56 |
| Дүн | | 239 | 1,122,576.01 |

4.Ажилгүйдлийн даатгалын сан (мян.төг)

| д/д | Төрөл | Хүний тоо | Дүн |
|---|---|---|---|
| 1 | Ажилгүйдлийн тэтгэмж | 187 | 1,101,697.99 |

| | | | |
|---|---|---|---|
| 2 | Сургалтын зардал | | 0 |
| | Дүн | 187 | 1,101,697.99 |

Нийгмийн даатгалын сангийн зардлын төлөвлөгөө гүйцэтгэл (мян.төг)

| | Сан | Төлөвлөгөө | гүйцэтгэл | Хэмнэлт |
|---|---|---|---|---|
| 1 | Тэтгэвэр | 28,616,029.80 | 28,446,116.11 | 169,348.68 |
| 2 | Тэтгэмж | 1,517,233.70 | 1,274,146.51 | 243,087.18 |
| 3 | ҮОМШӨ | 1,507,551.60 | 1,142,350.43 | 708,927.41 |
| 4 | Ажилгүйдэл | 1,101,828.30 | 1,101,752,12 | 76.8 |
| Дүн | | 32,742,643.40 | 31,964,365.17 | 778,278.23 |

Тайлант хугацаанд сангийн зардлын батлагдсан төсвийн хүрээнд 32742,6 сая төгрөг зарцуулахаас, 31964,9 сая төгрөг зарцуулж 97,6 хувийн гүйцэтгэлтэй байна.

2026.05.31-ны өдрийн байдлаарх санхүүжилт, төвлөрүүлэлт (мян.төг)

| | Сангийн төрөл | Санхүүжилт | Төвлөрүүлсэн мөнгө |
|---|---|---|---|
| 1 | Төвлөрсөн харилцах | | 19,084,037.07 |
| 2 | Тэтгэвэр | 22,523,030.72 | |
| 3 | Тэтгэмж | 1,306,340.47 | |
| 4 | ҮОМШӨ | 1,413,129.10 | |
| 5 | Ажилгүйдэл | 1,097,451.60 | |
| | Дүн | 26,339,951.90 | 19,084,037.07 |

Улсын төсвийн санхүүжилт (мян.төгрөг)

| | | Дүн |
|---|---|---|
| 1 | Тэтгэвэр | 9,179,183.50 |
| 2 | Тэтгэмж | 1,680,30 |
| 3 | ҮОМШӨ | 33,287.30 |
| | Дүн | 9,214,151.11 |

2.3.Орлого, шимтгэлийн талаар

Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж 2026 оны эхний 5 сард 45,177.1 мянган төгрөгийн цалингийн сантай 41 ажил олгогчийн 35 даатгуулагчийг шинээр хамруулсан байна.

"Хуулийн этгээд шинээр бүртгүүлж байгаа иргэдэд зориулан НДЕХ-ийн 20.1, Зөрчлийн тухай хуулийн 10.17.1 дэх заалт, харьяалах Нийгмийн даатгалын байгууллагад нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлэх зөвлөмж бүхий зурагт хуудас (постер)-ыг бэлтгэн, Санхүү, төрийн сангийн хэлтэс Улсын бүртгэлийн хэлтэс, Татварын хэлтэс, нотариат болон цахим орчинд байршуулж, зарим газрын удирдлага, албан хаагч нартай ажил хэргийн уулзалт хийж ажилласнаар тайлант хугацаанд шинээр 41 ажил олгогч хамруулж, хамралт 107.7 хувийн, албан журмын даатгуулагч өссөн дүнгээр хагас жилд 60 даатгуулагч шинээр хамруулахаас тайлант хугацаанд нийт 72 даатгуулагч хамруулж 120 хувийн биелэлттэй байна.



Авлагын насжилтийн судалгааг сард 2 удаа гаргаж, 30-аас дээш хоногийн насжилттай шимтгэлийн өр төлбөрийг ажил олгогч нарт сануулж, төлөхийг шаардан, тогтмол утсаар харилцах, шимтгэл төлөх данс мөнгөн дүнг мэссэжээр илгээх, “БНД-НДХ-Ажил олгогч” групп дээр шимтгэл төлөх хугацаа, хугацаандаа төлөөгүй тохиолдолд тооцох арга хэмжээ, эрсдэлийг сануулах постыг тогтмол нийтэлж, тус газрын пэйж хуудсаар шимтгэл төлөх хугацаа, дансны мэдээллийг байршуулан түгээх зэргээр цахим мэдээллийг түгээлээ.

2.4.Авлагын мэдээ

2026 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 6,744,439.4 мянган төгрөг, өглөг 32,624.8  мянган төгрөг байна. Үүнээс Эрүүл мэндийн төвийн НДШ-ийн өр 3,593,981.0 мянган төгрөг болж, тайлант оны нийт авлагын 53,2 хувийг дангаараа эзэлж байна.

Тайлант хугацааны нийт авлагын 96,6 хувь нь 10,0 сая төгрөгөөс дээш өртэй дараах 30 ажил олгогчийн авлага байна.

*Хүснэгт №1*

| | | |
|---|---|---|
| 1 | Багануур Авто зам арчлалтын нэгтгэл | 18,375,651.24 |
| 2 | БАГАНУУР ХК | 822,708,240.29 |
| 3 | Багануур Дулаан Станц ТӨХК | 570,355,071.29 |
| 4 | Багануур Тохижилт ОНӨААТҮГ | 205,993,565.53 |
| 5 | Багануур дүүргийн Боловсрол төв | 13,249,841.00 |
| 6 | Боловсрол сургууль | 22,390,299.76 |
| 7 | Оюуны Эрин сургууль | 95,771,238.90 |
| 8 | 288-р цэцэрлэг | 42,604,887.40 |
| 9 | 131-р цэцэрлэг | 29,705,692.84 |
| 10 | 139-р цэцэрлэг | 33,552,028.55 |
| 11 | Багануур Нийгмийн даатгалын газар | 11,693,349.06 |
| 12 | Багануур Эрүүл мэндийн төв | 3,593,981,084.63 |
| 13 | МЗХНН Төмөр зам Багануур өртөө | 28,551,849.67 |
| 14 | Вагон ашиглалтын депо | 22,384,560.44 |
| 15 | Багануурын Залуус төв | 15,856,778.70 |
| 16 | Брилиантын ундарга ХХК | 12,890,000.00 |
| 17 | Замбага трейд ХХК | 20,471,280.33 |
| 18 | МИМС ХХК | 53,914,480.19 |
| 19 | Мон цахим ХХК | 73,800,314.83 |
| 20 | Соёолон групп ХХК | 379,596,829.34 |
| 21 | Энеркон менежмент партнерс ХХК | 44,939,387.83 |
| 22 | Тэргэл прайм пропертиз ХХК | 67,470,816.93 |
| 23 | ЦНС ХХК | 26,195,745.25 |
| 24 | Энх өрх | 14,357,373.63 |
| 25 | Их чонос ХХК | 18,155,869.28 |
| 26 | Багануур Зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК | 144,277,408.33 |
| 27 | БЗӨБЦТСүлжээ компанийн Багануур салбар | 89,871,261.46 |
| 28 | Багануур мах маркет ХХК | 11,880,000.00 |
| 29 | Багануур Үйлдвэр технологийн парк | 16,985,489.13 |

| | | |
|---|---|---|
| 30 | Багануур сувилал ХХК | 14,278,253.05 |
| **ДҮН** | | **6,516,258,648.88** |

Эдгээр 30 ажил олгогчоос :

- Боловсрол төв, сургууль, цэцэрлэг зэрэг төсөвт 7 ажил олгогчийн авлага 248,967.3 мянган төгрөг буюу авлагын 3.7%,
- төрийн өмчит 4 компанийн авлага 1,627,211.9 мянган төгрөг буюу авлагын 24.1%,
- аж ахуйн тооцоот 4 байгууллагын авлага 257,211.4 мянган төгрөг буюу авлагын 3.8%,
- төмөр замын 2 байгууллагын авлага 50,936.4 мянган төгрөг буюу авлагын 0.7%,
- нэг өрхийн эмнэлгийн авлага 14,357.4 мянган төгрөг буюу авлагын 0.2%,
- Эрүүл мэндийн төвийн авлага 3,593,981.0 мянган төгрөг буюу авлагын 53.2%,
- хувийн хэвшлийн ажил олгогчдоос 723,592.9 мянган төгрөг буюу авлагын 10.7%-ийг тус тус эзэлж буй үзүүлэлттэй байна.




Тайлант хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн авлага үүсгэсэн 21 ажил олгогчтой 359,8 сая төгрөгийн өр авлага барагдуулах уулзалт хийж 19 ажил олгогчоос 254,1 сая төгрөг, 14,9 сая төгрөгийн өртэй 5 ажил олгогчид албан шаардлага хүргүүлж 3 ажил олгогчоос 4,2 сая төгрөг тус тус барагдуулсан.

Нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан авлага үүсгэсэн 91-180 хоногийн насжилттай нийт 919,3 сая төгрөгийн өртэй 7 ажил олгогчид дансны зарлагын гүйлгээг зогсоох мэдэгдэл хүргүүлж 5 ажил олгогчийн 109,1 сая төгрөг барагдуулж, 808,2 сая төгрөгийн өртэй 2 ажил олгогчийн дансны зарлагын гүйлгээг зогсоож 636,8 сая төгрөг, нийт 745,9 сая төгрөг тус тус барагдуулсан байна. 271 хоногоос дээш насжилттай 3,158.5 сая төгрөгийн хуримтлагдсан авлагатай 11 ажил олгогчид шүүхийн байгууллагад шилжүүлэх тухай мэдэгдэл хүргүүлж, 6 ажил олгогч нийт 221,2 сая төгрөг барагдуулсны дотор 3 ажил олгогчийн авлагыг бүрэн барагдуулж, 3 ажил олгогчтой үлдэх өр төлбөрийг барагдуулахаар уулзалт хийж, төлөлт хийгээгүй 5 ажил олгогчийг шүүхэд шилжүүлэхээр ажиллаж байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй нэр бүхий ажил олгогчдыг тайлант оноос өмнө шүүхэд шилжүүлж шийдвэрлүүлснээс, шийдвэр гүйцэтгэлийн шатанд байгаа дараахь байгууллагууд байна. Үүнд:

*Хүснэгт №3*

| д/д | ААН-ийн нэр | Мөнгөн дүн төгрөгөөр |
|---|---|---|
| **1** | МИМС ХХК | 53,914,480.19 |
| **2** | ЦНС ХХК | 21,033,721.00 |
| **3** | Соёолон групп ХХК | 559,960,660.00 |
| **Дүн** | | 634,908,861.19 |

Тайлант хугацаанд 2025 оны шүүхийн шийдвэрийн 2,9 сая төгрөгийн шимтгэлийн үлдэх төлбөртэй нэг ажил олгогчийг шүүхэд албадан гүйцэтгүүлэхээр нэхэмжлэл гарган шийдвэрлүүлж, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд нэмж шилжүүлснээр авлагыг бүрэн барагдуулсан.

*Хүснэгт №4*

| **д/д** | **Аж ахуйн нэгжийн нэр** | **Мөнгөн дүн** |
|---|---|---|
| **1** | Эг тавт ХХК | 2,999,340.00 |
| | | 2,999,340.00 |

Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулах ажлын хүрээнд ажил олгогчийн хариуцлагын хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, хаяг, утасны дугаар, цахим хаяг зэрэг мэдээллийг тухай бүр ажил олгогчоос албан хүсэлт болон улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг авч өөрчлөн шинэчилж мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлэн ажиллаж хэвшсэн. Шинээр бүртгүүлж байгаа болон бүртгэлтэй ажил олгогчийн удирдлага, санхүүгийн ажилтнууд солигдох тухай бүр албан хүсэлтийг үндэслэн улсын бүртгэлийн гэрчилгээ, тушаал, бичиг баримтын үндэслэлийг шалган бүрдүүлж шинэчлэгдсэн мэдээллийг системд өөрчлөн бүртгэж ажиллаж байна.

Тайлант хугацаанд шинээр шимтгэл төлөгч ажил олгогчоор бүртгүүлэх, дарга, захирал, эрхлэгч болон нягтлан бодогч солигдсон, байгууллагын нэр, хэлбэр өөрчлөгдсөн, регистрийн дугаар шинэчлэгдсэн зэрэг нийт 81 ажил олгогчийн ирүүлсэн баримтыг үндэслэн ажил олгогчийн мэдээллийг үнэн зөв бүрдүүлж ажиллав. Цахим хэлбэрээр ирүүлсэн тайланг хянан баталгаажуулах тухай бүр ажил олгогчийн шинээр томилогдсон ажилтны даатгуулагчийн төрөл кодыг зөв сонгосон эсэхэд түүврээр хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд ажил олгогчтой холбогдон даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүрдүүлэн ажиллаж, 56 даатгуулагчийн мэдээллийг нягтлан шалгасан байна.

Ажил олгогчид даатгуулагчдын төрлийн кодыг зөв бүртгэх, тушаал шийдвэрийг цахим мэдээллийн санд тухай бүр үнэн зөв оруулж бүртгэж байх, эмнэлгийн хуудас, түүний бодолт дээр гарч буй нийтлэг анхаарах зүйлүүдийг байгууллагаар үйлчлүүлсэн тухай бүр зөвлөн тусалж, алдаа зөрчил гарсан тухай бүр тайланг засуулж, мэдээллийн баазын үнэн зөв бүрдүүлэлтэд анхаарч ажилласан.

Программ хангамжийг зөв зохистой, процессын зураглалын хүрээнд горимын дагуу ашиглах, мэдээллийг зөвшөөрөлгүйгээр тараахгүй, түгээхгүй байхад анхаарч, шинээр бүртгүүлсэн ажил олгогчийн мэдээллийг тухай бүр мэдээлэл технологийн ажилтанд мэдэгдэг, ажил олгогчийн хуваарилалтыг системд хийлгэж, тайлант хугацаанд шинээр бүртгэгдсэн 41 ажил олгогчийг хуваарилуулав.

Оны эхний 5 сарын байдлаар нэг даатгуулагчийн илүү төлсөн шимтгэлээ буцаан авах хүсэлтийг хүлээн авч тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдлийн даатгалын сангаас нийт 2,1 сая төгрөгийн буцаалтыг олгож, 3 даатгуулагчийн регистрын дугаар нэгтгэх хүсэлтийг хүлээн авч, материалыг нягтлан шалгаж зөв регистрийн дугаар дээр нэгтгэж тус тус өргөдөл хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.

Ажил олгогч байгууллагуудын нэр, хэлбэрээ өөрчлөх 2 албан хүсэлт, регистр шинэчилсэн 3 ажил олгогч, удирдлага, санхүүгийн ажилтаны мэдээлэл шинэчлэх нийт 27 ажил олгогчийн албан хүсэлтийг хүлээн авч тухай бүр мэдээллийн баазад шинэчлэлийг оруулж хуулийн хугацаанд  шуурхай шийдвэрлэж ажилласан.

НДЕГ-ын даргын 2026 оны 2 дугаар сарын А/45 дугаар тушаалаар баталсан ажил олгогчийн удирдлага, хүний нөөц, санхүүгийн ажилтнуудад "Нийгмийн даатгалын хууль эрх зүйн болон практик" сургалтыг тайлант оны турш сар бүрийн 2 болон 4 дэх долоо хоногийн Лхагва гарагт зохион байгуулах ажлын хүрээнд бүртгэлтэй ажил олгогч болон шинээр НДШ

төлөгчөөр бүртгүүлж буй хуулийн этгээдийн захирал, нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтнуудыг сургалт мэдээлэлд бүрэн, идэвхитэй хамруулахыг зорин ажиллаж байна.

Сургалтын зар мэдээг ажлын байранд 73 ажил олгогчид, явуулын үйлчилгээгээр 23 ажил олгогчид биечлэн хүргэв. Мөн дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд оролцогчдод газрын дарга мэдээлэл өгч, сургалтын зарыг албан бичгээр удирдлагуудад хүргэв. Түүнчлэн цахим хэлбэрээр “БНД-НДХ Ажил олгогчид” цахим группэд 4 удаа, мэйл хаягаар 108 ажил олгогчид, албан хэрэг хөтлөлтийн ERP-edoc системээр 106 ажил олгогчид тус тус хүргүүлж ажилласан.

Дээрх сургалтыг зохион байгуулсан тухай болон сургалтын зарыг Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын цахим хуудсаар нийт 8 удаа байршуулан ажилласан байна. Нийт 6 удаагийн сургалтад 131 байгууллагын 176 албан тушаалтанг идэвхитэй хамруулан ажиллалаа. Тайлант оны 3 дугаар сард 29 байгууллагын 41, 4 дүгээр сард 23 байгууллагын 25, 5 дугаар сард 79 байгууллагын 110 нийт 131 байгууллагын 176 албан хаагч сургалтад хамрагдаж нийгмийн даатгалын ойлголт мэдлэг, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг бэлтгэх, илгээх дадал, ур чадвараа дээшлүүлэв.

Тайлант хугацаанд “БНД-НДХ Ажил олгогчид” цахим группэд ажил олгогч нарт зориулж нийт 52 удаагийн пост мэдээллийг тухай бүр оруулж ажилласан байна. Тус группыг идэвхитэй ажиллуулснаар цаг үеийн мэдээ, мэдээллийг шуурхай хүргэж, сар бүрийн тайлан, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, тайлангийн хугацааг сануулах, орлогын дансдыг байршуулж мэдээлэх, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хуулийн хугацаанд ирүүлэх, тайланд тавигдах шаардлага, тайлан гаргахдаа анхаарах асуудал зэргийг тогтмол сануулж ажилласнаар нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг сардаа буюу хуулийн хугацаанд багтаан төлөх, тайланг хуулийн хугацаанд багтаан ирүүлэхэд үр дүнтэй байна.

2.5.Сайн дурын даатгалын талаар

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Төлөвлөгөө батлах тухай” А/19 дүгээр тушаалаар шинээр хамруулах ажил олгогч, албан журмаар даатгуулагч, сайн дураар даатгуулагчийн тоон төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөө ёсоор 2026 онд шинээр 370, тайлант хугацаанд 154 даатгуулагчийг сайн дурын даатгалд шинээр хамруулахаас 211 даатгуулагчийг хамруулж, төлөвлөгөөг 137 хувиар биелүүлээд байна.

Шинээр хамруулсан сайн дурын даатгуулагчдыг төрлөөр нь ангилбал малчин 40, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх 12, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эх /эцэг/ 8, бусад 151 иргэн байна.

Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай хүүхдээ асарч байгаа эх /эцэг/-ийн шимтгэлийг төрөөс төлнө.

Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч ажил хөдөлмөр эрхлээгүй эх, эсхүл эцэг сайн дурын даатгалд даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийг улсын төсвөөс сар бүр төлнө.

Тус зохицуулалтын хүрээнд дүүргийн бүх хороодод 2026 оны 02 дугаар сард 03/23 “Хамтран ажиллах тухай” албан бичиг илгээж эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эх /эцэг/-ийн судалгаа авсан. Судалгаагаар эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эх /эцэг/ 120 иргэн байна.

Үүнээс: Тэтгэвэр авагч 4, албан журмаар даатгуулагч 46 иргэн байна. Сайн дурын даатгалд хамрагдвал зохих 65 иргэдтэй уулзалт хийж, утсаар холбогдон мэдээлэл, зөвлөгөө хүргэлээ. Ингэснээр тайлант хугацаанд даатгуулсан нийт 39 иргэнээс 8 иргэнийг шинээр сайн дурын даатгалд хамруулав.

Малчин, туслах малчин сайн дурын даатгалд даатгуулах бол тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд ногдох тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс сар бүр төлнө. Улсын төсвөөс хариуцан төлөх хугацаа 5 жилээс ихгүй байна.

Тус зохицуулалтын хүрээнд дүүргийн хороодоос малчдын судалгааг авч нэгтгэхэд 1022 малчин (мал бүхий иргэн) байна. Үүнээс: өндөр насны тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар алдсаны болон цэргийн алба хаасны тэтгэвэр авагч 277, албан журмаар даатгуулагч 275 иргэн байна. Сайн дурын даатгалд хамрагдвал зохих 470 иргэдтэй уулзах, утсаар ярих зэргээр мэдээлэл хүргэж, зөвлөгөө өгөв. Ингэснээр тайлант хугацаанд холбогдсон нийт 187 иргэнээс 40 иргэнийг шинээр сайн дурын даатгалд хамруулсан байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3, мөн зүйлийн 6, 7 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 485 дугаар тогтоолыг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан хүүхдээ 3 нас хүртэл асарч байгаа эхчүүд нийгмийн даатгалын сангаас жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх үүссэн бол төлөх шимтгэлийн 50 хувийг өөрөө, үлдэх 50 хувийг тэтгэмжийн даатгалын сангаас төлөх, бусад эхийн төлбөл зохих шимтгэлийн 50 хувийг улсын төсвөөс, 50 хувийг даатгуулагч эх өөрөө төлөхөөр зохицуулсан.

Тайлант хугацаанд дээрх зохицуулалтын хүрээнд нийгмийн даатгалын сангаас болон улсын төсвөөс шимтгэлийг хариуцаж төлж буй 142 даатгуулагч эх байна.

Тайлант онд шинээр даатгуулагчдыг төрлөөр нь ангилан өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал:




Дээрх графикаас харвал сайн дурын даатгуулагчийн тоо өмнөх онтой харьцуулахад өсөлт, бууралт хэвийн байна. Сайн дурын даатгалын малчин, туслах малчны, эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай 18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асардаг ажил хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/-ийн төрлөөр даатгуулагчдын тоо өмнөх оны мөн үеэс өссөн шалтгаан нь иргэд даатгуулагчдад сайн дураар даатгуулахын ач холбогдлын талаар зөвлөгөө мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна.

Тэгвэл тайлант оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 923 иргэн сайн дурын хэлбэрээр нийгмийн даатгалд хамрагдсан байна. Нийт даатгуулагчдыг төрлөөр харуулбал:

*Хүснэгт №02*

| | Даатгуулагчийн төрөл | /2025.01.01- 05.31/ даатгуулагчийн тоо | /2026.01.01- 05.31/ даатгуулагчийн тоо | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 1 | Шинээр | 188 | 191 | 0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | Даатгуулагч эх | 14 | 12 | -2 |
| 3 | Хөгжлийн бэрхшээлтэй асарч байгаа эх /эцэг/ | 5 | 8 | 3 |
| 4 | Сунгасан | 759 | 712 | -47 |
| Нийт дүн | | 966 | 923 | -46 |

Нийгмийн даатгалын санд 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 966 даатгуулагчийн 456,7 сая төгрөг, 2026 оны мөн үед 923 даатгуулагчийн 456,1 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

Орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх зорилгоор шүүлт хийж, сайн дурын даатгалын гэрээ дуусах хугацаа дөхсөн, гэрээний хугацаанд шимтгэл төлөөгүй 659 даатгуулагчийн мэдээллийг нягталж тодруулан утсаар ярих, уулзах зэргээр мэдээлэл хүргэж, зөвлөгөө өгөв. Гэрээний хугацаанд сайн дурын даатгалын шимтгэл төлөөгүй 217 даатгуулагчид 8,3 сая төгрөгийн алданги ногдуулж, бүрэн төлүүллээ.

Тайлант оны эхэнд 299 даатгуулагчийн 8,0 сая төгрөгийн өглөгөөс 37 даатгуулагчийн 4,0 сая төгрөгийн өглөгийг барагдууллаа. Мөн оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 487 даатгуулагчид 32,0 сая төгрөгийн өглөгтэй байна. Даатгуулагчид бүтэн жилээр даатгалын шимтгэлийг урьдчилан төлсөнөөр өглөгийн оны эхний үлдэгдэл өссөн байна.

Нийт даатгуулчдын 93,8% буюу 866 иргэн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр орлого тодорхойлж сайн дураар даатгуулж байна.

Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын 02/31 Сайн дурын даатгуулагчийн массив, 02/32 Сайн дурын даатгуулагчийн гэрээг жагсаалтын дагуу үйлдэн 4 боть материалыг цаасан болон цахим хэлбэрээр Архивын ажилтанд хуулийн хугацаанд хүргүүлсэн.

2026 оны 03 дугаар сард “Оюуны Эрин”, Гүн галуутай”, “Боловсрол” сургуульд, 04 дүгээр сард 4 дүгээр хорооны “Төлчин бүсгүйчүүд” уулзалт, 05 дугаар сард “Багануур тохижилт” ААТҮГ-т, нийт 5 удаагийн сургалт, уулзалтын үеэр 411 иргэнд сайн дурын даатгалын талаар мэдээлэл хүргэж, зөвлөгөө өгч ажиллалаа.

Нийгмийн даатгалын шинэчлэн батлагдсан багц хуулийг иргэд даатгуулагчдад сурталчлан таниулах мөн шинэ Sicos систем нэвтрүүлсэнтэй холбоотойгоор программд даатгуулагчдын мэдээллийг үнэн зөв бүртгэх, сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, гэрээний төрөл шинэчлэн бүртгэх зэрэг цаг үеийн ажлуудыг гүйцэтгэж ажиллав.

## ГУРАВ:НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН МЭДЭЭ

### 3.1.Ерөнхий мэдээлэл

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын мэдээллийн шинэ системээр бүтээгдэхүүн, хүсэлт бүрийг шийдвэрлэн, олгож, сангийн санхүүгийн тайланг шинэ системээр хуулийн хугацаанд гаргаж тайлагнасан мэдээллийн системийн ахиц дэвшил өндөртэй жил боллоо.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулинд зохицуулснаар Итгэлцүүрийг шинэчлэн тогтоож, 2026 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдсөн, мөн тэтгэврийг нэмэгдүүлэх тухай Засгийн газрын 2025 оны 242 дугаар тогтоолоор тэтгэврийг 80.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэв. Энэхүү нэмэгдлээр тус дүүргийн 5467 тэтгэвэр авагчийн тэтгэвэр 437,360.00 мянган төгрөгөөр өссөн байна.

Даатгуулагч иргэн цаг хугацаа, орон зайнаас үл хамааран нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хүсэлт цахимаар илгээх боломж бүрдлээ.

Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан 2026-2028 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох насны иргэдийн судалгааг бүх хороодоос авч, дүүргийн Засаг даргын тамгын газар, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтран  “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян”-ы хаалтын үйл ажиллагаанд оролцож дүүргийн аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭА хариуцсан ажилтан, хүний нөөцийн мэргэжилтнүүдэд ажилчдын эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, тэднийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулж байх чиглэл өгч дүүргийн үйлдвэрийн осол болон халдварт бус өвчний өвчлөлийн үзүүлэлтээр мэдээлэл хийж ажиллалаа.

Нийгмийн даатгалын газрын үзүүлсэн тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ, олголтын “Тойм мэдээ”, нийгмийн даатгалын хуулийн шинэчлэл болон үйлчилгээний талаарх мэдээллийг дижитал хэлбэрээр /постер, рийл/ бэлтгэн сар бүр байгууллагын цахим хуудсаар мэдээлж, олон нийтэд ил тод, шуурхай, хүртээмжтэй байдлаар хүргэж байна.

Нийгмийн даатгалын багц хууль, “Тэтгэмж авахад бүрдүүлэх баримт бичгийн бүрдэлд хяналт тавих журам”, “Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журам”, дээд газраас ирсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн тэтгэмжийн даатгалын сангаас 1368 даатгуулагч, хүний /давхардсан тоогоор/ хүсэлтийг хүлээн авч 1,268,474.2 мянган төгрөгийн, ажилгүйдлийн даатгалын сангаас 107 даатгуулагчийн хүсэлтийг хүлээн авч /давхардсан тоогоор/ 187 даатгуулагчид 1,101,698.0 мянган төгрөгийн, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 88 даатгуулагчийн /давхардсан тоогоор/ хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн 111,314.9 мянган төгрөгийн тэтгэмж, төлбөр хянаж, тогтоож, олгосон байна.







Даатгуулагч иргэдийн цахим хэрэглээ хангалтгүй, гар утасны хүчин чадлаас шалтгаалж цахим хүсэлт илгээх, цахимаар хүсэлт шийдвэрлэлт, олголтоо хянаж чадахгүй байдал, ажилгүйдлийн сангийн санхүүжилт хүрэлцэхгүйгээс шалтгаалсан утсан харилцааны ачаалал ихсэж байцаагчийн өдөр тутмын ажлын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж байна. Иймээс цахим үйлчилгээ, даатгуулагчийг чиглүүлэх, угтах үйлчилгээний ажилтны орон тоо, үйлчилгээний заалand интернетийн эрхтэй компьютер зайлшгүй шаардлагатай байдаг.

Эмнэлгийн хуудас бичилт, хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, ажилгүйдлийн тэтгэмжийн хүсэлт 100% цахимжсан, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хүсэлт цахимжсан боловч иргэд төдийлөн цахимаар хүсэлт гаргах хүсэлгүй байна. www.protal.ndaatgal.mn болон мэдээлэл солилцооны E-Mongolia системээс гаргасан хүсэлтийнхээ шийдвэрлэлтийн явц, олголтын хуваарийг харах бүрэн боломжтой болсныг даатгуулагчдад сурталчилж, зөвлөн туслаж ажиллаж байна.

3.2.Тэтгэмжийн даатгалын сан

3.2.1.Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж

Давхардсан тоогоор 1134 даатгуулагчийн хүсэлтийг хүлээн авч, эмнэлгийн хуудсыг магадлагч эмчээр, тэтгэмж тогтоолтыг хяналт шалгалтын байцаагчаар тус тус хянуулж, баталгаажуулан, 327,775.3 мянган төгрөгийн тэтгэмж тогтоож, 311,185.0 мянган төгрөгийн тэтгэмж олгосон байна.




3.2.2.Жирэмсний болон амаржсаны тэтгэмж

176 даатгуулагчийн цахим хүсэлтийг хүлээн авч эмнэлгийн хуудасны үндэслэлийг магадлагч эмчээр, тэтгэмж тогтоолтыг хяналт шалгалтын байцаагчаар тус тус хянуулж, баталгаажуулан 848947.6 мянган төгрөгийн тэтгэмж тогтоож, 783,289.2 мянган төгрөгийн жирэмсний болон амаржсаны тэтгэмж олголоо.




3.2.3. Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж

Тайлант хугацаанд нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хүсэлт гаргасан 58 иргэний бүрдүүлсэн баримт материалыг шалган хүлээн авч, 174,000.0 мянган төгрөгийн тэтгэмж тогтоож, 24 цагийн дотор олгосон байна. Эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолтоор амьгүй донор болж тэтгэмж авсан тохиолдол гараагүй.

3.2.4.Ажилгүйдлийн тэтгэмж

Холбогдох хуульд заасан болзол нөхцөлийг хангаж, ажилгүйдлийн тэтгэмж авах эрх үүссэн даатгуулагчийн цахим хүсэлтийг хүлээн авч ажилгүйдлийн тэтгэмжийн хувийн хэрэг бүрдүүлж ажиллалаа. Нийт 107 хүсэлтийг шийдвэрлэн, 1,100,610.2 мянган төгрөгийн тэтгэмж тогтоож олголоо.

Харъяаллын бус даатгуулагчийн хүсэлтийг цахимаар илгээхэд тусалж, ажил олгогч нь шимтгэлийн хуримтлагдсан өртэй даатгуулагчийн хүсэлтийг өргөдөл гомдол шийдвэрлэх хуулийн хугацаанд хүлээж, шимтгэл нь төлөгдөөгүй тохиолдолд хүсэлтийг цуцлан, ажил олгогчид тогтоогдсон тэтгэмжийн дүн, тухайн тэтгэмжийг бүрэн хариуцаж даатгуулагчид төлөх хуулийн зүйл заалтыг мэдэгдэж, ажил олгогч даатгуулагч хоёрыг холбож өгч ажиллаж байна.




2025 оны ажилгүйдлийн тэтгэмжийн санхүүжилт улсын хэмжээнд хүрэлцээгүй байдлаас шалгаалан тухайн оны 10,11,12 дугаар сарууддад олгох тэтгэмж 492,782.88 мянган төгрөгийг 2026 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн дотор олгож дуусгасан. Тайлант хугацаанд санхүүжилт 4.4 сая төгрөгөөр дутуу, мөн тогтоогдсон тэтгэмж төлөвлөгдсөн хэмжээнээс өндөр байгаагаас 5 дугаар сарын 31-ний байдлаар 144,855.7 мянган төгрөгний тэтгэмж олгоогүй байна.

3.2.5.ҮОМШӨ-ний даатгалын сангийн мэдээ

Тайлант хугацаанд давхардсан тоогоор 88 хүсэлт хүлээн авч, хуулийн хугацаанд шийдвэрлэжээ. Тус сангаас 82 даатгуулагчид сэргээн засах сувиллын зардал 108,240.0 мянган төгрөг, 1 даатгуулагчид сувилалд ирж очих унааны зардал 92.3 мянган төгрөг, 3 даатгуулагчид давхардсан тоогоор 1,772.6 мянган төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, 1 даатгуулагчид протез, ортопедийн зардлын төлбөр 1,210.0 мянган төгрөг нийт 111,314.9 мянган төгрөгийн тэтгэмж, төлбөрийг тогтоож, олгосон байна

Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 11 дүгээр тогтоолыг хэрэгжүүлж 2026.01.01-ний өдрөөс сэргээн засах болон сувиллын тусламж, үйчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санаас олгох хэмжээг нэг ор хоногийн 110000 төгрөгөөр тооцож байна.

3.3.Тэтгэврийн зөвлөн туслах үйл ажиллагаа

Тайлант хугацаад давхардсан тоогоор 583 иргэнд Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль болон эдгээр хуулийг хэрэгжүүлэх тухай журам, заавар, зөвлөмж, бусад холбогдох хууль тогтоомжуудыг сурталчлах, хэрэгжилтийг хангуулах талаар иргэд даатгуулагчдад хууль эрх зүйн зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж үйлчиллээ.

Тэтгэвэр тогтоолгох баримт бичгийн бүрдэл шалгуулах, шимтгэл төлж ажилласан жил хэрхэн тооцох, тэтгэвэр тогтоолгох насны болзол, тэтгэвэр тогтоолгох нөхцөл, болзол, нэмэгдүүлсэн насны болзол, хөдөлмөрийн хөнгөлттэй нөхцлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгох болзол, тусгай зохицуулалт, тэтгэврийн өөрчлөлт, олголт зэрэг асуудлаар

даатгуулагч, тэтгэвэр авагч иргэдэд цахимаар, утсаар болон биечлэн зөвлөгөө өгч, тэтгэвэр тогтоолгоход шаардагдах баримт бичгийн бүрдэл, зөрчлийг арилгах, урьдчилсан тооцоолол хийлгэхээр ирсэн даатгуулагчид мэдээлэл зөвлөгөө өгч зөвлөмжийн хуудас 57 даатгуулагчид бичиж өгч, бүртгэл хөтлөн ажиллалаа.

Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2026 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Хүний хөгжлийн бүлэгт тусгагдсан 2 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, төлөвлөгөөнд тусгагдсан 1. 2026-2028 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох насны иргэдийн судалгааг бүх хороодоос авч, судалгаан дээр ажиллаж байна. Шинэ системд урьдчилсан тэтгэврийн тооцоолол хийж зөвлөгөө өгөх боломжийг бүрдүүлж өгвөл тэтгэврийн байцаагчийн ажлыг хөнгөвчлөх, иргэд даатгуулагчийн сэтгэл ханамж нэмэгдэхээр байна.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 24 дүгээр зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх заалт, тус газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн дугаар тушаалаар Тэтгэврийн хувийн хэрэг тоолох ажлын хэсэг 8 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдаж, тооллого 2026 оны 1 дүгээр сарын 8, 9-ний өдрүүдэд явагдаж хугацаандаа дууслаа.

Өндөр насны, тэжээгчээ алдсаны, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн тогтоолтын хуудас /англи, монгол хэлээр/, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон акт, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй тодорхойлолтыг www.protal.ndaatgal.mn болон мэдээлэл солилцооны ХУР системээс цаг алдалгүй түргэн шуурхай, цахимаар авах боломжийг тэтгэвэр авагч иргэдэд зөвлөж, энэ үйлчилгээг 100% цахимаар шийдэж байна.

2025 оны 9 сараас дүүргийн архивын хэлтэс нь бусад аймгийн лавлагааны хүсэлтийг хүлээн авч, хариуг эзэнд нь олгох үйлчилгээний эрхтэй болсныг даатгуулагч иргэдэд зөвлөж, Үндэсний архивын газар болон нийслэлийн нэг цэгийн үйлчилгээнээс лавлагаа авах шаардлагагүй болсон. Энэ нь иргэдийн цаг зав, санхүү хэмнэсэн ажил боллоо.

Их өгөгдөлд тулгуурлан, цаасан баримт шаардахгүйгээр, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран цахимаар хөдөлмөрийн чадвар алдсны тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг хүлээн авч, тогтоож байна. ЭММЗ-ийн программыг сикос системд холбосноор даатгуулагч иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг тогтоосон, сунгасан, цуцалсан шийдвэр бүрэн цахимжиж, цаасан акт ашиглахгүй болж, тэтгэврийн дэд системд мэдээлэл шууд татагдаж, тэтгэврийн өөрчлөн тогтоолтыг хийх боломжтой боллоо.

### 3.4.Тэтгэврийн тогтоолт, олголт, түүнд тавих хяналт

Иргэн, даатгуулагчид тэтгэвэр тогтоох, олгох, тэтгэврийг өөрчлөхөд Нийгмийн даатгалын багц хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Засгийн газрын 2023 оны 439 дүгээр тогтоолоор батлагдсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр, тэтгэмж олгох журам", Засгийн газрын 2023 оны 450 дугаар тогтоолоор батлагдсан "Тэтгэвэр тогтоолгох, тэтгэврийн хэмжээг өөрчлөхөд бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, тэтгэвэр олгохтой холбогдсон бусад харилцааг зохицуулсан журам", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/136 дугаар "Тэтгэвэр тогтоолгох үндэсний ажил, мэргэжлийн жишиг цалинг батлах тухай" тушаал, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/221 дүгээр тушаалаар батлагдсан "Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох, газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт", Батлан хамгаалахын сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны "Заавар батлах тухай" А/95, А/81 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийг

хэрэгжүүлэхэд баримтлах заавар” зэрэг хууль, журам, дээд газрын зөвлөмж, холбогдох бусад хуулиуд, тэдгээрийг хэрэгжүүлэх журмын тухай хуулийг мөрдөн, хэрэгжүүлж ажиллалаа.

Тайлант онд тэтгэврийн хэмжээг өөрчлүүлэх, шилжиж ирсэн болон шилжиж явсан нийт 326 даатгуулагч иргэний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэлээ.

Тэтгэврийн хөдөлгөөний тооны тайлан

| д/д | Тэтгэврийн хөдөлгөөн | Өндөр нас | Хөдөлмөрийн чадвар алдсан | Тэжээгчээ алдсан | Дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | Шинээр тогтоосон | 80 | 13 | 3 | **96** |
| **2** | Шилжиж ирсэн | 2 | 1 | 0 | **3** |
| **3** | Шилжиж явсан | 11 | 0 | 2 | **13** |
| **4** | Тусгай зохицуулалт | 21 | - | - | **21** |

Тайлант хугацаанд нас барсан 48 тэтгэвэр авагчийн гэр бүлийн гишүүнд нас барсны дараа сарын тэтгэвэр 52,544.87 мянган төгрөг олгож, 21 тэтгэвэр авагчийн өндөр насны тэтгэврийг тэтгэврийн тусгай зохицуулалтаар нэмэгдүүлэн тогтоож сар бүр олгож байна.

Тэтгэврийг хэмжээг нэмэгдүүлэх Засгийн газрын 242 дугаар тогтоол, НДЕГ-аас ирүүлсэн тэтгэвэр нэмэгдүүлэх зөвлөмжийг хэрэгжүүлж, нийт 5467 тэтгэвэр авагчийн тэтгэвэрийн нэмэгдлийг хийж тэтгэврийг 2026.01.01-ний өдөр олгосон.
Засгийн газрын 65 дугаар тогтоол, НДЕГ-ын чиглэлийг хэрэгжүүлж 2026.01.01-ний өдрөөс шинээр тэтгэвэр тогтоолгох иргэдийн тэтгэвэр тогтоох дундаж цалин хөлс тооцоход шинээр батлагдсан итгэлцүүрийг хэрэглэж тэтгэврийг тогтоож байна.

Тус дүүргийн тэтгэвэр авагчдийн дундаж тэтгэвэр:




2026 оны 5 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 5496 хүнд 28,443,362.97 мянган төгрөгийн, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 145 хүнд 1,030,739.86 мянган төгрөгийн, нийт 5641 хүнд 29,474,102.83 мянган төгрөгийн тэтгэвэр олгоод байна.

Тэтгэвэр тогтоолт, олголтыг сикос системийн процессын дагуу дараалсан хяналтаар баталгаажуулж байна. Мөн шат шатны хяналтууд тэтгэвэр тогтоолтын явцад хувийн тэмдэглэл хөтөлж, материалын бүрдэлд хяналт тавих, нэмэлтээр нөхөн даатгалын материал, холбогдох газрын лавлагаа, НДЕГ-аас ирсэн шүүх шинжилгээний байгууллагын лавлагаа, шүүхэд нотлох баримтаар гаргаж өгсөн материалтай тулгах зэрэг ажлыг хийж байна.

Тайлант хугацаанд нийт 29 удаагийн тэтгэвэр олголтын файл илгээж, банк тус бүрээс ирүүлсэн нийт 5 удаагийн 29,427.67 сая төгрөгийн тэтгэвэр олголтын хаалтын файлыг системд уншуулж, гүйцэтгэлийг баталгаажуулсан. Өр авлага барагдуулахад

арилжааны банкуудтай байгуулсан “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу 3 тэтгэвэр авагчийн илүү олгогдсон 33.2 сая төгрөгийг барагдуулах хүсэлт илгээж 14.4 сая төгрөгийг сангийн харилцах дансанд шилжүүлсэн боловч Хаан банк гэрээний үүргээ биелүүлээгүйгээс 18.9 сая төгрөг шийдвэрлэгдээгүй байна.

Тэтгэвэр олголтод хяналт тавих зорилгоор удаан хугацаагаар тэтгэврийн данснаас гүйлгээ хийхгүй байгаа иргэдийн судалгааг харилцагч банкны хүсэлт хүргүүлсэн. Төрийн банкны судалгааны дагуу тэтгэвэр авагчидтай холбогдож, тодруулга хийж ажиллалаа. Хаан банкнаас мэдээлэл гаргаж ирүүлэх боломжгүй хариу ирүүлсэн.

## ДӨРӨВ:ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮГИЙН МЭДЭЭ

### 4.1.Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын санхүүгийн тайланг НББОУС, УСНББОУСтандартын дагуу IT zone ХХК-ны “GREENFINANCE” програмаар нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бүртгэл хөтлөн “Төсвийн тухай” хуулийн 54 дүгээр зүйлийн дагуу бүрэн, хугацаанд нь үнэн зөв тайлагналаа.

Тайлант хугацаанд /finance.gov.mn/ програмаар нийт 191 удаагийн 345,2 сая төгрөгийн зарлагын гүйлгээ хийж, ehuulga -аар гарсан зарлагын жагсаалтаар анхан шатны баримтад үндэслэн програмд бүртгэн, мэдээ, тайланг гаргаж, гарын үсэг зуруулан, тэмдэг дардасаар баталгаажуулж, НДЕГ-т хүргүүлэн ажиллаж байна.

Байгууллагын үйл ажиллагааны төсвийн гүйцэтгэлийг Greenfinance програмаар боловсруулж, сар бүрийн эхэнд 2 төрлийн маягтаар сарын мэдээ, тайланг үнэн зөв, бүрэн гүйцэд бэлтгэж, нягтлан шалгаж, баталгаажуулан, НДЕГ-т илгээж байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9 дэх заалтын дагуу удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулж ажиллав.

Мэдээллийн ил тод байдал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагааны төсөв, зардалтай холбоотой мэдээллийг https://info.shilendans.gov.mn/ цахим хуудаст мэдээлсэн. Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудаст нийгмийн даатгалын үйл ажиллагааны шинчлэгдсэн төсвийн хуваарийг 2, 5 дугаар сард "Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт" хэсэгт цаг хугацаанд нь оруулан баталгаажуулж, ил тод болгон ажилласан. Мөн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, батлагдсан орон тоонд орсон нэмэлт өөрчлөлт, тушаал зэрэг нийт 73 мэдээллийг хугацаанд нь байршууллаа.




Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу сангийн 2025 оны 12 дугаар сарын -31-ны өдрийн байдлаар санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэл, санхүүгийн үйл ажиллагааг Баталгаат тооцоолол аудит ХХК аудитлаж “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгч, Нийслэл дэх Төрийн аудитын газрын 2026 оны 02 дугаар сарын 286 тоот албан бичгээр дүгнэлтийг хүргүүлсэн байна.

2025 оны санхүүгийн тайлангаар өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн дагуу гаргасан 5 арга хэмжээ бүхий төлөвлөгөөний биелэлтэд анхааран ажиллаж цалингийн тооцоолол, шилэн дансны мэдээ байршуулалт, хөрөнгийн дахин үнэлгээ, ebarimt.mn сайт дахь нэхэмжлэлийн үлдэгдэл зэрэгт анхааран ажиллаж, алдаа эрсдэлээс сэргийлэн ebarimt.mn сайтаар сар бүр орж нэхэмжлэхийн жагсаалтыг шалгаж, төлбөр барагдсан эсэхэд хяналт тавин ажиллаж байна.

4.2.Орлогын талаар

Үйл ажиллагааны зардлын 2026 оны 05 дугаар сарын байдлаарх батлагдсан төсөв 362,8 сая төгрөгөөс төсвийн хуваарийн дагуу урсгал санхүүжилт 100 хувийн гүйцэтгэлтэй байна.

4.3.Зарлагын талаар

Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдлөг болгон 2026 оны 05 дугаар сарын байдлаар үйл ажиллагааны зардалд 345,2 сая төгрөгийг хөтөлбөр, арга хэмжээнд тусгасан эдийн засгийн ангилал, зориулалтын дагуу зарцууллаа. Энэ нь тайлант үеийн төсвийн 95 хувийг эзэлж байна.

Тус газрын үйл ажиллагааны төсвийг тухайн сарын мэдээ тайлангаар гарсан байдалтай уялдуулан, төсвийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй, төсвийн хэтрэлтгүй ажиллаж байна.

4.4.Бараа материал, үнэт цаасны талаар

Тайлант хугацаанд 549,2 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна. Зарцуулалтыг шаардах хуудсаар зарлага бүртгэж, сар бүр бараа материалын тайланд

тусгаж хэвшсэн. Эхний улирлын байдлаар НДЕГ-ын архив хөрөнгө хариуцсан ажилтантай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажууллаа.

4.5. Үндсэн хөрөнгийн талаар

2026 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 568,986.7 мянган төгрөгийн нийт эргэлтийн бус хөрөнгө байна.

Үүнээс:

1. Барилга, байгууламж 457,030.4 мян.төгрөг /*2006 онд ашиглалтанд орсон.*/
2. Авто машин 1,029.3мян.төгрөг
3. Машин, тоног төхөөрөмж 41,966.8 мян.төгрөг
4. Тавилга эд хогшил 14,342.5мян.төгрөг
5. Биет бус хөрөнгө /газар/ 30,700.0 мян.төгрөг илүүдэл дутагдалгүй бүрэн бүтэн ашиглагдаж байна.

4.6. Өр, авлагын талаар

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны төсвийг тухайн сарын мэдээ тайлангаар гарсан байдалтай уялдуулан төсвийн ангилал хооронд шилжүүлэхгүй төсвийн хэтрэлтгүй, өглөг, авлага үүсгэхгүй ажиллах төлөвлөгөөтэй байсан боловч тайлант хугацаанд төсөв хүрэлцэхгүйн улмаас 2026 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийгмийн даатгалын шимтгэлд 11,600,0 мянга, бичиг хэргийн зардалд 313.7 мянга, бага үнэтэй, түргэн элэгдэх зүйл, ахуйн эд зүйлсийн зардалд 299.0 мянга, харуул хамгаалалтын зардалд 237.5 мянга нийт 12,450.2 мянган төгрөгийн өглөг үүсээд байна.

4.7.Орон тоо, цалингийн сангийн талаар

Тус газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/21 дүгээр “Газрын зохион байгуулалтын бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай” тушаалаар шинэ бүтэц орон тоо батлагдаж нийт 18 хүний бүрэлдэхүүнтэй ажиллалаа.

4.8.Эд хөрөнгийн хадгалалт хамгаалалтын талаар

Байгууллагын эд хөрөнгийн 2025 оны жилийн эцсийн тооллого явуулсантай холбогдуулан, хөрөнгийн хөдлөлийг 18 албан хаагч тус бүрээр өөрчлөв.

Тайлант хугацаанд хуваарилагдсан төсвийн хүрээнд байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай 28 төрлийн 2,342.0 мянган төгрөгийн эд материалын худалдан авалт хийж, 65 нэр төрлийн 2,357.3 мянган төгрөгийн материалыг албан хэрэгцээнд зарцуулж, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтыг бүрдүүлж, сар бүр тайлагнав. Агуулахад байгаа бараа материалыг төрөлжүүлэн цэгцэлж, хаягжууллаа.

## ТАВ: ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН МЭДЭЭ

5.1.Ажил олгогч, даатгуулагчдад хийсэн хяналт шалгалтын талаар

Тайлант хугацаанд хяналт шалгалтаар 10 ажил олгогч, 10 даатгуулагчид холбогдох ажилласан хугацааны хөдөлмөрийн хөлс, жирэмсэн амарсаны амралттай хугацаа, хүүхдээ асрах чөлөөтэй байх хугацааны шимтгэлийг, ээлжийн амралтын олговрыг харгалзах сард нь залруулах тухай хүсэлтийг судлан нотлох баримтад үндэслэн шалган 1,700.6 мянган төгрөгийн акт тогтоогдож, 1,475.9 мянган төгрийг барагдуулсан байна. 2025 оны байдлаар шимтгэлийн өртэй 2 ажил олгогчийн 39.8 мянган төгрөгийн улсын байцаагчийн актыг барагдуулаагүй, Улсын байцаагчийн актын барагдуулалт 85.4%-тай байна.

*2026 онд тогтоогдсон улсын байцаагчийн актын барагдуулалтын тоон үзүүлэлт:*




Өмнөх онд Нийгмийн даатгалын ерөнхий газрын, хяналт шалгалтын газрын салбарын хяналтын улсын байцаагчийн нарын Нүүрэнтэйн эсгий ХХК-нд тогтоосон 2,081.8 мянган төгрөгийн акт 2026 оны эхний хагас жилийн байдлаар барагдуулаагүй байна. Тус компанийн захирал болон нягтлан бодогч нартай удаа дараа холбогдоход улсын байцаагчийн актыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн тайлбар өгсөн байна.

2026 онд сайн дурын даатгалын шимтгэлийг гэрээний хугацаанд, хугацаа хоцроож төлсөн 134 даатгуулагч (давхардсан тоогоор)-д 6,386.4 мянган төгрөгийн алданги тогтоож барагдуулсан.

*Хүснэгтээр харуулбал*:

| № | Тогтоогдсон актын төрөл | Оны эхний үлдэгдэл | Дт | Кт | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|---|
| *1* | Сайн дурын даатгуулагч | 0 | 6,386.4 | 6,386.4 | 0 |
| | | | | | |
| | **Дүн** | **0** | 6,386.4 | 6,386.4 | **0** |

**Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйл** “Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах”**, 15.2 дугаар зүйл** “Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах” заалтын дагуу дараахь зөрчлүүдийг шалган шийдвэрлэсэн байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг “Ажил олгогч Улсын бүртгэлийн байгууллагаас гэрчилгээ авснаас хойш ажлын 14 өдрийн дотор харьяалагдах нийгмийн даатгалын байгууллагад нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлэх”-т заасны дагуу хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй 11, ажил олгогчийг нотлох баримтад үндэслэн тулган шалгасан, мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/199 дугаар тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын 4.1-т дагуу 2 ажил олгогчийг нотлох баримтад үндэслэн тулган шалгаж зөрчлийн тухай хуулийн дагуу шалган шийдвэрлэж 6,000.0 мянган төгрөгийн торгууль тогтоож, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу 15 хоногийн дотор торгуулиа төлсөн 12 ажил олгогчийн 5,500.0 мянган төгрөгийн торгууль 50%-ийн хөнгөлөгдсөн, 1 ажил олгогч торгуулийн 500.0 мянган төгрөг төлөөгүй, барагдуулалт 92%-тай байна.

| д/д | Байгууллагын нэр | Регистер | Даатгуулагчийн тоо | Зөрчлийн хэрэг үүссэн эсэх | Хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн эсэх | Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авахаас | Зөрчлийн торгуулийн мөнгөн дүн (мян) |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Агар-аяга ХХК | 2023012916069 | 1 | | тийм | | 250 |
| 2 | Веритас саплай чэйн ХХК | 2026021300030 | 1 | | тийм | | 500 |
| 3 | Ган энх оюу ХХК | 2023012908345 | 2 | | тийм | | 250 |
| 4 | Дэлгэрэх хамтын арчим хоршоо | 2026051100030 | 1 | | тийм | | 500 |
| 5 | Дөлгөөн алт ХХК | 2026031100002 | 3 | | тийм | | 500 |
| 6 | Мөнхдөл констракшн ХХК | 2026021300037 | 1 | | тийм | | 500 |
| 7 | Нижү эйдь ХХК | 2026021000046 | 1 | | тийм | | 500 |
| 8 | Симетал сүүн сүрэг сан хоршоо | 2026043000431 | 2 | | тийм | | 500 |
| 9 | Торго магнаг ХХК | 2026041700023 | 1 | | тийм | | 500 |
| 10 | Тэмүүлэн цалуу гэрэл ХХК | 2026052000030 | 1 | | тийм | | 500 |
| 11 | Түвшин хан энержи ХХК | 2026020200054 | 1 | | тийм | | 500 |
| 12 | Элбэг хэрлэн ХХК | 2026052700004 | 1 | | тийм | | 500 |
| 13 | Эрчит нар энержи ХХК | 2026010300008 | 1 | | тийм | | 500 |
| 14 | Эрчим-Ус СӨХ | 2026011500020 | 1 | | | тийм | |
| **Нийт дүн** | | | | | | | **6000000** |

5.2.Дотоод хяналт шалгалтын талаар

Дотоодын хяналт шалгалтаар тахир дутуугийн тэтгэврээс өндөр насны тэтгэвэрт шилжсэн, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь өөрчлөгдсөн, гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тоо өөрчлөгдсөн, нөхөн даатгалын жил болон шимтгэл төлж ажилласан жил, цалин өөрчилсөн хуучин тэтгэвэртэй 160, шинээр тогтоолгосон 86, нийт 246 тэтгэвэр авагчийн хувийн хэрэг материалын үндэслэл, тооцооллыг шалгалаа.

Шалгалтаар 15 тэтгэврийн материалын зөрчлийг илрүүлэн, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажилласан байна. Түгээмэл гарсан зөрчлүүд нь зарим саруудын цалин зөрүүтэй бичих, , архивын лавлагаа, мэдээллийн бааз, нийгмийн даатгалын дэвтрүүд дээрх цалингууд зөрөх, жилийн цалингийн тодорхойлолтыг хяналтаар баталгаажуулаагүй, хөдөлмөрийн дэвтэр болон иргэний үнэмлэхний овог ондоо байх, шимтгэл төлөлтийн архивын лавлагаа дутуу, Засгийн газрын тогтоолоор нэмэгдсэн тэтгэврийн нэмэгдлийг хувийн хэрэгт тэмдэглээгүй, ажилласан жил зөрүүтэй оруулах зэрэг зөрчлүүд гарсныг тухай

бүр засуулж, гарч байгаа алдааг дахин гаргахгүй байх, бусад төрлийн нийтлэг гардаг алдаа гарахаас сэргийлэх талаар тэтгэврийн байцаагчид зөвлөгөө өгч ажиллав.

*5.2.1.Тэтгэврийн хөдөлгөөн болон даатгулагчийн хүйсийн тоон үзүүлэлт:*

| № | Тэтгэврийн төлөв | Тэтгэврийн төрөл | Тоо хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Нийт 246 тэтгэвэр -Үүнээс: | Өндөр насны тэтгэвэр | 134 |
| | | Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр | 99 |
| | | Тэжээгчээ алдсаны тэтгэвэр | 13 |
| 2 | Нийт 246 тэтгэвэр - Үүнээс: | Шинэ | 86 |
| | | Хуучин | 160 |
| 3 | Нийт 246 тэтгэвэр - Үүнээс: | Эр | 134 |
| | | Эм | 112 |

Улсын байцаагчийн актаар тогтоогдсон 10 тэтгэвэр авагчтай холбоотой төлбөрийн оны эхний үлдэгдэл 98,761.4 мянган төгрөгийн төлбөрөөс тайлант хугацаанд барагдуулаагүй байна.

2026 оны эхний үлдэгдэлтэй хуурамч бичиг баримтаар тэтгэвэр тогтоолгосон 20 тэтгэвэр авагчийн 409,822.98 мянган төгрөгийн актын төлбөрөөс барагдуулаагүй, 409822.9 мянган төгрөг үлдэгдэлтэй байна.

Тайлант хугацаанд 47 тэтгэвэр авагчид илүү болон дутуу олгосон 37,115.2 мянган төгрөгийн акт тогтоогдож, бүрэн олгож барагдуулсан байна. Нийт улсын байцаагчийн актын барагдуулалт 7%-тай байна.

2022 оны актын үлдэгдэлтэй нэг даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн актын төлбөр 1,089.6 мянган төгрөг барагдаагүй үлдэгдэлтэй байна.

5.2.2.Ажилгүйдлийн тэтгэмж

Ажилгүйдлийн тэтгэмж авахаар өргөдөл хүсэлт гаргасан 39 даатгуулагчдын хувийн хэрэг материалын тэтгэмжийн бодолт, баримт материалын бүрдэлт, хуулийн хугацаа зэргийг шалгасан.

5.2.3.Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний, амаржсаны тэтгэмж

Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний, амаржсаны тэтгэмж 105 байгууллагын 1091 даатгуулагч, сайн дурын 94 даатгуулагчдын эмнэлгийн хуудсыг зохих журмын дагуу хянаж, шалгав. Үүнд:

| № | Байгууллага | Тэтгэмжийн төрөл | Тоо хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагч – 94 | ЖАТ | 37 |
| | | ХЧТА | 57 |
| | | Эр | 21 |
| | | Эм | 72 |
| 2 | 156 ажил олгогч байгууллагын тэтгэмж авсан даатгуулагч 1091 | ЖАТ | 132 |
| | | ХЧТА | 958 |
| | | ҮОМШӨ ХЧТА | 1 |
| | | Нийт дүн | 1185 |

Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгосон тэтгэмжийг 44 иргэнд, сувилалын зардал 62 даатгуулагчид, ҮОМШӨ сувилалд ирж очих унааны зардал авах 1 хүсэлтийг сикос программ, нэгдсэн лавлагаатай тулган шалгав.

*Тэтгэвэр, тэтгэмж, сувилалын зардал шалгасан тоон үзүүлэлт:*




Оны эхний үлдэгдэлтэй жирэмсэн, амаржсаны тэтгэмж, ажилгүйдлийн тэтгэмж илүү олгосон акт төлбөр 32,890.6 мянган төгрөгийн актын үлдэгдэлтэй байснаас тайлант онд жилгүйдлийн тэтгэмж илүү олгосон 8 даатгуулагчид 4,687.9 мянган төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоогдож, 6,758.99 мянган төгрөгийг барагдуулж, актын барагдуулалт 18%-тай байна.

Дотоод хяналт шалгалтаар тогтоосон 6 даатгуулагчтай холбоотой 15,404.43 мянган төгрөгийн улсын байцаагчийн актыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргасан байна.

Цалин шалгуулахаар хүсэлт гаргасан 3, мал тооллогын А дансыг шалгуулах 2, ээлжийн амралтын цалин, цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогыг харгалзах сард нь залруулах, тайланд тусгаагүй цалин хөлс, түүнтэй адилтгах орлого нөхөн тайлагнуулах 1 өргөдлийг архивын баримт, тушаал, бусад нотлох баримтад үндэслэн тулган шалгаж, залруулах дүгнэлт гарган холбогдох санхүүгийн тасагт шилжүүлж, хариуг хуулийн хугацаанд хүргүүлсэн байна.

5.3.Нийгмийн даатгалын ерөнхий газрын  даргын баталсан 2026 оны 01 дүгээр сарын 26-ны  өдрийн “Аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн Даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамж”-ийн хүрээнд хийсэн ажлын мэдээ

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамжийн дагуу шимтгэлийн хуримтлагдсан өртэй аж ахуйн нэгж, байгууллагуудтай өр барагдуулах, шалгалтанд хамрагдах тухай удирдамж танилцуулахаар холбогдоход аж ахуйн нэгж, байгууллагын тушаал шийдвэр, иргэн болон ажилтантай байгуулсан холбогдох гэрээ, санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэл, цалин хөлс, санхүүгийн анхан шатны баримтуудаас дутуу ирүүлсэн, мөн удаа дараа холбогдоход материал ирүүлээгүй зэрэг нөхцөл байдлаас үүдэн шалгалтыг эцэслэн дуусгаагүй байна.

Тайлант хугацаанд  дотоодын хяналт шалгалтаар 10 ажил олгогч, байгууллагын 10 даатгуулагчид холбогдох 1700,6 мянган төгрөгийн акт тогтоогдож 9 ажил олгогчийн 1486,9

мянган төгрөгийг актын төлбөрийг барагдуулж, 1 ажил олгогчийн 213,7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэг “Ажил олгогч Улсын бүртгэлийн байгууллагаас гэрчилгээ авснаас хойш ажлын 14 өдрийн дотор харьяалагдах нийгмийн даатгалын байгууллагад нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр бүртгүүлэх”-т заасны дагуу хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй 11, ажил олгогчийг нотлох баримтад үндэслэн тулган шалгасан, мөн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/199 дугаар тушаалаар батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам”-ын 4.1-т дагуу 2 ажил олгогчийг нотлох баримтад үндэслэн тулган шалгаж зөрчлийн тухай хуулийн дагуу шалган шийдвэрлэж 6,000.0 мянган төгрөгийн торгууль тогтоож, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу 15 хоногийн дотор торгуулиа төлсөн 12 ажил олгогчийн 5,500.0 мянган төгрөгийн торгууль 50%-ийн хөнгөлөгдсөн, 1 ажил олгогч торгуулийн 500.0 мянган төгрөг төлөөгүй байна.

<u>5.4. Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн а/82 “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх удирдамж”-ийн хүрээнд хийсэн ажлын мэдээ</u>

Мэдээллийн технологийн төвөөс ирүүлсэн 2020-2025 онд нас барсны дараа сараас хойш илүү олгогдсон зөрчилтэй тэтгэврийн жагсаалтад үндэслэн тэтгэврийн олголтын тооцооллын үнэслэлд тулгалт хийлээ.

Мэдээллийн технологийн төвөөс нийт 42 жагсаалт бүхий 15 тэтгэвэр авагчийн нэр ирсэн бөгөөд тулган шалгахад 5 тэтгэвэр авагч холбоотой зөрчил илэрсэн байна.

5.4.1. Улсын байцаагчийн акт тогтоосон:

Цэргийн албан хаасны тэтгэвэр авагч Д.Цогтсайхан нь 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр нас барсан, 2025 оны 02 дугаар сараас 2025 оны 12 дугаар сарыг дуустал хугацааны 16,224,934 төгрөгийн тэтгэвэр үндэслэлгүйгээр илүү олгосон, өндөр насны тэтгэвэр авагч И.Бямбадорж нь 2024 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр нас барсан, 2024 оны 11 дүгээр сараас 2025 оны 12 дугаар сарыг дустал хугацааны 15,180,514 төгрөгийн тэтгэвэр үндэслэлгүйгээр илүү олгосон нь тогтоогдсон тул илүү олгосон 31,405,448.00 төгрөгийн тэтгэврийн даатаглын санд төлүүлэхээр 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 42 дугаартай улсын байцаагчийн акт тогтоож, 12,576,740.34 төгрөгийг барагдуулсан байна.

5.4.2.Улсын байцаагчийн акт тогтоох:

Өндөр насны тэтгэвэр авагч Б.Улаанхүү нь 2021 оны 07 дугаар сарын 31-ний өдөр нас барсан, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын газраас 2021 оны 08 дугаар сарын 02-ны өдөр авсан байна. 2021 оны 09-11 сарын нийт 2,003,604 төгрөгийн тэтгэвэр илүү олгосон байна. Тус газрын 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 337 дугаартай "Мэдэгдэл хүргүүлэх тухай" албан бичгийг эхнэр Багануур дүүргийн 3 дугаар хорооны иргэн Ц. Оюунчимэгт Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг 11 дүгээр хороо Ногоон зоорь Жалга 3 дугаар гудамж 10а тоотод Монгол шуудангаар хүргүүлжээ.

Өндөр насны тэтгэвэр авагч Н.Энхсүх нь 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр нас барсан, нас барсны дараа сарын тэтгэврийн 689,000 төгрөг, Г.Баярсайхан нь 2024 оны 02 дугаар сарын 22-ны өдөр нас барсан, нас барсны дараа сарын тэтгэврийн 1,773,142 төгрөгийг үндэслэлгүйгээр илүү олгосон нь тогтоогдлоо.

<u>5.5.Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн а/69 төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх удирдамж</u>

Мэдээллийн технологийн төвөөс ирүүлсэн 636 жагсаалт бүхий ажилгүйдлийн тэтгэмж авсан иргэдийн мэдээлэл ирснийг тулган шалгалаа. Шалгалтаар 62 даатгуулагчтай холбоотой зөрчил илэрснээс дотоод хяналтаар ажилгүйдлийн сангаас илүү олгосон 17 иргэнд улсын байцаагчийн акт, НДЕГ-н салбарын хяналтаас 13 иргэнд улсын байцаагчийн

актыг тус тус тогтоосон байна. Ажилгүйдлийн тэтгэмж авч байх хугацаанд ажилд орж албан журмаар шимтгэл төлсөн 23 иргэний тушаалыг татан авч тооцоо хийх, ажилд орсон 9 иргэний тушаалаар тэтгэмжийг зогсоохдоо программд огноо буруу оруулсанаар 1 өдрийн тэтгэмж илүү олгосон зөрчил илэрлээ.

## ЗУРГАА.ХУУЛЬ ТОГТООМЖИЙН БИЕЛЭЛТИЙН МЭДЭЭ

6.1.Дээд газрын ирүүлсэн тогтоол, шийдвэрийг бүртгэж, түүний мөрөөр авч хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах.

> Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд эрх зүйн шинэчлэлтийг цахим системд зүгшрүүлэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажиллав.

- ✓ 2026 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар дээд газраас ирүүлсэн 25 эрх зүйн актыг хэрэгжүүлэн ажиллав.

Үйлчилгээ, өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлт, хяналт

Нийгмийн даатгалын байгууллагаас үйлчилгээ авахаар иргэд, даатгуулагчдын ирүүлсэн хүсэлтийг өргөдөл, гомдлын дэвтэрт бүртгэж, бүртгэл хяналтын карт хөтлөн, холбогдох албан тушаалтанд шилжүүлж, явц, шийдвэрлэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд нийт 820 хүсэлт бүртгэгдсэнээс 97%-ийг шийдвэрлэж ажиллав. 2026 оны 1 дүгээр улирлын өргөдөл, гомдлын тайланг Монгол улсын тэргүүн шадар сайд бөгөөд эдийн засгийн хөгжлийн сайдын 2025 оны 11 дүгээр сарын 19-ны өдрийн А/66 тушаалын хавсралт “Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаарх тайлан, мэдээлэл гаргах, хүргүүлэх журам”-ын дагуу гаргаж 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдөр НДЕГ-ын ҮХОНХГ-т, мөн оны 05 дугаар сарын 25-ны өдөр НДЕГ-ын ДАМГ-т тус тус хүргүүлсэн.

Ирүүлсэн шийдвэрийг төрлөөр нь авч үзвэл

| № | Эрх зүйн актын нэр | Тоо |
|---|---|---|
| 1 | Засгийн газрын тогтоол | 3 |
| 2 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын албан даалгавар | 2 |
| 3 | НДЕГ-ын даргын тушаал | 15 |
| | НДЕГ-ын даргын албан даалгавар | 1 |
| 4 | Ерөнхий сайдын захирамж | 3 |
| 5 | ТАЗ-ийн ГБХНХ дэргэдэх салбар зөвлөлийн тогтоол | 1 |
| | **Нийт** | **25** |

6.2.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай

Тайлант хугацаанд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2–8.6-д заасан 37 төрлийн мэдээллийг цахим хуудсандаа байршуулж, Baganuur.ndaatgal.mn сайтад нийтэлсэн мэдээллийг shilen.gov.mn системтэй холбон ажиллав. 2026 онд мэдээллийн ил тод байдал, дотоод хяналт, хүний нөөцийн бодлого, үйлчилгээний чанарын чиглэлээр хууль, журамд заасан хугацаанд тайлан мэдээ, үр дүнг бүрдүүлэн хүргүүлж ажиллав. 1 дүгээр улиралд 85,03% үнэлэгдсэн II улиралд мэдээллийг хугацаанд бүрэн байршуулж ажиллана.

6.3.Авлига гэмт хэргээс, урьдчилан сэргийлэх чиглэлээр

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах чиглэлээр байгууллагын худалдан авах ажиллагаа, төсвийн зарцуулалтыг бүрэн цахимжуулж, ил тод байдлыг хангаж, шилэн дансанд байршуулсан.

Нийт албан хаагчдыг ашиг сонирхлын зөрчил болон авлигын эсрэг хууль тогтоомжийн чиглэлээр НДЕГ-аас зохион байгуулсан сургалтад хамруулж, зөвлөмж мэдээллээр хангасан.

Үйл ажиллагааны явцад авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй ажлын байрны эрсэдэлээс хамгаалж, дотоод хяналтыг тогтмолжуулсан.

Үүнээс гадна хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 250 дахин нэмэгдүүлсэнээс дээш их хэмжээний өөрчлөлт орсон бол 30 хоногийн дотор мэдээлэх гэсний дагуу нийт албан хаагчдад, түүний дундаас ХАСХОМ гаргагч нарт онцлон сануулж, хууль хэрэгжүүлж ажиллахыг зөвлөв.

6.4.Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам, Баримт бичгийн стандарт (MNS5140:2021-1, 2, 3), Засгийн газрын 2025 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан “Журам батлах тухай”, Монгол хэлний тухай хуулийн 7.2. дах хэсэгт заасны дагуу үндэсний бичгийн хөтөлбөрийг үе шаттай хэрэгжүүлж, зохих бэлтгэл хангасны үндсэн дээр төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага албан хэргээ крилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулна, 11.1.2.монгол хэл, бичиг үсгийн хэрэглээг нэмэгдүүлэх, хамгаалах, хөгжүүлэх, үндэсний бичгийн хэрэглээнд албан ёсоор шилжих дунд болон урт хугацааны үндэсний хөтөлбөр, дүрэм, журам, үндсэн чиглэл боловсруулж хэрэгжүүлэх гэсэн заалтын дагуу архив, албан хэрэг хөтлөлтөө хөтөлж байна.

Албан хэрэг хөтлөлтийн edoc дэд системээр нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудтай, able программаар Нийгмийн даатгалын ерөнхий газар, аймгийн Нийгмийн даатгалын газартай албан бичиг солилцон ажиллаж байна.

Цаасаар ирүүлсэн 112 албан бичгийг edoc.ulaanbaatar.mn системд бүртгэж, илгээсэн 83 албан бичгийг системээр боловсруулав.

Тус газраас гадагш илгээж буй албан бичгийг edoc системийн баримт боловсруулалт цэсээр боловсруулах ажлыг хэвшүүлж, тоон гарын үсгээр баталгаажуулан илгээж, үндэсний бичгээр хөрвүүлж, байгууллагад үлдэх хувийг хэвлэмэл хуудсанд буулган архив, албан хэрэг хөтлөлтийн журам, стандартыг мөрдөн ажиллалаа.

Ажлын зохион байгуулалтын хүрээнд: Газрын даргын А тушаал 13, Б тушаал 9 нийт 22 тушаалын хуулийн ишлэлийг хянаж, эрхзүйн чиглэлээр ирүүлсэн 3 судалгааг гаргасан.

6.5.Архивын үйл ажиллагааны талаар

Нийгмийн даатгалын газрын 2025 оны үйл ажиллагааны явцад бүрдүүлсэн баримтыг албан хаагчдаас архивд хүлээн авах хуваарийг 2026 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр газрын даргаар баталгаажуулсан ба албан хаагчдад нэг мөр ойлголт өгөх зорилгоор Багануур дүүргийн Архивын хэлтэст хүсэлт хүргүүлэн, 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах болон хадгаламжийн нэгж бүрдүүлэх арга зүй" сэдвээр сургалт зохион байгуулсан.

Хуваарийн дагуу тухайн оны Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтаар 9 албан хаагчаас 301 баримтыг цаасаар, 76 баримтыг цахимаар хүлээн авч, нягтлан шалгаж, архивд хүлээн авсан тухай акт үйлдсэн. Үүнд:

Өндөр насны тэтгэврийн 105, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийн 82, тэжээгчээ алдсаны тэтгэврийн 17, нийт 204 зогсоогдсон хувийн хэрэг, цаасан суурьтай 301, цахимжуулсан 76 баримтыг нягтлан шалгаж, архивд хүлээн авсан.

Архивд хүлээн авсан нийт 581 баримтыг төрөлжүүлэн ангилсан ба 2024, 2025 оны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн болон сангийн тайлан, 2025 оны хяналт шалгалтын баримтыг архивд хүлээлгэн өгөөгүйтэй холбоотойгоор бүрэн эцэслэгдээгүй байна.

Архив, хөрөнгө хариуцсан ажилтны үйл ажиллагааны явцад үүссэн мэдээлэл лавлагааны баримт бичгүүдийг Архив, албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу зохион бүрдүүлж, баталгаажуулан, байнга хадгалах 9, түр хадгалах 17 хадгаламжийн нэгжийг бүрдүүлэн, цаасан суурьтай 26, цахимжуулсан 24 баримтыг архивд хүлээлгэн өгөв.

Архиваас албан хаагчдад түр ашиглуулахаар 140 хадгаламжийн нэгжийг бүртгэлээр хүлээлгэн өгч, баримт тус бүрийн ашиглалтын хуудсанд бичилт хийлгэн хүлээн авсан байна.

Дүүргийн архивд нөхөн бүрдүүлэлт хийхээр өгсөн 1997-2011 оны 144 баримтыг буцаан авч, 65 баримтад техник ажиллагаа хийсэн.

Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам шинэчлэн батлагдсантай холбогдуулан өдөр тутмын үйл ажиллагаанд хөтлөгдөх 3 төрлийн бүртгэл, 2 төрлийн маягтыг шинэчлэн ашиглаж, үйл ажиллагааны явцад үүссэн баримт бичгийг холбогдох хууль, журамд заасны дагуу бүрдүүлэв.

Дүүргийн Засаг Даргын Тамгын Газрын Архивын хэлтсээс ирүүлсэн албан бичгийн хүрээнд 2020, 2021, 2022, 2025 оны албан хаагчдын цалингийн тооцооны хүснэгтийг цахим хэлбэрт шилжүүлэн, 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр хугацаанд өгч хянуулллаа.

Багануур дүүргийн шүүх болон архивын хэлтсээс ирүүлсэн 2 албан бичгийн хариуг хугацаанд нь хүргүүлсэн.

Иргэдээс 396, бусад аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газраас 41, нийт 437 хүсэлтийг хүлээн авч, 88 хүсэлтийг бусад аймаг, дүүрэг рүү уламжилж, 390 лавлагааг цаасан суурьтай баримт болон цахим мэдээллийн сангаас гарган, иргэдэд хүлээлгэн өгсөн байна.

Тайлант хугацаанд шийдвэрлэсэн лавлагааны хүсэлтийг 2025 оны мөн үетэй харьцуулбал 17,85 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Энэ нь дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг “Гэрэлт ирээдүй” Мэргэжлийн боловсролын сургуулиас ирүүлсэн албан бичигт 197 суралцагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа авах хүсэлт ирүүлсэнтэй холбоотойгоор цахим лавлагааны тоо өссөн байв.

| Д/д | Лавлагааны төрөл | Огноо | | Үзүүлэлт | |
|---|---|---|---|---|---|
| | | 2025 оны хагас жил | 2026 оны хагас жил | Тоо | Хувь |
| 1 | Метадата | 184 | 95 | -89 | -48,36 |
| 2 | Явуулсан | 84 | 88 | 4 | 4,76 |
| 3 | Ирсэн | 40 | 41 | 1 | 2,5 |
| 4 | Цахим | 134 | 213 | 79 | 58,95 |
| **Нийт** | | **442** | **437** | **-5** | **17,85** |

Тайлангийн хугацаанд газрын хэмжээнд ирсэн 2356 (CallPro) дуудлагын 78 нь архивын утсанд ирсэн бөгөөд 7 дуудлага буюу 0,3 хувийг алдсан байна. Архивын ажилтан 71 дуудлагыг хүлээн авч, иргэдэд мэдээлэл, зөвлөгөөг өгч ажилласан.

6.6.Тус газрын зөвлөлүүдийн үйл ажиллгааны тайлан

6.6.1.Маргаан хянан шийдвэрлэх салбар зөвлөл

Төв болон салбар зөвлөл нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, ажил олгогч, даатгуулагчийн болон

нийгмийн даатгалын байгууллагын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хүндэтгэх, ажил олгогч, даатгуулагчийн нууцыг чанд хадгалах зарчмыг баримталж, нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрмийг удирдлага болгон ажиллаж байна.

Албан тушаалын нэршил өөрчилсөнтэй холбоотойгоор тус газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 27-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар салбар зөвлөлийн даргаар тус газрын дарга, гишүүдээр Санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтсийн дарга, Захиргаа, хяналтын хэлтсийн дарга, Тэтгэвэр, тэтгэмжийн хэлтсийн дарга, орлого шимтгэлийн байцаагч, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн хэлтсийн дарга болон нийгмийн хамгааллын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн нар, дүүргийн Ажил олгогч эздийн холбооны тэргүүлэгч гишүүн, Багануур ХК-ийн хуулийн зөвлөх, нарийн бичгийн даргаар тус газрын хяналт шалгалтын байцаагч нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй баталсан байна.

Тайлант хугацаанд салбар зөвлөл нь 5 удаагийн хурлаар ажлын байрны хортой нөхцөлөөр 1, хүнд нөхцөлөөр 2, өөрчлөн тогтоосон тэтгэвэрийн олгож эхлэх хугацааг тогтоолгох 2, ажилгүйдлийн тэтгэмж олгож эхлэх өдрийг тогтоох тухай 2, малчнаар ажилласанд тооцуулах тухай 1 нийт 8 даатгуулагчийн өргөдөл, хүсэлтийг хүлээн авч, 7 даатгуулагчийн хүсэлтийг ханган шийдвэрлэж, 1 даатгуулагчийг хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажилласнаар тооцох боломжгүй талаар хурладааанаар шийдвэрлэлээ.

Маргаан хянан шийдвэрлэлтийн талаар

| Өргөдлийн төрөл | Өргөдлийн тоо | Хэрхэн шийдвэрлэсэн |
|---|---|---|
| Хөдөлмөрийн хортой нөхцөлд ажилласнаар тооцохгүй тухай | 1 | Хөдөлмөр, нийгмийн хамгаалын сайдын 2023 оны А/221 дугаар тушаалаар баталсан “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалт”-ын “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой халуун хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалт”-ын<br>- Хоёр. “Хөдөлмөрийн хортой нөхцөл”-ийн 2.19 дэх хэсгийн “Нефть боловсруулах үйлдвэр”-ийн 200 дахь заалтын 9333-15 кодтой шатахуун ачигч, шатахуун буулгагч ажлын байрт дүйцүүлж, хөдөлмөрийн хортой нөхцөлд хамааруулан тооцохгүй болохыг тогтоосон. |
| Хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажилласнаар тооцсон тухай | 2 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/221 дугаар тушаалаар баталсан “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын доор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг хэрэглэх журам”-ын 2 дугаар зүйлийн 2.7 дахь хэсэг заасан жишээ-2 баримтлан<br>Дөрөв. “Хөдөлмөрийн хүнд нөхцөл”-ийн 31 дэх хэсгийн “Нийслэлийн нийтийн тээврийн том оврын зорчигч тээвэр”-ийн 1-т заасан 8331-11 кодтой ажил, мэргэжилд хамааруулан хөдөлмөрийн хүнд нөхцөлд ажилласнаар тооцсон. |

| | | |
|---|---|---|
| Тэтгэвэр олгож эхлэх хугацааг тогтоох тухай | 2 | Цэргийн алба хаасны тэтгэврийг өөрчлөн тогтоолгох зорилгоор, 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр тус газарт тэтгэвэр тогтоолгосон хугацаанд хамаарах 2005 оны 02, 03 дугаар сарын цалинг залруулах хүсэлт ирүүлсэнийг харгалзан, өмнө авч байсан тэтгэвэр, өөрчлөн тогтоосон тэтгэврийн зөрүүг тооцож, 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс нөхөн олгох.<br>Өндөр насны тэтгэврийг өөрчлөн тогтоолгох зорилгоор тэтгэвэр тогтоолгосон хугацаанд хамаарах 1995 оны 12 сар, 1998 оны 7, 9, 11, 12 сар, 2000 оны 12 сар, 2001 оны 1, 3, 4-10 дугаар саруудын цалинг нөхөн төлүүлэх хүсэлтийг 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр тус газарт ирүүлснийг харгалзан өмнө авч байсан тэтгэвэр, өөрчлөн тогтоосон тэтгэврийн зөрүүг тооцож, 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс нөхөн олгох. |
| Ажилгүйдлийн тэтгэмжийг олгож эхлэх өдрийг тогтоох тухай | 2 | Даатгуулагч нь 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдөр ажлаас чөлөөлөгдөж, 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Нийгмийн даатгалд цахимаар ажилгүйдлийн тэтгэмж авахаар хүсэлт гаргасан байна.<br>Тухайн үед Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн цахим системд 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөр бүртгэлтэй байсан хугацаагаар программд алдаатай хүсэлт илгээгдэж, тэтгэмжийн байцаагч энэ талаар даатгуулагчид мэдэгдсэнээр, даатгуулагч тус хэлтсийн цахим системд 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр дахин бүртгүүлсэн байна.<br>Даатгуулагч өөрөөс үл хамаарах шалтгаанаар хугацаа хойшилж бүртгүүлсэнийг харгалзан, даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг нийгмийн даатгалын байгууллагад тэтгэмж авах хүсэлт илгээсэн өдөр буюу 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс тогтоон олгох.<br>Даатгуулагч нь 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр ажлаас чөлөөлөгдөж, 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Нийгмийн даатгалд цахимаар ажилгүйдлийн тэтгэмж авахаар хүсэлт гаргасан байна.<br>Тухайн үед Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн цахим системд 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрөөр бүртгэлтэй байсан хугацаагаар программд алдаатай хүсэлт илгээгдэж, тэтгэмжийн байцаагч энэ талаар даатгуулагчид мэдэгдсэнээр, даатгуулагч тус хэлтсийн цахим системд 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр дахин бүртгүүлсэн байна.<br>Даатгуулагч өөрөөс үл хамаарах шалтгаанаар хугацаа хойшилж бүртгүүлсэнийг харгалзан, Даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмжийг нийгмийн даатгалын байгууллагад тэтгэмж авах хүсэлт илгээсэн өдөр буюу 2025 оны 04 дугаар сарын 01-ний өдрөөс тогтоон олгосугай. |

| | | |
|---|---|---|
| Малчнаар ажилласанд тооцох тухай | 1 | Даатгуулагч нь нөхөртэйгээ 1995 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр гэрлэлтээ батлуулсан, 1995 оны 03 дугаар сарын 25-ны өдөр хүүхэд төрүүлж, эцгээр нь овоглосон тул 1995 оны 03 дугаар сараас малчнаар ажилласанд тооцсон. |

6.6.2.Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагааны талаар

Эрүүл мэндийн магадлалын салбар зөвлөлийн хурал долоо хоног бүрийн Лхагва гарагт Нийгмийн эрүүл мэндийг дэмжих төвд 80-100% ирцтэйгээр, нийт 18 удаа 29.5 цаг хуралдлаа.

Тайлант хугацаанд зөвлөлийн үйл ажиллагаа, гишүүдтэй холбоотой гомдол, зөрчил гараагүй. ЭММСЗ-ын хурлын үйл явцыг дүрс бичлэгт бичиж, хадгалж байна.



Хурлаар хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, хэмжээг 32 иргэнд шинээр тогтоож, 23 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг цуцалж, 145 иргэнийг магадлан сунгаж, *нийт 200 иргэний* хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааны шийдвэр гаргаж ажилласан байна.

2025 оны 05 сарын 31-ны өдрийн байдлаар *нийт 869 иргэн* тэтгэвэр тогтоолгон авч байгаа бөгөөд үүнээс 556 иргэн нийгмийн даатгалын сангаас, 313 иргэн нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авч байна. Хөдөлмөрийн чадвараа *50-69%-аар алдсан 459/53%, 70-100% алдсан 410/47%* иргэн байна.

Хөдөлмөрийн чадвар алдалтыг сэтгэцийн эмгэг, дотрын өвчин, мэдрэлийн эмгэг, нүд, гэмтлийн эмгэгүүд эхний 5 байр буюу нийт хөдөлмөрийн чадвар алдалтын 80 хувийг эзэлж байгаа ба хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн *70 гаруй хувь нь 31-59 насны* хөдөлмөрийн насны иргэд байна.

Үйлдвэрлэлийн ослын шалтгаанаар хөдөлмөрийн чадвар алдсны тэтгэвэр авагч 22 даатгуулагч байдаг ба шинээр үйлдвэрлэлийн ослын улмаас хөдөлмөрийн чадвар алдалт тогтоогдоогүй.

Шинээр хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа, шалтгааныг тогтоолгож буй иргэний оношийг магадлах, биеийн байдлыг үнэлэх, мэдээлэл солилцох, цаашид тусламж үйлчилгээ, хяналтыг зөв чиглүүлэх, эмчлэн эрүүлжих зөвлөгөө өгөхөөр иргэнийг биеэр хуралд оролцуулж байна.

Мэдээллийн сангийн зөрүү гарахаас урдчилан сэргийлж нас барсан иргэдийн бүртгэлийг Эрүүл мэндийн төвийн дүн бүртгэлээс сар бүр авч, сан хоорондын хяналтыг улирал бүрээр тулгалт, хяналт хийдэг.

Эрүүл мэндийн магадлалтай холбоотой дүрэм, журмыг зөрчих, авлига, ашиг сонирхол, ёс зүйн аливаа алдаа дутагдал гарахаас урьдчилан сэргийлж ажилладаг.

Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлөөс Авлигатай тэмцэх газартай хамтран Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн гишүүдийн хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаарх

сургалтад зөвлөлийн гишүүдийг хамруулсан. Зөвлөлийн хурал эхлэхээс өмнө тухайн өдрийн хуралд хэлэлцүүлэх иргэдийн бүртгэлийг нарийн бичгийн дарга гишүүдэд танилцуулж, гишүүдээс хурлаар орж буй иргэнтэй ашиг сонирхолын зөрчилтэй тохиолдолд журмын дагуу маягт бөглөн зөвлөлийн даргаар шийдвэрлүүлэн ажиллаж хэвшсэн. Тухайн жилийн эхний хурал хуралдахад болон бүрэлдэхүүн өөрчлөгдөж шинэ гишүүн ажиллах тохиолдолд гишүүний үүрэгжилтийг танилцуулан гарын үсэг зуруулж хамтран ажилладаг. Тус үүрэгжилтэнд хурлаар орсон эмчийн танилцуулж буй иргэний хувийн эмзэг мэдээлэлийг нууцлан, аюулгүй байдлыг хангах тухай заалт орсон байдаг. ЭММЗ-ын хурлын үйл явцыг дүрс бичлэгт бичиж, хадгалдаг. Тайлант хугацаанд зөвлөлийн үйл ажиллагаа, гишүүдтэй холбоотой гомдол, зөрчил гараагүй.

Мэдээллийн ил тод байдал, сургалт мэдээлэл өгөх чиглэлээр:

Дүүргийн хөдөлмөрийн чадвар алдалтын жилийн эцсийн тоон мэдээ болон өвчлөлийн байдал, ангилал, хөдөлмөрийн чадвар алдсан иргэний ажилласан жил, нас, хүйс, хувь, хугацаа, тулгамдаж буй асуудал зэргээр дүүргийн Засаг дарга, Иргэдийн хурлын төлөөлөгчид болон холбогдох дарга, удирдлагуудад нээлттэй мэдээлэл хийж, дүүргийн ИТХ, ЗДТГ, байгуулллагын цахим хуудсанд 3 удаагийн мэдээлэл нийтлүүлж, ярилцлага өгсөн.



Засаг даргын тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэн хариуцсан мэргэжилтэн болон Эрүүл мэндийн төвийн Гэмтэл, Чих хамар хоолой, шүдний эмч нартай хамтран гэмтэл, чих хамар хоолойн өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдалт тогтоолгосон иргэдийн мэдээлэлд судалгаа, дүн шинжилгээ хийлээ. Судалгааны дүнг ЭММЗөвлөлд танилцуулж ажиллалаа. Судалгаагаар Багануур дүүргийн хувьд гэмтэл нь хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэж буй өвчлөлийн 3 дугаарт ордог бол чих, хамар хоолойн өвчин нь 6 дугаарт орж байна. Дээрх өвчний заалтаар хугацаагүй шийдвэртэй 70 иргэнийг дахин магадлалд хамруулж байна.

Дүүргийн эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдэд дүүргийн хөдөлмөрийн чадвар алдалтын тоон үзүүлэлт, эмнэлгийн хуудас олголтын журмын талаар мэдээлэл өгсөн. Эрүүл мэндийн магадлалын үйл ажиллагаа болон холбогдох дүрэм журмын талаарх иргэдийн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх чиглэлээр 5 удаагийн сургалт, мэдээлэл хийж 155 иргэнийг хамруулсан.

Зөвлөлийн хурлаар шинээр орж буй иргэн өөрийн биеэр хуралд ирдэг бөгөөд тэдгээр хүмүүст хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр тогтоолгох цахим хүсэлт илгээх зааварчилгаа, сайн дурын даатгалд хамрагдах тухай мэдээллийг багтаасан боршур хийж тарааж, зөвлөгөө мэдээлэл, чиглэл өгч ажиллаж байна.

Эрүүл мэндийн байгууллага, сувиллын үйл ажиллагааны хяналт, эмнэлгийн хуудасны бичилт, олголт , хяналт

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/177, А/433 хамтарсан тушаалаар батлагдсан Даатгуулагчид эмнэлгийн хуудас олгох журмыг баримтлан ажиллаж байна.

Эрүүл мэндийн байгууллагаас олгосон эмнэлгийн хуудсын жагсаалтыг сар бүр авч, 2 ба түүнээс дээш давтамжтай эмнэлгийн хуудас авсан, өндөр дүнгээр нийгмийн даатгал

төлдөг иргэн, эмнэлгийн хуудас их олгодог эмч, эмнэлгийн хуудас их бичүүлдэг аж ахуйн нэгжүүдийн эмнэлгийн хуудас олголтод хяналт хийж ажиллав. Тайлант хугацаанд 998 хөдөлмөрийн чадвар алдалт, 176 жирэмсэн амаржсаны эмнэлгийн хуудсаар хянаж, баталгаажуулсан. “Багануур” сувиллаас тусламж үйлчилгээ авсан 82 иргэний 984 ор хоногийн материалыг хянаж, сувиллын үйл ажиллагаанд хяналт хийж ажилласан.

Бүтээгдэхүүн шийдвэрлэлт системийн хэмжээнд хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас шийдвэрлэлт 1.66, ҮОМШӨ-ний хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас шийдвэрлэлт 3.27, жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудас шийдвэрлэлт 1.19 хоног буюу дундаж хоног 2.04 хоног байгаа бол тус дүүргийн магадлагч эмчийн эмнэлгийн хуудас шийдвэрлэлтийн ***дундаж хоног 0.51*** байна.

**https://sicos.ndaatgal.mn/#/core/insurance-products/finereport_ins_fine0121 2026.06.02**









Эрүүл мэндийн байгууллагын эмч нарыг хамруулж эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн үйл ажиллагаа, эмч нар хурлаар оруулахад анхаарах зүйлс, хяналтын эмчийн хариуцлага, эмнэлгийн хуудас олгох журам зэрэг тулгамдсан асуудлаар сургалт зохион байгуулж 40 гаруй эмчийг хамруулсан.

Үйлдвэрийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаанаар хөдөлмөрийн чадвар алдалттай иргэдэд сувиллын тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээтэй сувиллын нэрсийн жагсаалтыг байгууллагын болон дүүргийн 5 цахим хуудас, "Багануур" сувиллын цахим хуудсаар мэдээлж иргэд даатгуулагч, эмч мэргэжилтэн, "Нүүрэнтэйн Илч" төрийн бус байгууллагын ажилчдыг мэдээллээр хангалаа.

6.6.3.Ёс зүйн дэд хороо

Газрын дарга болон Ёс зүйн дэд хорооноос нийт албан хаагчдад ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор зөвлөгөө, мэдээллийг тогтмол хүргэж ажилладаг. Ингэснээр одоогоор иргэд даатгуулагчдаас ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээлэл ирээгүй болно. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтад тус газрын 16 албан хаагчийг хамрууллаа. Нийгмийн даатгалын ерөнхий газрын Ёс зүйн дэд хорооноос зохион байгуулах 4 удаагийн сургалтад оролцох албан хаагчдын нэрсийг гаргаж, 2 удаагийн 5 цагийн сургалтад давхардсан тоогоор тус газрын 19 албан хаагчийг хамрууллаа.

6.6.4. Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс

Хөдөлмөрийн тухай хуулийн биелэлтийг хангах, хуулийг сурталчлах ажлын хүрээнд хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталж ажилтан албан хаагчийн хөдөлмөрлөх нөхцөл бололцоог сайжруулах, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрт

хяналт тавин ажиллаж байна. Тус онд хөдөлмөрийн эрхтэй холбоотой нэг хүсэлт ирж, холбогдох хуулийн дагуу удирдлагад зөвлөгөө өгч ажиллаа.

6.6.5.Газрын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын

Баримт нягтлан шалгах комиссын 2026 оны 03 дугаар сарын 10-ны өдөр хуралдуулж, 1 асуудал, 2026 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр хуралдуулж, 2 асуудлыг тус тус шийдвэрлүүлж, баримтжуулав.

6.6.6.Өмч хамгаалах байнгын зөвлөл

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/27 тоот тушаалаар 2025 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг 2026 оны 01 дүгээр сарын 7-ны өдрөөс өмнө хийж гүйцэтгэсэн.
Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар 2026 оны улсын тооллогын комисс байгуулж одоогоор байгууллагын ажилтан албан хаагчдын өмчийг бүртгэлтэй тулган тоолж эхэлсэн байна.

6.6.7.Ахмадын зөвлөл

НДЕГ-аас ирүүлсэн 2026 оны 06/758 тоот Чиглэл хүргүүлэх тухай "Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.5-д “Төсвийн байгууллага ахмадын сангийн хөрөнгийг Төрийн сангийн дансанд байршуулна", 2026 оны төсөвт зардлын эдийн засгийн “Ахмадын сан” ангилалд батлагдсан төсвийг ахмадын сангийн дансанд төвлөрүүлж, тухайн данснаас зарцуулж байх" чиглэлийн дагуу 2026 оны батлагдсан төсвийн 3,0 сая төгрөгийг энэ оны 5 дугаар сард ахмадын санд байршуулсан. Тус газарт харъяалалтай 11 ахмадыг Монголын уламжлалт Цагаан сараар хүлээн авч хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулсан.

6.6.8.ХАБЭА-н зөвлөл

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтран  “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян”-ы хаалтын үйл ажиллагаанд оролцож дүүргийн аж ахуйн нэгж, байгууллагын ХАБЭА хариуцсан ажилтан, хүний нөөцийн мэргэжилтнүүдэд ажилчдын эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх, тэднийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт тогтмол хамруулж байх чиглэл өгч дүүргийн үйлдвэрийн осол болон халдварт бус өвчний өвчлөлийн үзүүлэлтээр мэдээлэл хийж ажиллалаа.

6.6.9.Гамшигаас хамгаалах штаб

Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж дүүргээс зохион байгуулсан гамшгийн бэлэн байдлын сургалт үйл ажиллагаанд оны эхний байдлаар 3 удаа оролцож өгсөн зөвлөмжийн дагуу ажиллаж байна.
6.6.10.Эцэг, эх, залуучуудын зөвлөл

Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолын дагуу хүүхэд хамгааллын бодлогыг баталж, хэрэгжүүлэх, ажилтан албан хаагчдад танилцуулж ажиллаж байна. Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн хүрээнд “Миний хүсдэг гэр бүл сэдэвт” гар зургийн уралдаан болон зохион бичлэгийн уралдаан зохион байгууллаа.






6.6.11.Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөл, биеийн тамир спортын хамтлаг

Нийт албан хаагчдын дунд өглөөний ажлын байрны дасгалыг тогтмол хийж хэвшсэн. Иогоор хичээллэдэг 2, агаарын теннисээр хичээллэдэг 3, уулын спортоор нэг албан хаагч нийт 6 албан хаагч спортоор хичээллэж байна. Мөн үйл ажиллагааны нягтлан бодогч Б.Наранцэцэг нь спортын олон төрөлд амжилттай оролцсон. Долоо хоног бүрийн пүрэв гарагт Багануур сувилал ХК-ийн хамт олонтой уурхайн зааланд хамтран сагс болон волейбол тоглодог. Дүүргээс зохион байгуулж буй спорт арга хэмжээнд төрийн захиргааны байгууллагуудтай хамтран баг бүрдүүлж оролцдог.

6.6.12. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зөрчил шалган шийдвэрлэх зөвлөл

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд тус зөвлөлөөс “Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй” үе тэнгийн дээрхэлт, түүний сөрөг үр дагаврын талаар Багануур дүүргийн 125 дугаар сургуулийн 5-1 ангийн 42 сурагчид мэдээлэл хүргэж, газрын фейсбүүк хуудсанд үе тэнгийн дээрхэлтийн талаар постер бэлтгэн орууллаа.

6.7.Ажилтан албан хаагчдын “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд”

Тус газар нь 2026 оны 05 сарын байдлаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны А/238 дугаар тушаалаар батлагдсан зохион байгуулалтын 3 хэлтэс, удирдах 4, гүйцэтгэх 14 нийт 18 албан хаагчтайгаар ажиллаж байна.



Хүний нөөцийн үзүүлэлтийг боловсролын зэрэг, жендер, насны ангилал, салбарт ажилласан хугацаагаар ангилан харуулбал дараах байдалтай байна.



**Боловсролын зэрэг:** Магистр 27%
Бакалавр 67%
Бүрэн дунд 6%



**Жендер**
Эрэгтэй 16%
Эмэгтэй 84%




**Салбарт ажилласан жил:**
5 хүртэл жил 38%
5-9 жил 24%
10-14 жил 27%
15-аас дээш жил 11%




**Насны ангилал:**
25-34 нас 33%
35-44 нас 33%
45-54 нас 34%

Тайлант хугацаанд орон тооны хэтрэлтгүй ажиллаж, хүний нөөцийн сарын 5 удаагийн мэдээг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн.

Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөний мэдээ

- хүүхдээ асарч байгаа - 1 албан хаагч
- тушаал дэвшсэн - 1 албан хаагч

Төрийн жинхэнэ албан хаагчдаас 8 байцаагч буюу 67% нь улсын байцаагчийн эрхтэй байна.

Тайлант хугацаанд хүний нөөцтэй холбоотой 14, бусад 12 нийт 26 төрлийн судалгааг гарган холбогдох байгууллагад хүргүүллээ.

Оны эхний хагас жилийн байдлаар нийт 3 албан хаагч төрийн шагналаар шагнагдсан. Үүнээс Хөдөлмөрийн хүндэт медалиар 2 албан хаагч, Эрүүл мэндийн яамны тэргүүнээр тус газрын магадлагч эмч мэргэжилтэн нар шагнагдсан.

6.8.Албан хаагчдыг мэргэшүүлэх ажлын хүрээнд

Албан хаагчдын мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх хүрээнд сургалтын хэрэгцээг тодорхойлж, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулсан. Үүний дагуу мэргэжлийн сургалтуудад үр дүнтэйгээр албан хаагчдыг чадавхжуулах, ур чадварыг дээшлүүлэх 60 удаагийн сургалтад давхардсан тоогоор 369 албан хаагчийг танхим болон цахимаар хамруулав.




Нийгмийн даатгалын байгууллагын Нийгмийн баталгаар хангах хөтөлбөрийн хүрээнд 31 ажил төлөвлөгдөж одоогоор 72%-н биелэлттэй байна.

6.9. Стресс менежмент хөтөлбөрийн хүрээнд

Нийгмийн даатгалын ерөнхий газраас “Стресс менежмент” сургалтыг 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдөр Аз жаргалтай ажлын байр сэдэвт сургалт орсон нийт 18 албан хаагч бүгд хамрагдсан. Нийт албан хаагчдыг сэтгэцийн эрүүл мэндийн үзлэгт нэг удаа хамруулсан.

Тус газрын 18 албан хаагчийг сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны үзлэгээр нойр дутмагшил 4 албан хаагчид, сэтгэцийн гүн түгшүүр 2 албан хаагчид илэрсэн. Нийт албан хаагчдын 85%-нь сэтгэцийн эрүүл мэнд сайн гэсэн үнэлгээтэй байсан.

Нийт албан хаагчдын 4 албан хаагч буюу 22%-д нойр дутагдлын доголдол илэрсэн.

Нийт албан хаагчдын 2 албан хаагч буюу 11% нь хурдан санах, мартах мэдрэлийн тогтолцооны эрхтний доголдол илэрсэн.

Дээрх сэтгэцийн эрүүл мэндийн судалгаануудын үр дүнд албан хаагч нарын эрүүл мэндийг хамгаалах олон улсын шинэ жишгийг нэвтрүүлэх шаардлага байгааг илтгэж байна. Мөн стресс тайлах энгийн арга, судалгаа, өөрийгөө танин мэдэх чиглэлээр шинжилгээний баг зөвлөгөө өгсөн.

## ДОЛОО.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ИРГЭДЭД ТАНИУЛАХ АЖЛЫН МЭДЭЭ

Тайлант хугацаанд хэрэгжүүлэх сургалт сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, батлуулан, мөн Захиргаа, хяналтын хэлтсийн төлөвлөгөөнд сургалт сурталчилгааны чиглэлээр хийх ажлуудыг тусгаж газрын даргаар батлуулан, мөрдөж хэрэгжилтийг ханган ажиллав.

7.1.Цахим сурталчилгаа

Багануур дүүргийн Нийгмийн даатгалын газар нь олон нийтийг Нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллээр хангах, сурталчлах зорилгоор 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 31-ны өдрийн хооронд албан ёсны Facebook хуудсаар нийт 28 нийтлэл байршуулсан. Эдгээр нийтлэл нийт 1,322,321 хандалт, 1,770 хариу үйлдэл, 175 сэтгэгдэл, 2,660 хуваалцал авсан байна. Мөн тус газрын зүгээс бэлтгэсэн 3 ширхэг рийлс/видео контент, “Багануурын мэдээ” веб сайтаар 1 нийтлэн олон нийтэд хүргэгдсэн ба фэйсбүүк хуудас 4600 дагагчтай болсон.




Тайлант хугацаанд зохион байгуулсан сургалтуудыг зорилтот бүлгийн онцлогт тохируулан дөрвөн үндсэн чиглэлд хуваан хэрэгжүүллээ. Хөтөлбөрийн дийлэнх хувийг ажил олгогч, аж ахуйн нэгжүүдэд чиглэсэн практик сургалтууд эзэлж байна. Энэ хүрээнд шимтгэлийн тайланг цахим системээр алдаагүй, шуурхай илгээх зааварчилгаа өгч, шимтгэл төлөлтөд гардаг нийтлэг алдааг хэрхэн засварлах практик арга зүйг олгосон юм. Ингэснээр аж ахуйн нэгжүүдийн тайлангийн чанар сайжирч, хугацаа хоцролтыг бууруулах, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх бодит суурь нөхцөл бүрдлээ.

Мөн нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр тусгай бүлгүүд болон ирээдүйн даатгуулагчдад зориулсан ажлуудыг шат дараатай зохион байгуулав. Сайн дурын даатгалын ач холбогдлыг сурталчлах ажлын хүрээнд дүүргийн 5 хорооны 231 малчин эмэгтэйчүүд болон Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, ажилчдыг чадавхжуулах сургалтад хамрууллаа. Үүний зэрэгцээ Оюуны Эрин, Гүн Галуутай, Боловсрол болон Мэргэжлийн боловсролын сургуулийн нийт 249 сурагч, залууст нийгмийн даатгалын суурь ойлголт өгөхийн зэрэгцээ үе тэнгийн дээрэлхэлтийн эсрэг соён гэгээрүүлэх мэдээллийг хослуулан хүргэсэн нь үр өгөөжтэй арга хэмжээ болов.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах чиглэлээр бодлогын чанартай сургалтуудыг амжилттай хэрэгжүүллээ. Тухайлбал, Багануур дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал,

эрүүл ахуйн (ХАБЭА) салбар зөвлөл болон эрсдэл өндөртэй ажлын байранд тооцогддог "Багануур Тохижилт" ААТҮГ-тай хамтран хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үйлдвэрлэлийн ослын шалтгаан нөхцөлийг таниулах сургалтуудыг дагнан зохион байгуулж, холбогдох зардлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж ажиллалаа.

Зохион байгуулсан 16 удаагийн сургалтад нийт 132 аж ахуйн нэгж, байгууллагын удирдах ажилтан, нягтлан бодогчид болон иргэд, оюутан сурагчдын төлөөлөл бүхий 1,071 даатгуулагч, иргэд хамрагдсан байна.



7.4.Callpro утсаар мэдээлэл, зөвлөгөө хүргэх

Тус газар нь 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дүгээр сарын 31-ны өдөр хүртэлх хугацаанд нийт 2,356 дуудлага хүлээн авсан бөгөөд үүнээс 193 дуудлага алдагдсан байна. Нийт дуудлагын 7.25%-ийг хүлээн авч чадаагүй бөгөөд дуудлага алдалтын түвшин 10% хүрээгүй, төлөвлөсөн хэмжээнд ажилласан болно.

7.5.Нийгмийн даатгалын үйлчилгээний сэтгэл ханамжийн судалгаа

Хагас жилийн тайлант хугацаанд нийгмийн даатгалын үйлчилгээний сэтгэл ханамж, цахим системийн ашиглалт болон ажил олгогч, даатгуулагчдад тулгарч буй хүндрэл бэрхшээлийг бодитой тодорхойлох зорилгоор судалгааны ажлыг зохион байгуулан ажиллалаа. Судалгаанд тус дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг нийт 93 аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, хүний нөөцийн менежер, санхүүгийн ажилтнуудыг хамруулан (portal.ndaatgal.mn) системийн ашиглалтын түвшин болон тайлан гаргах арга зүйн хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон. Мөн үйлчилгээ авсан 16 иргэн, даатгуулагчаас түүвэр судалгаа авч, үйлчилгээний чанар, хүртээмжийн талаарх санал, дүгнэлтийг нэгтгэн гаргалаа. Судалгааны үр дүнгээс үзэхэд (portal.ndaatgal.mn) системийн ашиглалт ерөнхийдөө жигдэрсэн хэдий ч байгууллагуудын шинэ нягтлан бодогчдыг сургах, тайлангийн алдаанаас сэргийлэх арга зүйн зөвлөгөө, практик сургалтын хэрэгцээ өндөр байгаа нь тогтоогдсон. Иргэдийн хувьд цахим үйлчилгээнд сэтгэл ханамж сайн байгаа ч мэдээллийн зөрүүг арилгах, цахимаар үйлчилгээ авах, хүсэлт илгээх зааварыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Үүнд үндэслэн цаашид ажил олгогчдод зориулсан

системийн практик сургалтыг шат дараатай зохион байгуулах, зааварчилгаа бүхий постер, видео хичээлийг цахим сувгаар түгээх, цахим болон танхимын үйлчилгээний уялдааг сайжруулах ажлуудыг дараагийн хагас жилд төлөвлөн хэрэгжүүлэхээр бэлтгэж байна.

## НАЙМ. ДҮҮРГИЙН ТӨР ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ДААЛГАСАН АЖЛЫН МЭДЭЭ

8.1.Албан бичиг, шийдвэрийн биелэлт, тайлагнал

Албан бичгийн шийдвэрлэлт: Тайлант хугацаанд Багануур дүүргийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газар (ЗДТГ)-аас ирүүлсэн нийт 55 албан бичгийг хүлээн авч, холбогдох зохицуулалтыг хийн, биелэлтийг бүрэн хангаж ажиллав.

Хөгжлийн төлөвлөгөөний тайлагнал: Дүүргийн Засаг даргын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд, 2026 оны хэрэгжилтийн явцын тайланг тогтоосон хугацаанд (улирал бүрийн сүүлчийн сарын 20-ны өдрөөр тасалбар болгон) 2 удаа бэлтгэж, хүргүүллээ.

Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт: Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 06, 07, 25 дугаар хуралдааны тэмдэглэл болон Ерөнхий сайдын 02 дугаар албан даалгаврын хэрэгжилтийн тайланг 2026 оны 03 дугаар сарын 20, 05 дугаар сарын 26-ны өдрүүдэд тус тус дүүргийн ЗДТГ-т албан ёсоор тайлагнасан.

8.2.Байгаль орчин, тохижилтын ажлын хүрээнд

"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн, "Бүх нийтээр мод тарих үндэсний өдөр":
Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 62 дугаар зарлиг, дүүргийн ЗДТГ-ын 2026 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн 08/525 дугаар албан бичгийг тус тус удирдлага болгов.
Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх заалтыг үндэслэн, байгууллага болон дүүргийн орчныг тохижуулах үйлсэд хувь нэмэр оруулж, нийт 18 ажилтны мөнгөн хандивыг (нэг ажилтнаас 15,000 төгрөгөөр тооцон) 270.0 мянган төгрөгийг Төрийн сан банкны 100200255204 тоот дансанд төвлөрүүлэв.

8.3.Тохижилт, нийтийн аж ахуйн ажлын хүрээнд

Байгууллагын гадаад орчинд нөхөн тарилт, арчилгаа: 2012 оноос хойш өөрийн эзэмшлийн талбайд монос, улиас, шинэс, гацуур зэрэг 12 төрлийн 400 орчим мод, сөөгийг жил бүр нэмж болон нөхөн тарьсан. Түүнчлэн, ойр орчмын нийтийн эзэмшлийн талбайд агч, хайлаас зэрэг 2 төрлийн 30 ширхэг модыг тарьж ургуулан, усалгаа болон агротехникийн арчилгааг тогтмол хийж байна.

Багануур дүүргийн ЗДТГ-ын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн удирдамж, чиглэлийн дагуу бүх нийтийн цас цэвэрлэгээнд 7 удаа, хог хаягдал цэвэрлэх арга хэмжээнд 2 удаа тус тус идэвхтэй оролцов.

Ажлын хүрээнд өөрийн болон нийтийн эзэмшлийн зам талбай, ногоон бүс, хотын төвийн хуваарьт талбайн цас, мөсийг арилгаж, хэлтсийн хашааны дотор, гаднах шар өвс, хог хаягдлыг цэвэрлэн, цонх, хашаа, хайс болон албан тасалгааны орчныг угааж, өнгө үзэмжийг сайжруулах ажлыг бүрэн гүйцэтгэлээ.

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХҮНИЙ НӨӨЦ, ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН А.УНДАРМАА

БАГАНУУР ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН

АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ

2025-2028 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2026 оны 06 дугаар сарын 10 Багануур дүүрэг

| № | Үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин 2026 оны эхний хагас жил | Хүрсэн түвшин | Хүрэх үр дүн буюу хэрэгжилт | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
| **Зорилт 1. Цалин хөлс, нэмэгдэл, шагнал урамшуулал, тэтгэвэр, тэтгэмж, мөнгөн урамшуулал, тусламж, дэмжлэгийг хуулийн хүрээнд үзүүлэх зорилтын хүрээнд** | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 1.1 Засгийн газрын баталсан цалингийн сүлжээг баримтлан албан хаагчдын цалинг тухай бүр шинэчлэн тогтоож олгох. | Цалингийн нэмэгдсэн хувь | +10% | Төрийн Захиргааны албан хаагчдын цалин нэмэгдсэн. | 60% | Засгийн газрын 2025 оны 12 дугаар Сарын 24-ний өдрийн 226 дугаар Тогтоолын 3 дугаар хавсралтад заасны дагуу газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/01 тушаалаар тус байгууллагад ажилладаг 12 төрийн захиргааны албан хаагчийн цалинг нэмэгдүүлсэн. Нийт 18 албан хаагчаас 12 хүний цалин нэмэгдсэн нь цалин нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 60%-н үзүүлэлттэй байна. 2026 оны эхний 5 сарын байдлаар 374.3 сая төгрөгийн цалин олгосон бол өмнөх оны мөн үед 373,7сая төгрөгийг олгож байсан. |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|---|
| 2 | Арга хэмжээ 1.2 Төрийн албан хаагчдын ур чадвар, ажлын үр дүн, туршлагыг үндэслэн шатлан дэвшүүлэх | Тушаал дэвшсэн албан хаагчийн тоо | - | Нэг албан хаагч тушаал дэвшсэн | 100% | Тус газрын хяналт, шалгалтын улсын байцаагч Х.Тогтвор нь тус газартаа 17 жил тасралтгүй ажиллаж газрын даргын 2026.05.25-ны өдрийн Б/08 тушаалаар Захиргаа, хяналтын хэлтсийн даргаар дэвшин ажиллаж байна. |
| 3 | Арга хэмжээ 1.3 Төрийн алба хаагчийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, улсын байцаагчийн мэргэшлийн зэргийг шинээр болон ахиулан олгох, Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл болон хөдөлмөрийн гэрээнд заагдсан нэмэгдэл болон бусад нэмэгдэл олгох асуудлыг тухай бүр шийдвэрлэх. | Зэрэг дэв, мэргэшлийн зэрэг нэмсэн албан хаагчдын тоо | 2 | Таван албан хаагчийн төрийн албаны зэрэг дэвд өөрчлөлт оруулахаар судалгаа хүргүүлсэн. | 100% | Тус газраас гурван албан хаагчийн зэрэг дэвийг нэмэгдүүлэхээр, 2 албан хаагчид зэрэг дэв шинээр олгуулахаар судалгааг нийгмийн даатгалын ерөнхий газарт 2026.05.26-ны өдөр хүргүүлсэн. |
| 4 | Арга хэмжээ 1.4 Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны нөхөх төлбөрийг эдийн засгийн байдалтай уялдуулан нэмэгдүүлэх олгох асуудлыг тухай бүр шийдвэрлэх | Цай, хоолны мөнгө нэмэгдсэн байна. | 25 мянга | 27 мянга | 100% | Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн А/26 дугаар тушаалаар хоол унааны мөнгө Багануур дүүрэгт 27 мянган төгрөг болсон. |
| 5 | Арга хэмжээ 1.5 Албан хаагчдад ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгохоос гадна бусад | Хагас жил, бүтэн жилээр албан хаагчдад мөнгөн | 59.7 сая | - | Төрийн албан хаагч тогтвор суурьшилтай | Хүлээгдэж байна. |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|---|
| | хэлбэрээр урамшуулах боломжийг судлан төсөвт багтаан шийдвэрлэх олгох. | урамшуулал олгогдсон байна. | | | ажиллах нөхцөл бүрдэж, ажиллах урам нэмэгдсэн байна. | |
| 6 | Арга хэмжээ 1.6 Хууль тогтоомжид нийцүүлэн төрийн дээд одон медаль, салбарын болон бусад байгууллагын шагналаар шагнах, гадаад, дотоод сургалтад хамруулах, мэргэшил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх зэргээр урамшуулах. | Шалгуур хангасан албан хаагчдыг хууль тогтоомжид нийцүүлэн шагнал, урамшуулал тодорхойлж, гадаад дотоод мэргэшил дээшлүүлэх сургалтад хамруулсан байх. | Тус газраас нийт 7 ажилтан шагнал авсан. | 3 албан хаагч шагнал авсан. | 100% | Тус газраас 8 албан хаагч, нэг ахмад настны шагналын судалгааг Дүүрэг болон НДЕГ-т хүргүүлсэн.<br>2026 оны 02 дугаар сард Хөдөлмөрийн хүндэт медалиар 2 албан хаагч, Эрүүл мэндийн салбарын тэргүүний ажилтнаар магадлагч эмч мэргэжилтэн Б.Балжинням нар шагнагдсан.<br>Монгол улсын Эрүүл мэндийн яамны 2026.05.07-ны өдрийн 6/2152 албан бичигт заасны дагуу Магадлагч эмч мэргэжилтэн Б.Балжиннямд газрын даргын 2026.05.08-ны Б/07 дугаар тушаалаар 2026.05.11-2026.05.15-ны хооронд мэргэшил дээшлүүлэх зорилгоор нийт ажлын 5 хоног цалинтай чөлөө олгосон. |
| 7 | Арга хэмжээ 1.7 Албан хаагчдын ээлжийн амралт, нөхөх төлбөр, тэтгэмж, буцалтгүй тусламж олгох асуудлыг Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн хууль бусад тогтоол, журам, шийдвэр, | Шалгуур хангасан албан хаагчдад Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн хууль, хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу ээлжийн амралт, | Нийт албан хаагчдийн 95% биеэр эдлүүлж, нэг албан хаагч биеэр ээлжийн | 100% | 86% | 2026 оны ээлжийн амралтыг нийт 1 ажилтан биеэр бүтэн эдэлж дуусаад байна. Байгууллагын тайлан төлөвлөгөө, байнгын үйл ажиллагаатай холбоотой ээлжийн амралтын дундуур ажиллуулах үзэгдэл байгаа ч хөдөлмөрийн хуульд заасны дагуу ээлжийн |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|---|
| | хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу шийдвэрлэх. | нөхөх төлбөр, тэтгэмж, буцалтгүй тусламж олгосон байх. | амралт эдэлж чадаагүй. | | | амралтыг хэсэгчлэн эдлүүлэхдээ нэг удаагийн амралтыг 10 хоногоос багагүй байлгах гэсэн зарчмыг ханган ажиллаж байна. 2025 оны ээлжийн амралтыг биеэр эдлээгүй албан хаагчийн ажилласан хугацааны цалинг олгосон ба цалингийн санд үндэслэн 1.5 дахин нэмэгдүүлж олгож чадаагүй.<br><br>Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргын 2019 оны А/31 дүгээр тушаалаар 16 хүртэлх насны хүүхдийн төрсөн өдөр тохиох бүрд ажилтанд 1 өдрийн цалинтай чөлөө олгохоор шийдвэрлэсэн. Энэхүү заалтаар тайлант хугацаанд 6 албан хаагчид 7 өдрийн цалинтай чөлөө олгов.<br><br>Хөдөлмөрийн дотоод журмын 7.2.7.Улсын болон Олон Улсын чанартай тэмцээн уралдаанд оролцох 16 хүртэлх насны хүүхдээ харгалзан дэмжиж явах албан хаагчид жилд 1 удаа ажлын 5 хүртэл хоногийн цалинтай чөлөө олгох гэж заасны дагуу газрын дарга Р.Өнөржаргалд 5 хоногийн цалинтай чөлөө олгов. |
| 8 | Арга хэмжээ 1.8 Нийгмийн даатгалын байгууллагаас өндөр | | 3.0 сая | 1.5 сая | 100% | НДЕГ-аас ирүүлсэн 2026 оны 06/758 тоот Чиглэл хүргүүлэх |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|---|
| | насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг нийгмийн баталгааг “Ахмадын сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам”-ын дагуу дэмжлэг үзүүлэх | Ахмад настны хуулиар тусгайлан сангийн мөнгөн хөрөнгө байршуулах, зарцуулах. | | | | тухай "Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.5-д “Төсвийн байгууллага ахмадын сангийн хөрөнгийг Төрийн сангийн дансанд байршуулна", 2026 оны төсөвт зардлын эдийн засгийн “Ахмадын сан” ангилалд батлагдсан төсвийг ахмадын сангийн дансанд төвлөрүүлж, тухайн данснаас зарцуулж байх" чиглэлийн дагуу 2026 оны батлагдсан төсвийн 3,0 сая төгрөгийг энэ оны 5 дугаар сард ахмадын санд байршуулсан. Тус газарт харъяалалтай 11 ахмадыг Монголын уламжлалт Цагаан сараар хүлээн авч хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгуулсан. |
| **Зорилт 2. Ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах, үр дүнтэй ажиллах нөхцөл бололцоог хангах зорилтын хүрээнд** | | | | | | |
| 9 | Арга хэмжээ 2.1 Байгууллагын ажиллах өрөө тасалгааны засвар, барилга байгууламжийг засварлах, ажлын байрны тохижилтыг орчин үеийн шаардлагад нийцсэн, стандартыг хангасан байдлаар тохижуулах, техник хэрэгсэл, тавилгаар хангах | Ажилтан, албан хаагч, үйлчлүүлэгчид ая тухтай очноор хангагдсан байх | - | Архивын өрөөний засварын ажил хийлгэж стандартад нийцсэн архивтай болох. | 70% | Тус газрын Архивын өрөөг тохижуулж стандартад нийцүүлэн дахин засварлах шаардлага гарсан тул 2026 онд төрийн өмчийн хорооны дүгнэлт гаргуулж, төсөв боловсруулан ажиллаж байна. |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг шат дараатай төлөвлөн тухай бүр шийдвэрлэн ажиллах; | | | | | |
| 10 | Арга хэмжээ 2.2 Ажлын байранд тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, стандартыг хангах; | Тав тухтай, эрүүл, аюулгүй ажиллах нөхцөл бүрдсэн байна. | 85% | 85% | 85% | Тус газраас ХАБЭА-н хүрээнд дотоод журмаа шинэчлэн, Нийгмийн даатгалын үйлчилгээний стандартыг ханган ажиллаж байна. |
| 11 | Арга хэмжээ 2.3 Шинэ тоног төхөөрөмж, технологийг нэвтрүүлэх, цаасгүй технологи бий болгох, шинэлэг үйлчилгээ нэвтрүүлэх арга замыг байнга эрэлхийлэх, нэвтрүүлэх; | Албан хаагчдын ур чадвар нэмэгдсэн байна. | Тэтгэвэр, тэтгэмжийн хүсэлтийг цахимаар 100% хүлээн авах. | 50% | 50% | Нийт газрын хэмжээнд цахимаар тэтгэмж, Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг 100% цахимаар авч байна.<br>Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа болон бусад судалгааг google forms -р гаргаж байна. |
| 12 | Арга хэмжээ 2.4 Ажилтнуудын үдийн амралт болон илүү цагаар ажиллах үед нь богино хугацаанд алжаал тайлах амрах орчинг нөөц боломждоо тулгуурлан бий болгох; | Ажиллах орчин, албан хаагчдын сэтгэл ханамж дээшилсэн байна. | 100% | 100% | 90% | Албан хаагчдын амралтын өрөөг гарган, гадаа талбайд цэцэрлэгжүүлэлт хийж, байгууллагын гадаад болон дотоод орчныг сайжруулан ажиллаж байна. |
| 13 | Арга хэмжээ 2.5 Төрийн албан хаагчдын нийгмийн хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагыг мэдэрч, | Байгууллагын соёл, хамт олны уур амьсгал, ажил хийх урам зориг дээшилсэн байна. | 2 | 1 | 70% | НДЕГ-с 2026 оны 02 дугаар сарын 04-ний өдөр “Аз жаргалтай ажлын байр сэдэвт” сургалтад нийт 18 албан хаагч орсон. |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагын соёл, хамт олны уур амьсгалыг эерэг болгох; | | | | | |
| 14 | Арга хэмжээ 2.6 Нөөц боломжид тулгуурлан ажилтан, албан хаагчдын хүүхдүүдэд зориулан өрөө эсвэл буланг гарган тохижуулах; | Албан хаагчдын гэр бүлийн амгалан байдал нэмэгдэж, тайван ажиллах нөхцөл бүрдсэн байна. | - | - | 70% | Тус газарт 2021 онд Дэлхийн зөн олон улсын байгууллагаас хүүхдийн буланг тохижуулан өгсөн бөгөөд одоогоор эцэг эхийн зөвлөл тус буланг хариуцан баяжуулалт хийж ажиллаж байна. |
| 15 | Арга хэмжээ 2.7 Эцэг эхийн зөвлөл, сонирхол, хөгжилд тулгуурласан спортын зөвлөл, сургалтын баг, залуучуудын зөвлөл, ахмадуудын зөвлөл гэх мэт хамт олны албан бус бүлэг, нэгдлийн санаачилгыг дэмжих, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх; | Хамтын ажиллагаа, багаар ажиллах чадвар, ажлын бүтээмж нэмэгдсэн байна.<br><br>Нийт зохион байгуулсан арга хэмжээний тоо. | 2 | 1 | 80% | Тус газарт эцэг, эх залуучуудын зөвлөл, Нийгмийн эрүүл мэнд спорт хамтлаг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх орон тооны бус 3 зөвлөл ажиллаж байна.<br><br>Эхний хагас жилийн байдлаар албан хаагчдын хүүхдүүдийн дунд гар зургийн уралдаан болон зохион бичлэгийн уралдааныг амжилттай зохион байгуулсан.<br><br>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Хүний нөөц, хуулийн мэргэжилтэн, Магадлагч эмч мэргэжилтэн нар Багануур дүүргийн 125 дугаар сургуулийн 5-1 ангийн 42 сурагчид Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй сэдвээр сургалт хийсэн. |
| 16 | Арга хэмжээ 2.8 Стресс менежемент болон харилцаа, хандлага, байгууллагын соёлыг | Албан хаагчдын сэтгэл санаа тайван болж, | 2 | 1 | 80% | Стресс менежмент хөтөлбөрийн хүрээнд 2025 онд гаргасан нийт албан хаагчдын дунд явуулсан |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|---|
| | төлөвшүүлэх, сургалт зохион байгуулах | ажиллах урам нэмэгдсэн байна.<br>Судалгааны тоо | | | | судалгаанд үндэслэн бүтээмж нэмэгдүүлэх, ажлын байрандаа тайван ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэхээр дэлхийн хүний нөөцийн судалгааны 3 том зохиол болох GOOGle-н Алтан дүрэм, Netflix-ийн Дүрэмгүй дүрэм, Dare to Lead номыг үндэслэн дээрх номын зарчмуудаас ажилтан албан хаагч дээрээ туршиж хэрэгжүүлж байна.<br>Дэлхийн хүний нөөцийн судалгаанд тулгуурлан:<br>1. Break time буюу 2 цаг ажил хийгээд 10 минут завсарлах цаг заавал гаргах,<br>2.Албан хаагчдаа мотивацжуулах , танин мэдэхгүйгээ тэлэх зэрэгт нь системтэйгээр тусалж ажиллах.<br>Мөн нийт газрын албан хаагчдыг сэтгэцийн эрүүл мэндийн үзлэг, зөвлөгөөнд хамруулсан. |
| **Зорилт 3. Амьдрах орчин нөхцөлийг сайжруулах зорилтын хүрээнд** | | | | | | |
| 17 | Арга хэмжээ 3.1 Төрийн албан хаагчдыг орон сууцны нөхцөлөө сайжруулах зорилгоор банкнаас зээл авах болон ипотекийн зээл | Амьдралын түвшин дээшилсэн байна. | Өөрийн орон байргүй нэг албан хаагч, Ипотекийн | - | 0% | Нийт газрын хэмжээнд орон байрны судалгааг гарган 3 албан хаагч Ипотекийн зээлд орохоор хүсэлт өгсөн ч одоо хүртэл шийдэгдээгүй удаашралтай байна. Багануур дүүрэгт |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|---|
| | авахад хамтран ажилладаг банктай холбон дэмжлэг үзүүлэх; | | хүсэлт өгсөн 3 албан хаагч | | | Ипотекийн зээлд хамрагдах боломж маш бага квоттой байна.<br>Тус газрын үйлчлэгч ажилтай М.Буд нь одоогоор өрх толгойлсон эх бөгөөд 13 болон 6 насны хоёр хүүхдийн хамт түрээсийн гэрт амьдарч байна. Иймд тухайн ажилтны орон байрны асуудлыг нэн тэргүүнд шийдэх шаардлагатай байна. |
| 18 | Арга хэмжээ 3.2 Шинээр гэр бүл болсон залуу гэр бүлд санхүүгийн болон бусад хэлбэрийн тусламж, дэмжлэг үзүүлэх. | Сэтгэл санаа болон санхүүгийн байдал дээшилсэн байна. | - | - | 0% | Хөдөлмөрийн дотоод журмын 8.2.3 -д шинээр гэр бүл болж буй албан хаагчид 1.0 сая төгрөг, хүүхэд төрүүлсэн бол 0.5 сая, ихэр хүүхэд төрүүлсэн бол 0.8 сая төгрөг өгөх заалт нэмж оруулсан. Одоогоор дээрх тэтгэмжүүдийг авсан албан хаагч байхгүй болно. |
| 19 | Арга хэмжээ 3.3 Тухайн жилийн батлагдсан төсвийн хүрээнд зарцуулагдаагүй зардлаас орон сууц, хашаа байшин худалдаж авахад дэмжлэг үзүүлэх, буцалтгүй тусламж, нэг удаагийн тусламжийн зардлаас орон сууц, хашаа байшин худалдаж авахад нь дэмжлэг үзүүлэх. | Амьдралын түвшин дээшилсэн байна. | - | - | 0% | Тухайн жилд олгосон мөнгөн дүн байхгүй. |
| **Зорилт 4. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маягийг хэвшүүлэх зорилтын хүрээнд** | | | | | | |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|---|
| 20 | Арга хэмжээ 4.1 Жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоонд хамруулах талаар арга хэмжээ авах, эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллах; | Эрүүл байх, эрүүл амьдрах хэв маяг, дадал зуршилтай болсон байна. | Албан хаагчдыг эрүүл мэндийн ерэнхий үзлэгт нэг удаа хамруулсан. | - | 78% | Төсвийн хэмнэлтийн тухай хуулиар жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нарийн мэргэжлийн эмчийн үзлэг, оношилгоонд хамруулах талаар арга хэмжээ авах, эрүүл мэндийн байгууллагатай гэрээ байгуулан хамтран ажиллах төсөв байхгүй тул хөдөлмөрийн дотоод журмын 7.2.9-д албан хаагч өөрийн хүсэлтээр үзлэг шинжилгээ, оношилгоонд хамрагдах бол жилд нэг удаа хоёр хүртэлх хоногоор цалинтай чөлөө олгохоор заасан. |
| 21 | Арга хэмжээ 4.2 Байгууллага, хамт олноороо аливаа хорт зуршлаас татгалзан, амьдралын зөв хэвшил, дадал, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх, санал санаачилгыг дэмжих, өрнүүлэх; | Хамт олонч сэтгэлгээ, багаар ажиллах дадал, зөв амьдралын хэв шинжтэй болсон байна. | Ажлын байрны тогмол дасгал хөдөлгөөн | - | 80% | Нийт албан хаагчдын дунд өглөөний ажлын байрны дасгалыг тогтмол хийж хэвшсэн. Иогоор хичээллэдэг 2, агаарын теннисээр хичээллэдэг 3, уулын спортоор нэг албан хаагч нийт 6 албан хаагч спортоор хичээллэж байна. Мөн үйл ажиллагааны нягтлан бодогч Б.Наранцэцэг нь спортын олон төрөлд амжилттай оролцсон. |
| 22 | Арга хэмжээ 4.3 Спорт, нийтийн биеийн тамирын хөтөлбөр, соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулах, зохион байгуулсан арга хэмжээнд идэвхтэй оролцох зэргээр хамт олны уур амьсгалыг зөв төлөвшүүлэх, албан хаагчдыг | Албан хаагчид үр бүтээлтэй, таатай амрах нөхцөл бүрдсэн байна. | Хамт олноороо сар болгон нэг өдөр заал авсан. | 16 | 80% | Долоо хоног бүрийн пүрэв гарагт Багануур сувилал ХК-ийн хамт олонтой уурхайн зааланд хамтран сагс болон волейбол тоглодог. Дүүргээс зохион байгуулж буй спорт арга хэмжээнд төрийн |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|---|
| | үр бүтээлтэй амрах таатай нөхцөлийг хангах; | | | | | захиргааны байгууллагуудтай хамтран баг бүрдүүлж оролцдог. |
| 23 | Арга хэмжээ 4.4 Эрүүл аж төрөх, чөлөөт цагаа ая тухтай өнгөрүүлэхийг дэмжиж жилд 1-ээс доошгүй удаа идэвхтэй амралт, аялал зохион байгуулах; | Хамт олны уур амьсгал дээшилсэн байна. | Жилд 2 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулдаг. | 1 | - | Хүлээгдэж байгаа |
| 24 | Арга хэмжээ 4.5 Дархлаажуулалтыг сайжруулах, витаминжуулах ажлыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулах; | Эрүүл амьдрал, зөв дадал, хандлагатай болсон байна. | 1 | 1 | 100% | Өвлийг угтан витаминжуулах аяныг тус онд үйл ажиллагааны нягтлан бодогч, бичиг хэрэг, дотоод асуудал хариуцсан ажилтан нар амжилттай зохион байгуулсан. |
| 25 | Арга хэмжээ 4.6 Жирэмсэн, амаржсан, хүүхэд асрах чөлөөтэй болон бусад шалтгаанаар чөлөөтэй албан хаагчдыг хамт олны аливаа арга хэмжээнд татан оролцуулах, хамруулахад санаачилгатай ажиллах; | Албан хаагчдын уур амьсгал өөрчлөгдсөн байна. | 2 удаагийн арга хэмжээнд заавал оруулах | 1 | 80% | Эцэг эх залуучуудын зөвлөлөөс хүүхэд асрах чөлөөтэй байгаа ажилтныг дэмжих хүрээнд хүүхдийн баярын арга хэмжээнд оролцуулсан. |
| 26 | Арга хэмжээ 4.7 Байгууллага хамт олноороо Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих, ногоон хөгжлийн талаарх соёлын арга хэмжээг дэмжиж, эерэг уур амьсгалыг бүрдүүлэх, үр | Эко амьдралын дадалтай болж, албан хаагчдын уур амьсгал өөрчлөгдсөн байна. | Жилд 2 удаа мод тарих, эсвэл тарих мөнгийг нь олгосон байна. | 1 | 100% | “Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих, ногоон хөгжлийн талаарх соёлын арга хэмжээг дэмжиж нэг удаа 270 мянган төгрөгийг төрийн сангийн дансанд тушаасан. |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|---|
| | бүтээлтэй, зөв боловсон өнгөрөөх; | | | | | |
| 27 | Арга хэмжээ 4.8 Байгууллага хамт олноороо ахмад настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тусламж дэмжлэг үзүүлэх болон нийгэмд чиглэсэн хүмүүнлэгийн ажилд оролцох. | Бусдад хандах хандлага эергээр өөрчлөгдсөн байна. | 2 удаагийн арга хэмжээнд оролцсон байна. | 1 | 80% | Үе тэнгийн дээрхэлтийг зогсоож Нийгэмд эерэг нөлөөлөл үзүүлэхээр тус газрын хуулийн мэргэжилтэн, магадлагч эмч мэргэжилтэн нар Багануур дүүргийн 125 дугаар сургуулийн 5-1 ангийн 42 хүүхдэд үе тэнгийн Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй талаар 30 минутын хичээл орсон. |
| **Зорилт 5. Төрийн албан хаагчийн нийгмийн хэрэгцээ, сэтгэл зүйн хандлагыг мэдэрч, байгууллагын соёл, хамт олны уур амьсгалыг өөрчлөх замаар албан хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжийг сайжруулах зорилтын хүрээнд** | | | | | | |
| 28 | Арга хэмжээ 5.1 Удирдах, гүйцэтгэх албан тушаалтны харилцаа, хандлагын хэв маягийг өөрчлөх замаар албан хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжийг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх; | Албан хаагчдын харилцаа, хандлага сайжирсан байна. | Сургалтын тоо 2 | 1 | 80% | Удирдах ажилтнуудын манлайллыг дээшлүүлэх, мэдээлэл түгээлтийг чанаржуулах, харилцаа хандлагаараа үлгэрлэх соёлыг төлөвшүүлэхийн тулд дээд шатны удирдлагаас чиглэсэн сургалт, сурталчилгааны ажил болон подкаст зэрэг контентуудыг тогтмолжуулж, нөлөөллийн үйл ажиллагааг эрчимжүүлэх саналтай байна.<br><br>Тус газрын дарга 2026 оны 03 дугаар сард НДЕГ-н удирдах ажилтны хуралдаанд оролцсон. |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|---|
| 29 | Арга хэмжээ 5.2 Байгууллагын дотоод нэгжүүдийн болон албан хаагчдын үйл ажиллагааны уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах; | Албан хаагчдын ажлын ачаалал, ажил үүргийн давхардал арилсан байна. | - | 1 | 50% | Монгол Улсын Их Хурлын 2025 оны “Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө батлах тухай” 48 дугаар тогтоолоор төрийн албаны шинэчлэлийг хийж, чиг үүргийн давхардлыг арилган, төрийн албан хаагчдын тоог 9 хувиар бууруулах замаар чадварлаг, цомхон, бүтээмжид суурилсан төрийн албыг бэхжүүлэхээр шийдвэрлэсэн. Энэхүү арга хэмжээний хүрээнд тус газраас 2 албан хаагч цомхотголд орсон бөгөөд ажлын ачаалал нэмэгдсэн байна. |

| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|---|
| 30 | Арга хэмжээ 5.3 Байгууллагын дотоод нэгжийн уур амьсгалыг сайжруулах, зөв боловсон соёлыг төлөвшүүлэх ажлыг дэмжиж, сайн туршлагыг дэлгэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх. | Албан хаагчдын харилцаа хандлага сайжирч, бусдад үлгэр дуурайл үзүүлсэн байна. | - | 1 | 80% | Дараах сайн туршлагыг нэвтрүүлж байна.<br>Удирдах ажилтнууд ажилчдын санал хүсэлт, шүүмжлэлийг хэдийд ч сонсоход бэлэн байх соёлыг хэвшүүлж, хүний нөөцийн ажилтан сар эсвэл улирал бүр ажилтан бүртэй ганцаарчилсан уулзалт хийж, зөвхөн ажлын гүйцэтгэл бус, тэдний сэтгэл зүй, тулгарч буй бэрхшээлийг сонсож хамт шийдэж, ажилчид нэрээ нууцлан байгууллагын соёл, уур амьсгалтай холбоотой шүүмж, саналыг чөлөөтэй хэлж илэрхийлж болох ажлын байрны сэтгэл ханамжийн судалгааг жилд 2 удаа авч ажиллаж байна. Үүний үр дүнд ажилтан албан хаагчдын харилцан хүндлэл өмнөх оныг бодвол харьцангуй сайжирсан байна. |
| **Зорилт 6. Мэргэжил, мэргэшлээ дээшлүүлэх сургалтад хамруулах зорилтын хүрээнд** | | | | | | |
| 31 | Арга хэмжээ 6.1 Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2025 оны А/296 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Нийгмийн | Сургалтын тоо | 284 | 60 | 70% | Нийт дээд газраас болон дүүрэг, бусад газраас зохион байгуулсан 60 удаагийн сургалтад нийт давхардсан тоогоор 369 албан |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | даатгалын байгууллагын сургалтын хөтөлбөр"-ийн дагуу нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдыг тасралтгүй сургах, мэргэшүүлэх. | Хамрагдсан албан хаагчдын тоо | 413 | 369 | | хаагч хамрагдсан байна. Нийт албан хаагчдын мэргэшлийн ур чадварыг нэмэгдүүлэх сургалтыг түлхүү оруулах шаардлагатай. Жишээ нь шилдэг залуу ажилчдын ур чадварыг урамшуулан мэргэшсэн нягтлан бодогчийн шалгалтад бэлтгэх сургалтын төлбөрийг нэг удаа төлөх гэх мэт арга хэмжээ нь албан хаагчдын хөгжлийг дэмжих, мэргэших зэрэгт ихээхэн түлхэц болно. |
| Гүйцэтгэлийн дундаж хувь | | | | | | 72% |

ХЯНАСАН:
ГАЗРЫН ДАРГА Р.ӨНӨРЖАРГАЛ

ТАЙЛАН БИЧСЭН:
ХҮНИЙ НӨӨЦ, ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН А.УНДАРМАА

9103538
2724010001
AMT05778